

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1-2
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	3-30
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	31-134
<hr/>	
<i>1.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/</i>	44-25
<i>2.Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх</i>	45-49
<i>3.Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	49-53
<i>4.“Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	53-62
<i>5.“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	62-69
<i>6.“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай” болон “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолуудын нэгтгэсэн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 12 гишүүн 2022.06.03-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл 2022.12.13-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	70-83
<i>7.Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	83-86
<i>8.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	86-87
<i>9.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	87-88

---

<b>10.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</b>	88-89
<b>11.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	89-101
<b>12.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	101-114
<b>13. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	115-121
<b>14.““Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</b>	121-122
<b>15.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилох тухай асуудал</b>	122-134

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр /Пүрэв гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Э.Батшугар, С.Ганбаатар, Х.Ганхуяг, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Сүхбаатар, Н.Учрал, Ж.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Анужин, С.Батболд;

Хоцорсон: С.Амарсайхан-41 минут, Ц.Анандбазар-04 минут, Ж.Батсуурь-53 минут, Б.Баярсайхан-06 минут, Х.Булгантуяа-03 минут, Н.Ганибал-03 минут, Т.Доржханд-02 минут, Л.Мөнхбаатар-01 минут, Ц.Мөнх-Оргил-02 минут, Ц.Мөнхцэцэг-02 минут, С.Одонтуяа-02 минут, М.Оюунчимэг-12 минут, Д.Өнөрболор-08 минут, Д.Сарангэрэл-1 цаг 29 минут, Ц.Туваан-03 минут, Б.Чойжилсүрэн-14 минут, Л.Энх-Амгалан-14 минут, Н.Энхболд-05 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, А.Адъяасүрэн, О.Цогтгэрэл, Ш.Адъяаа, Ч.Хүрэлбаатар, Х.Болорчулуун, Т.Доржханд, Д.Ганбат нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм нарын 6 гишүүн 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./10:11/

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, А.Адъяасүрэн, О.Цогтгэрэл, Ч.Хүрэлбаатар, Д.Ганбат, Ш.Адъяаа, Т.Доржханд, Х.Болорчулуун нар үг хэлэв.

**Нэг.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Н.Ганибал завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 3 өдрийн завсарлага өгөв./11:00/

*Уг асуудлыг 11 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 17

Бүгд: 49

65.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Х.Итгэл, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Я.Мөнхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 18

Бүгд: 48

62.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга Л.Өлзийбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын дарга Ц.Нямбаяр, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Г.Ганболд, Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	40
Татгалзсан:	11
Бүгд:	51

78.4 хувийн саналаар хууль батлагдлаа.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хууль эцэслэн баталсанд тооцов.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав.*

*Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:11/*

*Уг асуудлыг 12 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.*

**Тав.** “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга Л.Өлзийбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын дарга Ц.Нямбаяр, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг, Д.Өнөрболор, Н.Ганибал нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян нар хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	42
Татгалзсан:	11
Бүгд:	53

79.2 хувийн саналаар хууль батлагдлаа.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:37/

Уг асуудлыг 12 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.



*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хэлэлцэх асуудлын зургаадугаар асуудал болох Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг Засгийн газрын гишүүн байхгүй байгаа тул түр хойшлуулсныг мэдэгдэв. /12:40/*

***Зургаа. “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай” болон “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолуудын нэгтгэсэн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 12 гишүүн 2022.06.03-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл 2022.12.13-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Мөнх-Оргил, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Баттөмөр, Ж.Батжаргал, Ц.Даваасүрэн, О.Цогтгэрэл нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай” болон “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолуудын нэгтгэсэн төслийг гүйцээн боловсруулах чиглэл өгч, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн

тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Хуулийн зөвлөх, өмгөөлөгч П.Баттулга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч /хуулийн зөвлөх/ Г.Оюунболд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Гэр бүл, хүүхэд хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Чинбат, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Амарбаясгалан, Монгол Улсын Их сургуулийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш, дэд профессор, доктор А.Батхишиг, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга П.Болормаа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжээч Б.Дуламсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хорооны мэргэжилтэн А.Уранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын референт Г.Нямсүрэн, Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

### **Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “орон нутгийн байгууллага,” гэсний дараа “хамтарсан баг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 18  
Бүгд: 42  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын, 36 дугаар зүйлийн 36.2.4 дэх заалтын “тохиолдлын зохицуулалт” гэснийг, мөн зүйлийн 36.2.5 дахь заалтын “тохиолдол” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 18  
Бүгд: 42  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 25 дугаар зүйлийн 4 дэх тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэ зүйлд заасан “цахимаар дарамтлах” гэж хүний хувийн болон эмзэг мэдээллийг ашиглан цахим орчинд хүүхдэд түгшүүр төрүүлэх, шахалт үзүүлэх үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 19  
Бүгд: 42  
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

***Найм.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Хуулийн зөвлөх, өмгөөлөгч П.Баттулга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч /хуулийн зөвлөх/ Г.Оюунболд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Гэр бүл, хүүхэд хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Чинбат, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Амарбаясгалан, Монгол Улсын Их сургуулийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш, дэд профессор, доктор А.Батхишиг, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга П.Болормаа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжээч Б.Дуламсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хорооны мэргэжилтэн А.Уранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын референт Г.Нямсүрэн, Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооноос гаргасан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 17  
Бүгд: 43  
60.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

**Ес.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Хуулийн зөвлөх, өмгөөлөгч П.Баттулга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч /хуулийн зөвлөх/ Г.Оюунболд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Гэр бүл, хүүхэд хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Чинбат, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Амарбаясгалан, Монгол Улсын Их сургуулийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш, дэд профессор, доктор А.Батхишиг, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга П.Болормаа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжээч Б.Дуламсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хорооны мэргэжилтэн А.Уранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын референт Г.Нямсүрэн, Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооноос гаргасан Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 13  
Бүгд: 46  
71.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

***Арав.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Хуулийн зөвлөх, өмгөөлөгч П.Баттулга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч /хуулийн зөвлөх/ Г.Оюунболд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Гэр бүл, хүүхэд хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Чинбат, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Амарбаясгалан, Монгол Улсын Их сургуулийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш, дэд профессор, доктор А.Батхишиг, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга П.Болормаа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжээч Б.Дуламсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хорооны мэргэжилтэн А.Уранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын референт Г.Нямсүрэн, Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооноос гаргасан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 18

Бүгд: 46

60.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

**Арваннэг. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, мөн хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгорсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, ахлах референт Н.Энхбаатар, А.Нинжин, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Н.Ундраа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ч.Хүрэлбаатар, Х.Баделхан нарын тавьсан асуултад Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19

Бүгд: 43  
55.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

*Арванхоёр. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, М.Пүрэвсүрэн, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.Галбадар, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга Б.Батсуурь, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Д.Энхтөр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль, тогтоомжийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч асан, өмгөөлөгч Д.Батсүх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн нар хариулж, тайлбар хийв.

*Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 2.2 дугаар зүйлийн 10, 11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.Энэ хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тухай прокурорын саналыг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.

11.Энэ хуулийн 31.5 дугаар зүйлд заасны дагуу сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан тухай мөрдөгчийн шийдвэрийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх, хэрэв баривчлагдсан сэжигтнийг 24 цагийн дотор уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд хүргэх боломжгүй бол баривчлах ажиллагаа явагдсан газрын шүүх хянан шийдвэрлэнэ.” гэсэн 2 дахь өгүүлбэрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 21

Бүгд: 44

52.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Шүүх энэ хуулийн” гэсний дараа “14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5 дахь заалт,” гэж нэмж, 3.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 17

Бүгд: 41

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 14.10 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “5 хоногийн өмнө” гэснийг “7-оос доошгүй хоногийн өмнө” гэж, 8 дахь хэсгийн “4 хоногийн өмнө” гэснийг “4-өөс доошгүй хоногийн өмнө” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 14.10 дугаар зүйлийн Тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11, 12 дахь хэсэг болгох:

“11.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүгдэгчид урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, цагдан хорих хугацааг сунгахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж дуустал цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

12.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаа нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй.” хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.



Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 17.2 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Прокурор, мөрдөгч яллагдагчид энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан эрх, үүргээс гадна дараах эрхийг тусгайлан танилцуулна:

6.1.тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар мэдээлэл авах;

6.2.прокурорын санал болгосон эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах;

6.3.эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар өөрийн саналыг илэрхийлэх;

6.4.шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээс татгалзах.

7.Прокурор хохирогчид энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг мэдэгдэж, хохирол нөхөн төлөх талаар яллагдагчийн гаргасан санал болон энэ хуулийн Наймдугаар бүлэгт заасан эрх, үүргийг тусгайлан танилцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 17.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсгийн “хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй” гэснийг “ердийн журмаар хянан шийдвэрлэнэ” гэж тус тус өөрчилж, 17.2 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн “Эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн нь” гэсний дараа “мөрдөн шалгах ажиллагааны явцад” гэж нэмж, 17.2 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 17

Бүгд: 41

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 17.3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтын “тохиролцоо хийгдсэн огноо” гэснийг “прокурорын санал танилцуулсан он, сар, өдөр” гэж өөрчилж, 17.3 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Прокурор яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийг харьяалах шүүхэд шилжүүлсэн тухай яллагдагч, хохирогч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 18  
Бүгд: 41  
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 22  
Бүгд: 42  
47.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 19  
Бүгд: 42  
54.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 17.3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтын “тохиролцоо хийгдсэн огноо” гэснийг “прокурорын санал танилцуулсан он, сар, өдөр” гэж өөрчилж, 17.3 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Прокурор яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийг харьяалах шүүхэд шилжүүлсэн тухай яллагдагч, хохирогч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 19  
Бүгд: 42  
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй гэж үзвэл” гэснийг хасаж, 14.9 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “оргон зайлсан” гэсний өмнө “эсхүл” гэж, 14.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “саналыг үндэслэн” гэсний дараа “шүүх” гэж тус тус нэмж, 14.9 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтын “сүрдүүлсэн” гэснийг “эсхүл сүрдүүлсэн, эсхүл нөлөөлсөн” гэж, 14.9 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтын “1.1, 1.3-т”

гэснийг “1.1, 1.2, 1.3-т” гэж тус тус өөрчилж, 14.9 дүгээр зүйлийн 2.3, 2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2.3, 2.4, 2.5 дахь заалт болгох:

“2.3.зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт хамтран оролцсон;

2.4.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

2.5.Монгол Улсад байнга оршин суудаггүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 20  
Бүгд: 42  
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 17.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “талууд” гэснийг “прокурор” гэж, “тохиолдолд” гэснийг “үндэслэлээр” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 19  
Бүгд: 43  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 31.5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

### **“31.5 дугаар зүйл.Сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах**

1.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг дараах үндэслэлээр хойшлуулшгүйгээр баривчилж болно:

1.1.гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь, эсхүл гэмт хэрэг үйлдсэн газраас зугтах үед барьсан;

1.2.гэмт хэрэг үйлдсэн даруй гэрч, хохирогч шууд заасан;

1.3.хэргийн газарт болон тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд ул мөр илэрсэн.

2.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол хойшлуулшгүйгээр баривчилж болно:

2.1.хэн болох нь тогтоогдоогүй;

2.2.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

2.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй.

3.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн даруй энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэл бүхий сэжиг тогтоогдвол сэжигтнийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан аль нэг үндэслэлээр хойшлуулшгүйгээр баривчилж болно.

4.Мөрдөгч сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор баривчлах ажиллагаа хуульд нийцсэн эсэхийг хянаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

4.1.мөрдөгчийн шийдвэрийг баталж, шүүхэд даруй хүргүүлэх;

4.2.мөрдөгчийн шийдвэрийг үндэслэлгүй, эсхүл үргэлжлүүлэн баривчлах шаардлагагүй гэж үзвэл батлахаас татгалзаж, тэмдэглэл үйлдэх.

5.Үндэслэлгүйгээр баривчлагдсан сэжигтнийг прокурор даруй суллана.

6.Мөрдөгч энэ хуулийн 30.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлтэй бол хойшлуулшгүйгээр баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналаа сэжигтнийг баривчилснаас хойш прокурорт даруй хүргүүлнэ.

7.Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 6 цагийн дотор баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэнэ.

8.Прокурор сэжигтнийг баривчилсан шийдвэрийг хүчинтэйд тооцуулах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналаа баривчлах хугацаа дуусахаас 24 цагийн өмнө шүүхэд хүргүүлнэ.

9.Шүүх энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан прокурорын саналыг хүлээн авснаас хойш даруй, эсхүл 24 цагийн дотор шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, прокурорын саналыг үндэслэн баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох, яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг хянан шийдвэрлэнэ.

10.Прокурор, эсхүл баривчлах байрны даргын шийдвэрээр суллагдсан сэжигтэн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд баривчлах ажиллагааны талаар сэжигтнийг суллагдсанаас хойш 10 хоногийн дотор гомдол гаргаж болно. Прокурор гомдолд холбогдох материалыг харьяалах шүүхэд даруй хүргүүлнэ.

11.Шүүх энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг хянан шийдвэрлэнэ. Энэ шийдвэрт гомдол гаргахгүй.

12.Энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасны дагуу суллагдсан хүн гомдол гаргаагүй бол холбогдох шийдвэрийг 30 хоногийн дотор харьяалах шүүхэд хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ж.Батжаргал, Б.Энхбаяр, Ц.Мөнх-Оргил нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 18  
Бүгд: 43  
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “15.8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч” гэснийг “давж заалдах шатны шүүх” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 20  
Бүгд: 43  
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасаж, 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт болгох:

**“5/31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Мөрдөгч сэжигтнийг баривчлах үед түүнийг ямар хэрэгт холбогдуулан баривчилж байгаа талаар мэдэгдэж, энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг сануулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 19  
Бүгд: 43  
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн” гэснийг хасаж, 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт болгох:

**“6/31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэрийг танилцуулсан, эсхүл хойшлуулшгүйгээр баривчилсан тохиолдолд энэ хуулийн 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг танилцуулсан үеэс баривчилсан хугацааг тоолох бөгөөд сэжигтнийг мөрдөн шалгах байгууллагад хүргэх, зайлшгүй эмнэлгийн туслалцаа үзүүлэх, эрүүлжүүлэх, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзахад зарцуулсан хугацааг энэ хуулийн 31.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан хугацаанд оруулан тооцохгүй. Өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах хугацаа 1 цагаас илүүгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 20  
Бүгд: 43  
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс

дараалал, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжэе гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 16  
Бүгд: 43  
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.*

***Арвангурав.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга Ч.Оюунцэцэг, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Б.Ундрах, мөн зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, мөн хэлтсийн шинжээч М.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

### **Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1, 2 дугаар зүйл болгох:

**“1 дүгээр зүйл.**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай Долдугаар<sup>1</sup> бүлэг нэмсүгэй:

**“ДОЛДУГААР<sup>1</sup> БҮЛЭГ**  
**Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа**

**75<sup>1</sup> дүгээр зүйл.**Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг

75<sup>1</sup>.1.Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75<sup>1</sup>.1.1.бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах;

75<sup>1</sup>.1.2.дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах;

75<sup>1</sup>.1.3.хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах;

75<sup>1</sup>.1.4.бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах.

75<sup>1</sup>.2.Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75<sup>1</sup>.2.1.шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;

75<sup>1</sup>.2.2.энэ хуулийн 75<sup>1</sup>.1.1-д заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;

75<sup>1</sup>.2.3.ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл.

75<sup>1</sup>.3.Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглоно.

75<sup>1</sup>.4.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон журмын дагуу шийдвэрлэнэ.

75<sup>1</sup>.5.Гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

**75<sup>2</sup> дугаар зүйл.**Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх  
**зарчим, хугацаа**

75<sup>2</sup>.1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.

75<sup>2</sup>.2.Зохигч шүүх хуралдаанаас өмнө, энэ бүлэгт заасан хугацааны дотор өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

75<sup>2</sup>.3.Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

75<sup>2</sup>.4.Энэ хуулийн 75<sup>2</sup>.3-т заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

### **75<sup>3</sup> дугаар зүйл.Хэрэг үүсгэх, нэхэмжлэл гардуулах**

75<sup>3</sup>.1.Шүүгч энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлага хангагдсан бөгөөд энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

75<sup>3</sup>.2.Энэ хуулийн 75<sup>4</sup> дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, эрх, үүргийн тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 75<sup>4</sup>.4-т заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсанд тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

75<sup>3</sup>.3.Нэхэмжлэл, хариу тайлбар, хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална.

### **75<sup>4</sup> дүгээр зүйл.Мэдэгдэх хуудсыг хүргүүлэх**

75<sup>4</sup>.1.Шүүх энэ хуулийн 77.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол хариуцагч иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар, эсхүл регистрийн дугаарыг мэдээлсэн нэхэмжлэлийн тухайд албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

75<sup>4</sup>.2.Энэ хуулийн 75<sup>4</sup>.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч уг хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний болон хуулийн этгээдийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ.

75<sup>4</sup>.3.Энэ хуулийн 75<sup>4</sup>.2-т заасан цахим шуудангийн хаягаас гадна хариуцагчийн албаны болон хувийн цахим шуудангийн хаягийн мэдээллийг нэхэмжлэлд тусгасан бол эдгээр хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг давхар илгээнэ.

75<sup>4</sup>.4.Энэ хуулийн 75<sup>4</sup>.2, 75<sup>4</sup>.3-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.



### **75<sup>5</sup> дугаар зүйл.Хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, гуравдагч этгээд оролцох**

75<sup>5</sup>.1.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэгтгэх, тусгаарлах, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд, хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагч татан оролцуулах ажиллагаа хийгдэхгүй.

75<sup>5</sup>.2.Хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш 7 хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргаж болно.

75<sup>5</sup>.3.Сөрөг нэхэмжлэл энэ хуулийн 73, 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

75<sup>5</sup>.4.Зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.

75<sup>5</sup>.5.Нэхэмжлэгч иргэний хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлага, үндсэн нэхэмжлэлд заасан үндэслэлийн хүрээнд нэхэмжлэлийн шаардлагаа нэг удаа нэмэгдүүлж болно. Нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлснийг хэргийн оролцогчид мэдэгдэнэ.

75<sup>5</sup>.6.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр оролцож болно.

### **75<sup>6</sup> дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг**

75<sup>6</sup>.1.Гэрч энэ хуулийн 43.3-т заасан эрх, үүргийг ойлгосны үндсэн дээр үнэн зөв мэдүүлснээ илэрхийлэн, нотариатаар гэрчлүүлсэн мэдүүлгийг шүүхэд ирүүлсэн нь хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75<sup>6</sup>.2.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтай гэрч, шүүгч, зохигч нэгэн зэрэг холбогдон авсан гэрчийн мэдүүлгийг хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75<sup>6</sup>.3.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлсэн нь гэрчийн мэдүүлгийг энэ хуулийн 75<sup>6</sup>.2-т заасны дагуу үнэлэхэд саад болохгүй.

### **75<sup>7</sup> дугаар зүйл.Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх**

75<sup>7</sup>.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш дараах нөхцөл байдал тогтоогдвол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ:

75<sup>7</sup>.1.1.нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасныг зөрчсөн;

75<sup>7</sup>.1.2.тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн.

75<sup>7</sup>.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.

75<sup>7</sup>.3.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс тогтоосон тов ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хүчинтэй хэвээр байна.

75<sup>7</sup>.4.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр үргэлжлүүлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолох үндэслэл болохгүй.

#### **75<sup>8</sup> дугаар зүйл.Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх**

75<sup>8</sup>.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш энэ хуулийн 74.1-д заасан үндэслэл бүрдвэл хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

#### **75<sup>9</sup> дүгээр зүйл.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр**

75<sup>9</sup>.1.Энэ хуулийн 75<sup>7</sup>.1-д зааснаас бусад тохиолдолд шүүх энэ хуулийн 75<sup>1</sup>.1, 75<sup>1</sup>.2-т заасан шүүх хуралдаанаас шийдвэр гаргана.

75<sup>9</sup>.2.Энэ хуулийн 75<sup>9</sup>.1-д заасан шийдвэр нь удиртгал, үндэслэх, тогтоох хэсэгтэй байх бөгөөд үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, шийдвэрийн үндэслэлийн товч агуулгыг дурдана.

75<sup>9</sup>.3.Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ хуулийн 75<sup>3</sup>.2-т заасны дагуу зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулна.

75<sup>9</sup>.4.Энэ хуулийн 75<sup>9</sup>.2 дахь хэсэг давж заалдах шатны шүүхийн магадлалд нэгэн адил үйлчилнэ. Шийдвэр, магадлалын бүтэц, боловсруулах аргачлалыг Улсын дээд шүүх батална.

#### **75<sup>10</sup> дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр нэмэлт хугацаа тогтоох, хуваарь гарган хэсэгчлэн төлөх**

75<sup>10</sup>.1.Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн, эсхүл хэсэгчлэн хангасан бол хариуцагчийн санхүүгийн байдал, харгалзвал зохих бусад зайлшгүй шалтгаанаар, хариуцагчийн хүсэлтэд үндэслэн шийдвэрийг биелүүлэх нэмэлт хугацаа тогтоох, эсхүл хуваарийн дагуу хэсэгчлэн төлөхөөр шүүхийн шийдвэрт зааж болно. Нэмэлт хугацаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш зургаан сараас илүүгүй байна.

#### **75<sup>11</sup> дүгээр зүйл.Давж заалдах гомдол гаргах**

75<sup>11</sup>.1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75<sup>9</sup>.3-т заасны дагуу гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

75<sup>11</sup>.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

**Арвандөрөв.** ““Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Төгсцэнгэл нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар ““Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	17
Бүгд:	41

58.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ““Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:38/

*Уг асуудлыг 16 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

**Арвантав.** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Ж.Дэлгэрсайхан, Р.Ринчинбазар, Н.Ууганбаатар, Л.Гангэрэл, Л.Отгонтуяа, А.Энхбат, Н.Энхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийг томилох тухай Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Нэр дэвшигч болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, М.Оюунчимэг, Д.Өнөрболор нарын тавьсан асуултад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Ж.Дэлгэрсайхан, Р.Ринчинбазар, Н.Ууганбаатар, Л.Гангэрэл, Л.Отгонтуяа, А.Энхбат, Н.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

*Нэр дэвшигчийг томилох саналыг нууц санал хураалтаар явуулав.*

**Г.Занданшатар:** Намжилдоржийн Энхбаярыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 18  
Бүгд: 42  
57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Жамсрандоржийн Дэлгэрсайханыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 18  
Бүгд: 42  
57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Нинжбатын Ууганбаатарыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 19  
Бүгд: 42  
54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Амаржаргалын Энхбатыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 19  
Бүгд: 42  
54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Равсалын Ринчинбазарыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 19  
Бүгд: 42  
54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Ланганы Отгонтуяаг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 21  
Бүгд: 42  
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 17  
Бүгд: 41  
58.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Ланганы Отгонтуяаг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн дахин санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 17  
Бүгд: 41  
58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Лхагважавын Гангэрэлийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 17  
Бүгд: 41  
58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.*

*Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:15/*

*Уг асуудлыг 17 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

***Арванзургаа. “Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.10.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, хаалттай/***

*Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 17 цаг 20 минутаас хаалттай горимоор дээрх тогтоолын төслийг хэлэлцэв.*

*Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 17 цаг 42 минутад нээлттэй горимд шилжиж, 17 цаг 43 минутад хуралдаан өндөрлөв.*

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын урилгаар Өмнөговь аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 1992 оны төгсөгчид, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн алба хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Б.Чойжилсүрэн, Ч.Хүрэлбаатар нарын урилгаар Увс аймгийн Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Т.Энхтүвшин нарын урилгаар Дорноговь аймгийн Сайншанд сум дахь Улаанбаатар төмөр замын Барилга, үйлчилгээний 3 дугаар ангийн ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Орхон аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн урилгаар Компьютерийн техник, менежментийн сургуулийн 1998 оны төгсөгчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшиний урилгаар Хан-Уул дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ж.Батжаргал нарын урилгаар Төв аймгийн Онцгой байдлын ерөнхий газрын албан хаагчид болон ахмадуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн урилгаар Говь-Алтай аймгийн Шарга сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар нээлттэй горимоор 15 асуудал, хаалттай горимоор 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 6 цаг 31 минут үргэлжилж, 72 гишүүнээс 61 гишүүн хүрэлцэн ирж, 84.8 хувийн ирцтэйгээр 17 цаг 43 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

**МОНГОЛ УЛСЫН ИХ**  
2024 оны 01 дүгээр сарын 11-ний  
өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай”  
танхим  
10 цаг 05 минут  
**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ**  
**ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 18 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлж хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Иргэний нисэхийн тухай хууль, хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Төмөр замын тээврийн тухай хууль хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ. Энэ Бямбацогт сайд, Засгийн газар, Тамгын газар анхаараарай. Үүнийг чинь хэрэгжилтийн хугацаа чинь эхлээд тоологдохсон байгаа шүү дээ. Түүнийг яах ёстой юм?

Дөрөвдүгээрт, Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл, соёрхон батална.

Тавдугаарт, Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Соёрхон батална. 39, энэ нийт гишүүний олонхоор энэ хуулиудыг эцэслэн батлах байгаа.

Зургаадугаарт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Долоодугаарт, “Төрийн ба орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай” болон “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолуудын нэгтгэсэн төслийг хэлэлцэнэ. Энэ бол Дамдины Цогтбаатар нарын 12 гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын гишүүдийн өргөн мэдүүлсэн 2 тогтоолын төслийг нийлүүлж хэлэлцэнэ.

Наймдугаарт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Есдүгээрт, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Аравдугаарт, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэнэ.

Арваннэгт, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийн эцсийн найруулгатай, төсөлтэй холбогдуулж боловсруулсан анхны хэлэлцүүлэг явуулна.

Арванхоёрт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.



Арвангуравт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Арвандөрөвт, “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Арвантав.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх, томилох тухай асуудал.

Арванзургаа.”Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Арвандолоо.”Бүгд найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Арваннайв, Элчин сайд нарыг эргүүлэн татах, томилох тухай зөвшилцөх асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт, Бөхчулууны Пүрэвдорж, Амгалангийн Адъяасүрэн, Одонгийн Цогтгэрэл, Ширнэнбаньдийн Адьяаа, Чимэдийн Хүрэлбаатар, Хаянгаагийн Болорчулуун, Тогмидын Доржханд, Дашдондогийн Ганбат нараас албан бичиг ирүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23-д хууль, тогтоолын төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагч хууль тогтоолын төслөө татан авах үндэслэл бүхий үндэслэлээ тусгасан албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хууль, тогтоолын төслөө татан авсанд тооцно гэж заасан.

Энэ дагуу Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам нарын гишүүдээс 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр хуулийн төсөл татан авах тухай 160 тоот албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Хуулийн төсөл татаж авах тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэг болон заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын гишүүн миний бие нэр бүхий гишүүдийн хамтаар Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.3 дахь заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20.2-т заасны дагуу Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн доорх хуулийн төслүүдийг татаж авах хүсэлт гаргаж байна. Үүнд:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг татан авах бичиг ирүүлсэн байна.

Эдгээр хуулийн төслүүдийг татан авсанд тооцлоо. Эдгээр хуулийн төслүүд татан авагдсан шүү. Ундрам гишүүн, Баярсайхан гишүүн хоёр ирсэн байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хуулиар Соёлын дэд сайдын ажлын хэсэг нь уулзъя гээд байгаа. Өнөөдөр та гурав уулзаад нэг тийш нь болгосон нь дээр.

Мөнхцэцэг гишүүн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль нэлээн удаад байдаг. Үүнийг бас яаравчилж нэг тийш нь гаргах хэрэгтэй байх шүү.

Одоо гишүүд үг хэлнэ. Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт Монгол Улсын Их Хурлын 24 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлэх саналтай байна. Улсын Их Хурлын чуулганы хуралдаан Дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 13.4-д заасны дагуу зөвшөөрөл олгоно уу гэсэн. Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ.

**С.Бямбацогт:** Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Тэгэхээр сүүлийн үед энэ Хөрөнгө оруулалтын тухай хууль Монголын иргэдийг талцуулсан, эх оронч, эх оронч биш гэж хуваагдуулсан нэлээн маргаан мэтгэлцээн өрнөсөн, бухимдуулсан ийм асуудал болж байна л даа. Монгол Улсын Засгийн газраас ч гэсэн нэлээн ярьж байж, хэлэлцэж байж өргөн барьсан. Хууль улам сайжирч байх ёстой. Энэ агуулгаараа сайжирч байгаа гэж ойлгож байгаа. Өмнө нь бид нар хөрөнгө оруулалтыг гадных, дотных, гадаадынх гэж ялгадаг, ялгаварладаг байсан. Гадаадын хөрөнгө оруулалт л бол дэмжих ёстой, дотоодынх бол тоохгүй байх ёстой. Уул уурхайд хөрөнгө оруулах юм бол дэмждэг, үндэсний үйлдвэрүүддээ хөрөнгө оруулах юм бол дэмждэггүй. Ямар нэгэн татварын хөнгөлөлт дэмжлэг үзүүлдэггүй ийм явж ирсэн.

Мөн бас Хөрөнгө оруулалтын тухай хууль 13 онд баталсан. Үүнтэйгээ уялдуулаад Татварын хууль, Төсвийн хууль гээд хуулиудаараа бусдыг нь боомилчихдог. Иймэрхүү байдлаар л үндсэндээ хөрөнгө оруулалтыг нь ялгавартай дэмждэг, ялгавартай ханддаг, дээрээс нь заримдаа үзэмжээрээ ханддаг. Татварын хуулиар үгүй ээ зөвшөөрөхгүй. Заримдаа бол Татварын хууль хамаагүй, Хөрөнгө оруулалтын хууль нь чухал. Иймэрхүү олон сул тал алдаанууд байсан. Энэ алдаануудыг зассан энэ хуулиар. Өөрөөр хэлэх юм бол хөрөнгө оруулагчийг гадаадын хөрөнгө оруулагч, дотоодын хөрөнгө оруулагч гэж ялгахад больж байгаа. Тэр уул уурхайд хөрөнгө оруулсан байна уу, үндэсний үйлдвэрлэлд хөрөнгө оруулсан байна уу ялгаварлахаа больж байгаа.

Дээрээс нь Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийцүүлж Татварын болон Төсвийн хуульд нийцэж бас ажиллах ёстой ийм болж байгаа. Урьд нь Хөрөнгө оруулалтын тухай хуулиараа хөнгөлнө, чөлөөлнө, дэмжинэ гэхчидэг. Татварын хууль, Төсвийн хуулиараа дэмждэггүй ийм байсан. Энэ алдаанууд бол засагдаж байгаа юм. Энэ утгаараа энэ хуулиудад хэлэлцэх ёстой.

Гэтэл ганц, нэг заалтаас болоод тэр ярьж байгаа заалтууд нь мушигдаж, гуйвуулагдаж байгаагаас болоод асуудал үүсэж байна. 100 жилээр газрыг гаднын иргэнд өгөх гэж байна гэж асуудал ярьж байгаа нэг талдаа. Маш их бухимдаж байна. Тэгвэл нөгөө талдаа 100 жилээр эзэмшүүлдэг, ашиглуулдаг байсан урьд нь, тэгвэл зөвхөн ашиглуулдаг болж байгаа, эзэмшүүлэхгүй гэж байгаа. Гэтэл үүний цаад талд нь нөгөө дотоодын хөрөнгө оруулагч эзэмшихээ болих нь, зөвхөн ашигладаг болох нь ингээд дотоодын хөрөнгө оруулагч хохирох нь. Энэ асуудлыг хэрхэн яаж, шийдэх юм.

Мөн хөрөнгө оруулалтын босго гээд асуудал байна. Ийм эргэлзээтэй

асуудлуудыг бас тайлах хэрэгтэй байна. Олон нийтээр бас хэлэлцүүлэх шаардлагатай байна. Энэ дээр бас ард түмнийхээ бас мэдэх эрхийг хангах хэрэгтэй байна. Тэгэхгүй хүч түрээд юм уу унагаадаг, хүч түрээд эсвэл цааш нь явдаг ийм байж таарахгүй. Бид нэг Монгол Улс. Бүгдээрээ бас эрх ашигтай ойлголцоод явмаар байна. Энэ үүднээсээ бас нэлээн нухацтай хандаач, гишүүд бас анхаараач гэдгийг бас хэлэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт нь энэ хөрөнгө оруулалттай холбоотойгоор Ховдын Хөшөөтөд 100 хувийн Конг Конг хөрөнгө оруулалттай МоЭнКо компани үйл ажиллагаа явуулж байгаа. Хөшөөтийн уурхай дээр. Энэ Хөшөөтийн уурхайг стратегийн ордод авмаар байна. Хөшөөтийг төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон. Өнөөдөр 100 хувийн хөрөнгө оруулалттай гаднын компани үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ компани Хонг Конгийн хөрөнгийн бирж дээрээс мөнгө босгож ирсэн байж байгаа. Ингэж орж ирэхдээ ихээхэн зүйл амласан. Их олон үүрэг хүлээсэн. Дулааны цахилгаан станц барина, коксын үйлдвэр барина, Монголын компаниуд, дотоодын компаниудыг дэмжинэ гэж. Энэ үүргүүдээс ганцхан биелж байгаа үүрэг нь үндсэндээ Монголын компани, Монголын компаниуд дотоодын ханган нийлүүлэгч нар оролцож байна. Тээврийг Монголчууд, тэн дундаа Ховдчууд хийж байгаа. Нөгөө цахилгаан станц барих асуудал байхгүй болчихсон. Баруун аймгийнхан Оросоос, Хятадаас өндөр үнэтэй тог авч байна. Коксын үйлдвэр байхгүй. Ийм байдлаар үндсэндээ хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна. Олон жил болж байна. Тийм болохоор стратегийн ордод авъя. Монголын төр 34 хувийг нь эзэмшье. Монгол Улсын Үндсэн хуульд бид нар байгалийн баялгийн өгөөжийн дийлэнхийг Монголын ард түмэн хүртэх эрхтэй. Монголын ард түмэн байгалийн баялгийн өгөөжийн талаар мэдэх эрхтэй гэж заасан байгаа Үндсэн хуульд. Энэ Үндсэн хуулийн

заалтыг хэрэгжүүлмээр байна. Тэгэхгүй тэгээд л хардаад л, цэрдээд л, хулгай зэлгий, хууль бус гээд л ярьдаг. Үнэхээр хууль бай ёсны байна уу, хууль бус байна уу, нүүрсний хулгай байна уу, байхгүй юу бас шалгамаар байна. Хууль хяналтын байгууллагууд бас ажилламаар байна энэ дээр.

Тийм болохоор хууль хяналтын байгууллагууд энэ Хөшөөтийн уурхай МоЭнКо компанийн үйл ажиллагааг шалга. Хөшөөтийн уурхайг стратегийн ордууд авах асуудлыг би бас ярина. Монголын төр байгалийн баялагтаа эзэн болъё монголын ард түмэн. Орон нутаг мэддэг биш, олон нийт мэддэг, төр мэддэг болъё. Ийм байдлаар бас байгалийн баялгийнхаа өгөөжийг Монголын ард түмэн хүртмээр байна. Мэдэх эрхээ хангамаар байна. Тийм болохоор стратегийн ордод Хөшөөтийн ордыг оруулах асуудлыг цаашидаа бас хөндөж ярина гэдгээ бас энд хэлье.

**Г.Занданшатар:**Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор үг хэлнэ гэсэн.

**Б.Пүрэвдорж:** Дараалалтай холбоотой, хамгийн сүүлд нь хэлнэ. Одоо малчдын амьдрал бас нэлээн хүндэрч байна. Малаа маш их нядалж байна. 500 малтай айл 300-г нядлаад 200-тай үлдэж байгаа айл маш их байна. Тийм ч учраас энэ өвөлжилт хүндэрсэн газар мал их нядалж байгаатай холбоотойгоор өнгөрсөн жилийн оны эцсийн тооллого 71 сая толгой малтай байсан бол өнөөдөр 64.7 сая толгой мал тоолуулж мал их хорогдсон байна. Энэ өвөлжилт хүндрэх нь гэж үзээд Засгийн газраас 100 тэрбум төгрөгийг махны холбоотой хамтарч зохион байгуулж, компаниудад энэ гар аргаар нядалсан махыг авах талаар арга хэмжээ авч байгаа. Батлан хамгаалахын сайд Сайханбаяр ахлаад энэ ажлыг Махны холбоотой бас сайн хийж байгаа гэдгийг бас хэлье. 44 компанид

урилга өгсөн, 25 нь энд оролцохоор болсон.

Гэвч нөгөө бүх компаниуд бүгдээрээ бүх хөрөнгөө бүгдэнг нь барьцаанд тавиад зээл аваад тэр нэгээрээ мах авчихсан түүнийгээ борлуулж чадахгүй байгаа учраас дахиад банкны шалгуур давж гарч ирж байгаа компани ерөөсөө ховорхон байна. 23 компаниас 5 л банкны шалгуур даваад гараад ирсэн. Одоо тэгэхээр үлдсэн 100 тэрбум төгрөгийн зээл чинь ихэнх нь үлдэнэ гэсэн үг.

Тэгэхээр энэ 100 тэрбумаас нэгэнт л үлдэх юм чинь бас яг энэ 2017-2018 оны хооронд бас зуд болсон. Тэр зудаар яасан бэ гэх дээр өнгөрсөн жилийнх шиг Засгийн газар, Шадар сайд нь яваад 20, 30-хан тонн тэжээл улсын фондоос малчдад өгдөг биш, илүү хямдхан тэжээл нийлүүлэх тэр ажлыг хийсэн байхгүй юу даа. 2017-18 онд 8 аймаг хүндрэхэд 40 тэрбум төгрөг Засгийн газраас гаргаад, тэндээсээ 5, 5-н тэрбумыг аймгуудад өгөөд тэндээс нь компаниудын эндээс хүүгүй зээл ав, өнөөдөр жишээ нь 14 мянган төгрөгөөр хивээг Ховд аймагт байж байхад, 13 мянган төгрөгөөр бүтэн энэ өвөл, хаврын хугацаанд нийлүүл, 24 мянган төгрөгөөр хорголжин тэжээл байна, 23 мянган төгрөгөөр нийлүүлэх юм бол эндээс хүүгүй зээл ав гэдэг ийм шаардлага тавиад энэ компаниуд оролцоод, тэр хаваржингаа хямдхан хорголжин тэжээлтэй, химийн тэжээлтэй малчид малаа онд оруулсан байхгүй юу даа.

Гэтэл өнөөдрийн Засгийн газар ерөөсөө дээгүүр нисээд л ингээд л яваад байхаас биш энэ доогуур ерөөсөө ажил хийхгүй. Амьдралгүй, сайд нар нь, салбарын сайд нар нь ингээд сэтгэлгүй ийм байдал маш их бий болж байна. Тийм учраас энэ нэгэнт л энэ Засгийн газраас 100 тэрбум төгрөг гаргаад малчдын гар дээр байгаа махыг худалдаж авах энэ ажлыг хий гэж байгаа юм бол энэ компаниуд авч

чадахгүй, зээлийг нь авч чадахгүй юм байна.

Тийм учраас тодорхой үлдэгдэл үлдэх нь. Энэ тохиолдолд тэр үлдсэн малаа яаж онд оруулах вэ, яаж малчдын гар дээр хямдхан тэжээл аваачих вэ, яаж зохион байгуулалтад орох вэ гэдэг асуудлыг маш сайн шийдвэрлэх ийм шаардлага байна. Ялангуяа Завханы хувьд нэлээн хүнд байгаа. Тийм учраас энэ Завхан аймаг энэ тэр дээр бас энэ мөнгөнөөс тодорхой хэмжээгээр мөнгийг нь аваад, компаниудад өгөөд Арц сууриар тэжээл оруулаад хийх боломж байж байна шүү дээ. Увс аймаг ч гэсэн бас Боршоогоор оруулаад, Ховд, Баян-Өлгий, Цагааннуураар оруулаад ингээд асуудлаа шийдээд явах ийм бүрэн боломж байна. Энэ дээр Их Хурлын гишүүд, ялангуяа Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэрэнпунцаг даргаа та бас энэ дээр жоохон анхаараад бас чиглэл өгөөд энэ малчдынхаа талаар бас жоохон юм хум бодоод явахгүй бол болохгүй нь. Энэ чинь ажил хийдэг сайд байхгүй, амьдрал мэддэггүй ийм нөхөд энэ Засгийн газарт чинь байж байна шүү.

Ингээд л их хулгай яриад, түүнийгээ илрүүлсэн хүмүүс л байгаад байгаа болохоос яг амьдрал дээр бууж энэ малчдын бараа бүтээгдэхүүний үнийг буулгах, малын үнийг өсгөх, махны үнэ өсгөх талаар ерөөсөө хийж байгаа юм ерөөсөө алга байна. Тийм учраас энэ дээр жоохон бодлоготой, хурдан ажиллаарай гэж танаас бас хүсэх байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо Амгалангийн Адъяасүрэн гишүүн үг хэлнэ.

**А.Адъяасүрэн:** Та бүхэндээ энэ өглөөний мэндийг хүргэе. Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр хэл үг байна. Одоо сонгогчдоос, иргэдээс маш их санал ирж байгаа. Иргэдийн дуу хоолой болж байгаагийн хувьд бас иргэдийнхээ үгийг энд хүргэх ёстой гэж бодож байна. Гаднын хөрөнгө оруулалтыг дэмжихгүй байна гэж үгийг

минь бас битгий гуйвуулаарай. Монгол хүн, Монгол газар нутагтаа эзэн байх тухай би ярих гэж байна. Хөрөнгө оруулалтын тухай хууль гэххэд хөрөнгө оруулалтын босгогүй болгож байгаа нь хөрөнгийг татах биш, мөнгөгүй гадаад хүнийг оруулж газраа өгөх далд санаа агуулсан ийм хууль оруулж ирж байгаад миний бие харамсаж байна. Дэлхийн улс орнуудад гадаадын хөрөнгө оруулалтын хуульдаа тодорхой нөхцөлүүдийг тавьдаг.

Тухайлах юм бол Америкийн Нэгдсэн Улс гадаадын хөрөнгө оруулалтын статус авахын тулд 800 мянган долларын босго тавьдаг. Солонгос 100 сая вонх, Тайланд 10 сая ботийн босгыг шаарддаг. Газраа ашиглуулахгүй бол босгоо намсгахгүй бол хөрөнгө оруулалт хийхгүй гэсэн гадаадын нэг ч бизнес байхгүй. Манайд томоохон хөрөнгө оруулалт орж ирэхгүй байгаагийн шалтгаан нь юу юм. Тэгвэл хамгийн том шалтгаан гэвэл хууль, эрх зүйн орчин тогтворгүй байгаа шүү дээ. Хууль байнга өөрчлөгдөж байдаг энэ эрсдэлийг чинь тоочиж гадаадын том хөрөнгө оруулагчид орж ирэхгүй байгаа юм. Энэ хуульд сүүлийн 11 жилийн хугацаанд 11 удаа өөрчлөлт орсон байна шүү дээ. Үүнийг юу гэж ойлгох юм тэгвэл. Хүрэлбаатар гишүүний оруулаад байгаа энэ хууль батлагдлаа гээд бодоход жинхэнэ хөрөнгө оруулагчид итгэж орж ирэх юм уу? Хөрөнгө оруулагчид итгэхгүй байна шүү дээ. Хойтон өөрчлөгдөх хуульд хэн итгэх юм бэ? Энэ хуулийн тодорхой нэг заалтуудаас би эш татаж яримаар байна. Монгол хүнд 15 жилээр олгодог газрын эрхийг энэ хуулийн 16.1 дээр гаднын хүнд 100 жилээр ашиглахаар байгаа.

Мөн 30.1, 2-т зааснаар хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг Монгол Улсын хууль, шүүх бол шийдэхгүй. Мөн олон улсын арбитрын журмын дагуу бол шийдэхээр оруулж ирсэн байна. Энэ нь угтаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмээр 80 жил

тогтвортой суурьшсан иргэдийг уугуул иргэд гэж үздэг. Ингээд 80-хан жилийн дараа бид нутгаасаа хөөгдөх, нутагтаа хавчигдах ийм нөхцөлд орох юм биш үү? Энэ хоосон хардлага биш ээ, бодит түүх. Энэ Палестины түүхийг та нар хар л даа тэгвэл. Энэ зурагт анхаарлаа хандуулахыг хүсэж байна Их Хурлын гишүүдийг. Энэ Палестины зураг 1900-гаад оноос эхлээд Израилын мөнгө хүүлэгчид Палестины газар нутгийг түрээсэлж, мөн худалдаж авч эхэлсэн. 1947 онд энэ цагаанаар тэмдэглэгдсэн газрыг үндэслэж Нэгдсэн Үндэстний Байгууллага Израил улсыг байгуулсан. Одоо байдал ямар байгаа юм? Одоо 20 хувь дээр нь уугуул Палестин иргэд дайнд нэрвэгдэж, хавчигдаж, гадуурхаж амьдарч байна тэгвэл. Палестин иргэдийн 80 хувьд нь Израил иргэд, Израилчууд амьдарч байна. Энэ түүх биш юм уу? Үүнийг бид нар давтах гэж байна шүү дээ. Юундаа эгдүүцээд байгаа юм та нар. Би үгээ хэлэх эрхтэй. Ийм хууль оруулж ирчхээд. Яагаад би үгээ хэлж болдоггүй юм, юундаа эгдүүцээд байгаа юм? Ямар ашиг сонирхол байгаа юм? Монголд Монголын малчид малаа хариулах газаргүй болж байна. Сошиалаар та нар харж байгаа байх. Гаднын хөрөнгө оруулагч гээд нэг нөхөр монголын малчдыг малынх нь бэлчээр дээрээс хөөх ийм эрсдэл үүсэж байна шүү дээ. Тэгвэл Хүрэлбаатар сайдаа энэ хуулиа та татчихаач. Үнэхээр тийм юм бол ард иргэдийн нийтээс.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Өглөө чуулганы тов, дараалалтай холбоотой үг хэлдэг. Би яг энэ тов дараалалтай холбоотой үг хэлэх гэж байна л даа. Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын 19-өөс дээш гишүүн гарын үсэг зурж Түр хороо байгуулах тогтоолыг өргөн барьсан бол хэлэлцэх

асуудлын дараалал харгалзахгүйгээр нэн даруй хэлэлцэж Хянан шалгах хороог заавал байгуулна гэсэн ийм Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйл дээр цагаан дээр хараар бичсэн ийм заалттай.

Ардчилсан намын бүлгийн гишүүд, дээр нь 12 гишүүн нэмэгдэж нийт 25 гишүүний гарын үсэгтэйгээр Улсын Их Хурлын даргад 11 дүгээр сарын 29-ний өдөр өргөн барьсан. Өнөөдрийг хүртэл тэр дараалал харгалзахгүйгээр нэн даруй хэлэлцэнэ гэсэн тэр товчилж хэлбэл ногоон автобусны талаарх сонсгол явуулах Түр хороо өнөөдрийг хүртэл байгуулагдсангүй. Улсын Их Хурлын даргад энэ энэ хууль ингэж гуйвуулахаа бас болио. Бид бүгд бас үүн дээр дараагийн арга хэмжээ болох Үндсэн хуулийн цэцэд хандах арга хэмжээг авна. Улсын Их Хурлын чуулган нь ирэх 7 хоногт завсарлана. Энэ богинохон хугацаанд үлдэж байгаа хугацаанд Түр хороог байгуулж, хаврын чуулганаар энэ сонсголыг явуулах нөхцөл, бололцоог та хангаж өгөх ёстой. Мөн энэ энд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Энхболд даргад бас яг энэ Түр хороо байгуулах асуудал бас хамаатай.

Ер нь өнгөрсөн хугацаанд бүхий л зүйлийг улс төржүүлж, тэр нүүрсний сонсгол гэсэн чинь яаж Ардчилсан нам дээр нааж нялзаах вэ, яаж ардын намынхныг сугалж гаргах вэ гэдэг ийм л бодлого явж өнгөрсөн шүү дээ. Одоо яг энэ энэ дээр ногоон автобусны асуудал, КОВИД-ын сонсголын асуудал дээр зөвхөн энэ эрх баригчдын 4 жилтэй холбоотой, эрх баригчдын 8 жилтэй холбоотой энэ үйл ажиллагааг хэнтэй ч хуваалцахгүй хариуцлага ярих асуудал дээр тулаад ирэхэд үүнийг байгуулахгүй гэдэг ингэж аргацааж хойшлуулах ийм нөхцөл байдлыг үүсгэж байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын дарга та үлдэж байгаа богино хугацаанд энэ ногоон автобусны сонсгол явуулах Түр хороог нэн яаралтай горимоор

байгуулахыг өнөө, маргаашийн хуралдаанд оруулж шийдүүлэхийг танаас шаардаж байна. Энэ зөвхөн Ардчилсан намын бүлгийн асуудал биш. Монгол ардын намын 12 гишүүн гарын үсэг зурж, нийтдээ 25 гишүүний гарын үсэг бүхий тогтоолын төсөл шүү. Бас үүн дээр зориг гаргаад ард түмний мэдэх эрхийн төлөө гарын үсгээ зурсан нэр бүхий 12 гишүүнд бас энд талархаж байгаагаа бас илэрхийлье.

**Г.Занданшатар:** Энэ хянан шалгалтын Түр хороо байгуулах асуудал Улсын Их Хурлын тухай хуулиар зохицуулагдсан. Үүнийг холбогдох Байнгын хороо шийдвэрлэх ёстой. Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэгдсэн. Одоо энэ нийслэлийн асуудал, нийтийн тээврийн асуудал, газрын асуудлаар энэ хяналт шалгалтын Түр хороогоо байгуулж, ажиллах хэрэгтэй. Ийм Төрийн байгуулалт хуралдаад. Яах вэ энэ түрүүчийн нүүрсний сонсгол салан баавгай үлгэр шиг тэр санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганд танилцуулснаар татан буугдсанд тооцно гэж байгаа. Түрүүчийн Түр хорооны асуудал дуусаагүй байгаа учраас энэ хүлээгдэж байсан байх. Одоо түрүүчийн Түр хороо хяналт шалгалтын дүгнэлтээ танилцуулаад, дараагийн хяналт шалгалтын Түр хороод үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжоор нээгдэнэ.

Тийм учраас энэ хяналт шалгалтын Түр хороо ажиллуулж байсан туршилагатай гишүүд оролцоод, нийслэлийн тээвэр, нийтийн тээвэр, нийслэлийн асуудал, газрын асуудлаар энэ хяналт шалгалтын Түр хороо байгуулж энэ цэгцлэх шаардлагатай гэсэн энэ гишүүд холбогдох Байнгын хороодын санал байгаа. Үүнийг үүрэг, чиглэл болгож байна. Үүнийгээ хэлэлцээд тэр хугацаандаа тэр хяналт шалгалтын Түр хороогоо байгуулаад ажилла. Тэр тогтоолын төслөө гишүүд өөрсдөө Байнгын хороон дээрээ орж хэлэлцүүл. Тэгэхгүй тэгээд л энэ чуулган дээр

ярьчхаад, даргын дэргэдэх зөвлөл дээр ярьчхаад түрүүгээрээ шийд гээд чиглэл өгсөн шүү дээ. Тэгээд ажиллацгаа. Тэр Баттөмөрийн Энхбаяр гишүүнээс туршилага судал. Энхбаяр гишүүн өөрсдөө ч гэсэн Хууль зүйн сайд хүн оролцоод энэ туршилага хуримтлуулсан. Хяналт шалгалтын түр хороогоо хэн ахлах юм, байгуулаад Байнгын хороогоор хэлэлцээд яв.

Ер нь бас тэр Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэх ёстой байгаа шүү дээ. Төрийн байгуулалтын байнгын хороо энэ бүсчлэлийн хөгжилтэй холбоотойгоор.

Дараа нь Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн. Ширнэнбандийн Адьшаа гишүүн алга байна. Чимэдийн Хүрэлбаатар гишүүн үг хэлнэ.

**Ч.Хүрэлбаатар:** Энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дагасан нэлээд их улс төржилт явагдаж байна. Монгол Улс маань хөгжсөөр байна, ард иргэдийнхээ амьжиргааг дээшлүүлмээр байна, Монголчуудынхаа орлогыг нэмэгдүүлмээр байна. Ингээд үзэхээр Монгол Улсын хөгжлийн хамгийн гол хөдөлгүүр бол хөрөнгө оруулалт. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлийн бүхий л арга хэмжээнүүдийг бид нар авч хэрэгжүүлэх ёстой. Иргэд үүнийг л хүсэж байгаа. Та бүгд минь өөрчлөгдөөд өгөөч, шинээр хараад өгөөч, ард иргэдийнхээ амьдралыг, улс орноо хөгжүүлэх чиглэлээр шаардлагатай алхам болгоныг хийгээд өгөөч л гэж Монголын ард түмэн хүсэж байгаа. Бурууд нүд хурц байгаа Монголчууд.

Ийм учраас хэдүүлээ урьд өмнө гарсан бүх алдаануудаа засаад л яваад ирж байгаа. Авлигатай тэмцэх, луйвар булхайнуудыг илчлэх, ил болгох, хэлэлцэх, засах гээд ийм олон асуудлуудыг шийдээд явж байгаа. Ганихан үг нийгэмд ямар их өөрчлөлт авчирдгийг би та бүгдэд хэлье. Үүнийг бид бүгдээрээ хамтдаа хийсэн. Бирж гэдэг үг. Биржийн хууль энэ Улсын

Их Хуралд орж ирээд 2 жил дарагдаж байгаад хэлэлцэгдэж эхэлсэн. Энэ хууль батлагдсаны дараа Монголын энэ газрын доорх баялгууд үнэд хурдэг болсон. Монгол Улсын валютын нөөц нэмэгдсэн, улсын төсөв давж биелж байна, эдийн засаг 7 орчим хувиар өсөх болж байна ил тод байдал хангагдаж байна. 80 долларын юм 180 доллар болж байна. Ганихан үг бирж гэдэг үг ямар их өөрчлөлт авчирч байгааг бид нар бүгдээрээ мэдэж байгаа.

Хоёрдугаарт нь Англи хэл. Англи хэлийг Монголын энэ албан ёсны сургалтын гадаад хэл болгоно гэдгийг хуульд оруулж ирж өгөхөд энэ сайхан залуучууд Монголын залуу үе яаж их баярлаж хүлээж авч байна вэ. Яг маргааш байдал сайжрахгүй ч ирээдүйд Монгол Улс хөгжлийн зөв алхмуудыг хийж байна л гэж харж байгаа.

Дээр нь би нэг зүйл хэлье. Гадаад паспорт гээд хоёрхон үг. Гадаад паспорт Монгол Улсынхаа бүх иргэдэд гадаад паспортыг чөлөөтэй олгоё гэхэд эсэргүүцдэг мянга сая саяар, мянга мянгаараа эсэргүүцэж байсан Монголчууд бүгдээрээ гадагшаа гараад явчихна, болохгүй энэ ёстой Монгол Улсыг хорлох гэж байна гэж хэлж байсан. Гадаад паспорттой болсон Монголын хүн ам байна, бүүр өсчихсөн. Энэ ямар их өөрчлөлт, хүмүүсийн үзэл бодол, хандлага, сэтгэхүйд ямар их өөрчлөлт авчирсан бол. Өнөөдөр бид нар яг үүнтэй адилхан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ийм алхам хийх гэж байгаа юм. Мэдээж үүнийг Монгол Улсын хөгжлийн ирээдүй минь гэрэлтэй байгаасай гэж хүн болгон хүсэж байгаа. Монгол Улсын ирээдүй маань харин нэг нэгийгээ эрлийз, хурлийзаар нь дууддаг. 30 жил Монгол Улсын хуульд газрыг 100 жилээр байгаа заалтыг гэв гэнэт Колумб Америк улсыг нээчихсэн юм шиг олж хараад Хүрэлбаатар буюу эд нар улсыг газрыг 100 жилээр өгөх гэж байна гэж үлгэр зохиодог. Жишээ нь энд сууж л

байна. Шал худлаа 30 жил Монгол Улсын хуульд байсан.

Гэтэл Колумб Америк тивийг нээчихсэн юм шиг гэв гэнэт тэр үг гаргаж ирж, их үнэмшилтэйгээр жүжиглэцгээж байгаа. Хоолойгоо шахаж ярьж байгаа, нүднээс нь нулимс унжуулж ярьж байгаа. Гэхдээ тэрбум тэрбум төгрөгөөр Монгол Улсын ирээдүйг харлуулдаг, Монголчуудыгаа хуваадаг, доромжилдог ийм зүйлүүдэд зогсоох цаг бидэнд өнөөдөр ирж байгаа. Монгол Улсын ирээдүй эерэг байгаасай, сайхан байгаасай, гэрэлтэй байх ёстой гэж бид нар шийдвэр гаргах ёстой. Энэ Улсын Их Хурлын гишүүдийнхээ олонход би итгэж байгаа. Ардчилсан намаас гишүүд байна, Хүн нам байна. Ардын намын олон олон залуучууд үүнийг дэмжиж байгаа.

Харин хуучинтайгаа хоцрогдъё. Монгол Улсыг өнөөдрийг хүртэл танкны үлгэрээр Монгол Улсын хөгжлийг хэдэн 10 жилээр нь хойшоо татаж ирсэн хэсэг бүлэг хүмүүсийн гар, хөл болж байгаа хүмүүс өнөөдөр энэ хуулийг эсэргүүцнэ. Энэ ажиллагаанд хэдэн тэрбум төгрөг цацаж хүмүүсийг харлуулж. Гэхдээ Монголчуудын сэтгэлийг харлуулж чадахгүй шүү, Монголчуудын гэрэлт ирээдүйг харлуулж чадахгүй шүү, Монгол Улсын гэрэлт ирээдүйг гэрэлгүй болгож чадахгүй шүү гэдгийг би энд онцолж хэлмээр байна.

Их Хурлын даргаа та үүнийг б сараас хойш үүнийг барьсан. Өнөөдөр үүнийгээ хэлэлцүүлээд шийдвэр гаргая. Ямар нэгэн завсарлага иймээ тиймээ байхгүйгээр одоо шийдвэрээ гаргаад, хоёр талдаа гарцгаая, ил тод болцгооё одоо. Ингээд хэн нь Монгол Улсын хөгжлийг хойш нь татаж явъя гэдгээ шийдье, хэн нь урагшаага алхаж гэрэлт ирээдүй рүү алхах гэж гэж байгаагаа одоо бүгдээрээ харж шийдээд гаргацгаая. Одоо өнөөдөр шийдье.

**Г.Занданшатар:** Одоо Дашдондогийн Ганбат гишүүн. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 22 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд, 22 ондоо батлагдсан шүү. 2 жил дарагдсан асуудал байхгүй. Одоо Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат.

**Д.Ганбат:** Би, манай Адыасүрэн гишүүн ч үг хэлэх эрхтэй. Та нар битгий орилж чарлаад бай. Сая Хүрэлбаатар сайдын үг хэлж байхад бид нар дуугүй л байж байгаа биз дээ. Бид нар ардчилалд гайгүй суралцчихсан байна шүү.

Ингээд үргэлжлүүлье. Хөрөнгө оруулалтын хууль олны анхааралд орж ирж байна. Энэ бол сайн. Бид хэд хэдэн удаа ер нь хэдэн удаа ч яах вэ дээ боломж бол тэр болгон олдоод байдаггүй дэлхий нийтэд, энэ улс оронд. 10-аад жилийн өмнө 2011, 2012 онд Монгол Улс хоёр орон тоотой өсөөд л, гадаадад хар ажил хийж байсан залуучууд маань эргэж ирээд л ингээд л гэрэл гэгээтэй харагдаад эхэлж байсан. Дэлхий нийтээрээ энэ нүүрсээрээ энэ Монгол Улс маань, энэ Монгол Улс чинь, Чингисийн үр сад чинь дараагийн Катар болох нь, энэ Улаанбаатар нь дараагийн Дубай болох нь гэж байсан. Тэр хүлээлт байхгүй боллоо л доо. Үүнээсээ сургамж авч байгаа байх.

Ер нь аливаа улс орон, ард түмэн 1 удаа хууртаж болно. 1 удаа хууртах энэ асуудал мэдээж хэрэг мэдэхгүй, чадахгүйгээсээ болж байгаа юм, толгойгоо угаалгаснаасаа болж байгаа. Хоёр дахь, гурав дахь удаагаа хууртаж болохгүй. Хэрвээ хууртвал энэ ард түмний энэ ард түмнийг төлөөлж байгаа бид нарын буруу. Тэгэхээр энэ Хөрөнгө оруулалтын хууль ус, агаар шиг хэрэгтэй байна гэж би гадаадын хөрөнгө оруулалтыг би хэлээд байгаа шүү дээ. Тэндээс ноу хау их олон юм сурна бид нар. Энэ хэн нэгэн сайдын өргөн барьчихсан хууль биш гэж ойлгож байна. Энэ бол Засгийн газраас 7 хэмжиж бүхэл



бүтэн цаана нь 8 жил дунишж байж оруулж ирж байгаа хууль гэж ойлгож байна. Үүний ар талд энэ Засгийн газар байгуулсан энэ нам нь олонх нь байна уу, үгүй юү ийм асуудал яригдаж байна. Үүгээрээ би юу хэлэх гэж байна гэвэл Монголчууд ярьдаг шүү дээ жингийн тэмээ явж л байдаг, жингэр банкнууд нь хуцаж л байдаг гэдэг биз. Тийм үү, үгүй юү? Үгүй ээ, ажлаа хийе ээ. Энэ Улсын Их Хурал олон сайн юм хийсэн.

Хэдийгээр би та нарыг шүүмжилдэг, хэдийгээр би та нарын юмыг дэмждэг. Олонх та нар шүү дээ. Асуудлаа шийд л дээ. Удахгүй Ерөнхий сайд Лаос явах гэж байна. Тэнд очоод юу хэлэх юм. Манай улс орон нээлттэй байна. 4, 5 мянган доллароос доошоо байвал ямар ч ардчилал байхгүй. Одоо л тэрэндээ бид нар хүрч эхэлж байна, гэрэл гэгээ гарч эхэлж байна. Бид нар парламентын засаглалыг бэхжүүлж чадлаа энэ Улсын Их Хурал бол. Цааш нь бид бас 1000 доллароор өсгөж чадлаа. Сүүлийн 10 жилд босохгүй байсан эдийн засгаа сайжруулж чадаж байна. Хулгайтай тэмцье, луйвартай тэмцье гэж байна. Ийм юмнууд байна байна. Үүнийг дэмжиж байна.

Тэгэхээр асуудлаа яриад, хэлэлцээд явъя. Мэдээж хэрэг энэ дотор хуулийн ганц заалтыг аваад, янз бүр болоод, сайлаад муулаад энэ байдаг л асуудал шүү дээ ардчилсан улс оронд. Бид нар ажлаа хийе. Оюу толгойн гэрээ, Оюу толгой цаашаа үргэлжлэх, гүний уурхай ашиглалтад орох энэ асуудлыг хэчнээн саад бэрхшээлтэй тулгардаг байлаа. Өмнө хийсэн Засгийн газруудын ажилласан юман дээр дөрөөлөөд манай Оюун-Эрдэнийн Засгийн газар үүн дээр маш сайн ажилласан. Бид нар ч гэсэн цөөнх байхдаа сайн дэмжсэн. Тэгээд та нарт танхимын зарчим чинь алга, та нарт Засгийн газраа байгуулсан олонх чинь алга. Ийм зарчмын зүйлээ ярья л даа. Тэр ичгэвтэр байна шүү дээ. Тэр 10 жилийн өмнө, 7, 8 жилийн өмнө ярьж байсан жирийн насаараа уур уурхайд

ажилласан инженер Алгаа гуай юу гэж хэлж байсан. Үгүй ээ энэ чинь өрсөлдөх чадвартай л нүүрсээ гаргамаар байна шүү дээ бид нар гэж хэлж байсан шүү дээ.

Тэгээд хар. Мухар замтай л сууж байна. Бид нар төмөр замтай. Та нарын үед л батлагдсан шүү дээ. Та нар л хариуцлагагүй хандсан. Энэ Монгол ардын намыг татан буулгах ёстой гэж ярьдаг. Гэхдээ татан буулгаад хэрэггүй. Яах юм эд нарыг татан буулгаж. Ажиллуулмаар байгаа юм. Тэгээд зоригтой, эрчтэй, үлдсэн хугацаандаа шуурхай ажиллая. Хэрвээ та нар наад хуулиа чадахгүй бол цааш.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарын урилгаар Өмнөговь аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 1992 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт, эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе Өмнөговьчуудад.

Одоо Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн үг хэлнэ.

**Ш.Адьшаа:** Их Хурлын гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Би энэ удаа энэ Улсын Их Хурлаар хэлэлцэх асуудлын дараалалд 2 асуудал оруулж өгөөч гээд л яриад байгаа юм л даа. Дахиад үүнийгээ ярихаас өөр аргагүй байна. Сая би хөдөө, орон нутаг яваад ирлээ ард иргэдтэйгээ уулзлаа, ялангуяа өнөөдөр Эрдэнэбүрэний цахилгаан станц гэдэг энэ том төсөл хөдлөх гэж байна. Үүнийг хөдөлгөхийг дэмжиж байгаа.

Гэтэл тэр нөлөөллийн бүсэд байгаа 1200 иргэнд 1 удаа 30 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн ийм зардал олгоё, нөхөн олговрыг олгоё гэдэг ийм

хуулийн төслийг энэ Засгийн газарт ажиллаж байгаа олонхын бүлгийн Чимэдийн Хүрэлбаатар гэдэг гишүүнтэй хамт өргөн барьсан. Үүнийг хэлэлцэхгүй жил гаруй болж байна. Тэр Эрдэнэбүрэний цахилгаан барих төслөөс чинь 17 сая доллар энд байгаа. 50 гаруй тэрбум төгрөг. Энэ мөнгийг нь ер нь яагаад олгох энэ хуулийн төслийг хэлэлцэхгүй байгаа юм бэ? Бид нар энэ төслийг амжилттай хэрэгжүүлэх ёстой. Энэ бол улс, эх орны асуудал. Баруун бүсийн цахилгаантай болгох асуудал.

Гэтэл тэр нөлөөллийн бүсэд байгаа тэр 1200 хүний тэр нөхөн олговрын 1 хүнд 30 сая төгрөг өгөх асуудал чинь энэ том улс орны эрх ашгийн хажууд жижигхэн асуудал байна шүү дээ. Монгол Улсын Үндсэн хуульд ард иргэдийнхээ амьдрах орчин, эрүүл ахуйн төлөө Монголын төр хариуцлага хүлээнэ гэж байгаа. Гэтэл энэ нөлөөллийн бүсэд байгаа 1200 иргэнд 30 сая төгрөг өгөөд, тэр амьдрах нөхцөлийг нь орчныг нь шийдэж өгч энэ төслөө урагшлуулъя. Энэ асуудлыг энэ чуулган завсарлахаас өмнө Улсын Их Хурлаар оруулж ирэхийг би энэ Улсын Их Хурлын даргын зөвлөлийн гишүүд, энэ нам, эвслийн бүлгээс би дахин хүсэж байгаа юм. Энэ асуудал бол Монголын төрийн энэ төслийг урагшлуулахын тулд хийх ёстой асуудал гэж ойлгож байгаа.

Нөгөө нэг асуудал, Улсын Их Хурлын гишүүнийхээ хууль санаачлах эрхийн хүрээнд иргэдээс авсан 1072 хувьцааг буцааж олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн барьсан. Энэ асуудлыг Төсвийн байнгын хороогоор хэлэлцсэн. Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцсэн. Энэ чуулган руу оруулж ирж өгөөч гэж би яриад байгаа юм. Одоо бараг 50 гаруй хоночихлоо. Энэ асуудал шийдэх ёстой асуудлын нэг. Бид 2012 оны сонгууль, 2016 оны сонгуулийн өмнө сая гаруй иргэнийхээ 1072 хувьцааг мэдээлэл дутуу, хөрөнгө мөнгөний чадваргүй байдлыг

далимдуулаад Монголын төр худалдаж авсан. Зөвхөн сонгуульд зориулж сонгуулийн өмнө шүү. Ийм учраас энэ асуудлыг нь буцаагаад өгчихье гэж байгаа юм.

Тэгэхдээ үнэ төлбөргүй авъя гээгүй шүү дээ. Энэ ноогдол ашгаас нь суутгачихъя л гэж байгаа юм. Ноогдол ашиг өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой” энэ 1 хувьцааны ноогдол ашиг, 1 хүнд оногдох ноогдол ашиг чинь 580 мянган төгрөг байна гэж байгаа шүү дээ. 2 жилийнх нь ноогдол ашгаас нь тооцоод л сая гаруй иргэнээ “Эрдэнэс Тавантолгой”-ынхоо хувьцаа эзэмшдэг ийм хууль, эрх зүйн орчныг бүрдүүлье гэж байгаа юм.

Дээр нь өнөөдөр Монголын төр сонгууль бүрийн өмнө сонгууль зориулж төрийнхөө өмч хөрөнгийг санал авах зорилгоор авч байсан энэ буруугаа бас хүлээчихье гэж байгаа юм. Ийм л асуудал байгаа. Энэ 2 асуудлыг Улсын Их Хурлын дараагийн хэлэлцэх асуудалд оруулж өгөөч гэсэн ийм горимын саналыг би удаа дараа хэлж байгаа юм. Үүнийг Улсын Их Хурлын удирдлагууд, энэ даргын зөвлөлийнхөн, Засгийн газрынхан нь энд анхаарал хандуулж өгөөч гэж хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо Дашдондогийн Ганбат гишүүн ч сая үг хэлчихсэн тээ? Тогмидын Доржханд гишүүн.

**Т.Доржханд:** Баярлалаа. Тэгэхлээр хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотой хоёр асуудал байна.

Нэгдүгээрт, энэ гадаадын хөрөнгө оруулалтын асуудал. Өнөөдөр бид нар хэлэлцэх эсэхээ шийдэхгүй бол гадаадын хөрөнгө оруулагч нарт маш буруу тохиолдол очно. 1 удаа хойшлуулсан, 2 дахь удаагаа хойшлуулах юм бол энэ гадаадын хөрөнгө оруулалт маань цаашаагаа Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хурлаар дэмжихгүй

юм байна гэдэг сигнал очно шүү. Тэгэхлээр үүнийгээ хийх хэрэгтэй.

Тэгэхлээр би бас эдийн засгийн талаас хоёр, гуравхан зүйлийг хэлчихье. Ер нь Монгол Улс хөгжснээ гээд тэгэх юм бол юу хэрэгтэй дэд бүтэц хэрэгтэй шүү дээ. Хөгжлийн санхүүжилт гэдэг. Хөгжлийн санхүүжилтийн 3 хүчин зүйл байгаа юм. Нэгдүгээрт, улсын төсөв, хоёрдугаарт, гадаадын зээл, гуравдугаарт хөрөнгө оруулалт.

Улсын төсөв маань алдагдалтай, гадаадын зээл болохлоор өрийн хязгаар дарчихсан. Дараагийн нэг суваг нь хөрөнгө оруулалт юм. Хөрөнгө оруулалтын онцлог нь юу вэ гэхлээр өчигдөр бид нар жиргээний спэйс дотор 860 гаруй Монголын иргэд, залуучууд, мэргэжилтнүүд орж ирээд хэлэлцүүлэг хийлээ. Тэрэнд тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд байсан Энхсайхан гуай орж ирж байна. Нэг зүйлийг та нар Их Хурлын гишүүддээ иргэддээ ойлгуулж өгөөч ээ. Гадаадын хөрөнгө оруулалт гэдэг бол хэзээ ч өр өсгөдөггүй юм гэж, өр үүсгэдэггүй юм гэж. Тэгэхлээр өрийн дарамт байхгүй.

Хоёрдугаарт, энэ шинэ зах зээлийг бий болгодог.

Гуравдугаарт, ажлын байр бий болгодог.

Дөрөвдүгээрт, шинэ технологи, ноу хауг оруулж ирдэг гээд маш олон давуу талтай юм. Ийм болохлоороо бид нарт гадаадын хөрөнгө оруулалт маш их хэрэгтэй. Яагаад гэвэл бид нар хөгжиж байгаа орон. Үүнтэй холбоотойгоор ямар асуудал гарч байна гээд тэгэхлээр өнөөдөр энд сууж байгаа хүмүүс эцэслэх хэрэгтэй. Би Ардчилсан намыг баруун төвийн үзэл санаандаа хатуу байгаад үүнийгээ дэмжээд яваасай гэж хүсэж байгаа.

Яагаад гэвэл баруун төвийн үзэл санаатай бизнесийг дэмждэг ийм улс

төрийн хүчин Монгол Улсад ус, агаар шиг хэрэгтэй байгаа. Зүүний үзэл санаа биш, халамжийг биш, гаднын хөрөнгө оруулагчдыг хөөдөг биш, дотоодынхоо хөрөнгө оруулалтыг шоронд хорьдог биш, чирдэг биш, дэмждэг ийм улс төрийн хүчнүүд Монголд ус, агаар шиг хэрэгтэй байгаа. Энэ тал дээр хатуу байж өгөөч ээ гэж хүсэж байгаа.

Нөгөө талдаа эрх барьж байгаа намыг бас ирцээ бүрдүүлээд та бүгд энэ дээрээ кнопоо дар гэж бас шаардаж байгаа. Яагаад гэвэл энэ та нарын үүрэг. Хэрвээ үүнийгээ та нар хийхгүй байх юм бол ирээдүйдээ та нар асар их хохирлыг бий болгоно, хариуцлага тооцно. Шинэ үе чинь хариуцлага тооцно шүү. Шинэ үеийг харин манлайлаад гарч ирэх улс төрийн хүчин байгаа шүү. Хүн нам та бүгдэд харин хариуцлага тооцно гэдгийг албан ёсоор мэдэгдчихье.

Хоёр дахь асуудал, Ерөнхийлөгчийн тухай хуулийн асуудал үнэхээрийн хэрэгтэй юм байна. Өчигдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга гэдэг хүн Төрийн ордонд орж ирлээ. 2 удаа нүүрсний сонсголоос зугтсан байдаг юм. Яг 1 жилийн өмнө нүүрсний сонсголоор бие өвчтэй гээд явсан. Сая нүүрсний сонсголоор бас ирээгүй. Шалтгаан байхгүй. Тэгсэн мөртөө гэв гэнэт иргэдэд хайртай дүр үзүүлээд, баатрын дүрээр гарч ирээд, энэ газар шороо, энэ нутаг чинь эзлэгдлээ шүү дээ гэдэг шал өөр хүрээнд хуулийн зохицуулалт гаргаж ирээд иргэдийн тархи угаалтыг хийж байна. Энэ бол Монголчуудыг хагалан бутаргаж байна, худлаа мэдээллийг тарааж байна. Үүнийг бид нар хэрхэвч хүлээн зөвшөөрч болохгүй.

Монгол Улсын Ерөнхийлөгч гэдэг бол Монгол Улсын эв нэгдлийг илэрхийлэгч ийм албан тушаалтан. Энэ хүн ажлаа өгсөн ч гэсэн бид Монгол Улсын төрийн тэргүүн Ерөнхийлөгчөө гэж хүндэтгэдэг. Цаашид Монгол Улсын бүх Ерөнхийлөгч нар ийм байгаасай гэж

бид нар хүсэж байгаа. Өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч нар орж ирээд Их Хурлын гишүүдийг, намын бүтцийн нарийн бичгийн дарга нарыг дагуулаад Их Хурлын даргатай уулзаж байгаа юм уу? Багабанди гуай уулзаж байна уу, Очирбат гуай уулзаж байна уу, Намбарын Энхбаяр гуай уулзаж байна уу Цахиагийн Элбэгдорж гуай уулзаж байна уу? Үгүй биз дээ? Тэгвэл бүгдээрээ үүнийг зохицуулах хэрэгтэй юм байна. Өөрөөр хэлэх юм бол Ерөнхийлөгчийн тухай хуулийг зохицуулцаа.

Үүнтэй холбоотойгоор судлаад үзэхэд 2 жилийн өмнө Улсын Их Хурлын гишүүн Ганбат яг энэ асуудлыг зохицуулахаар хуулийн төслөө өргөн барьчихсан байна. 2 жилийн өмнө алсыг харсан байна, зөв зохицуулалт байх шаардлагатай юм байна гэдгийг хараад өргөн барьчихсан байна. Үүнийгээ бүгдээрээ яаралтай хэлэлцье.

Монгол Улс ердөө 3.5-хан сая. Учраа олоод ирээдүйн залуучууддаа боломжийг нь олгоё гэдэг энэ шийдвэрүүдийг гаргахад Монгол Улсыг иргэдийг хагалдаг, буталдаг, буруу мэдээллээр тархийг нь угаадаг энэ байдалд одоо бүгдээрээ цэг тавьцаа гэж байгаа. Ийм болохлоор Ерөнхийлөгчийн тухай хуулийг яаралтай энэ хаврын чуулганаар.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн алба хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт цагдаагийн алба хаагчдадаа Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт хүсэн ерөөе.

Хаянгаагийн Болорчулуун гишүүн үг хэлнэ.

**Х.Болорчулуун:** Баярлалаа. Монгол Улсад үйлчилж байгаа гадаадын хөрөнгө оруулалтын хууль муугаас

гадаадын хөрөнгө оруулалт саатаж байгаа гэж би бодохгүй байна. Монгол Улс зах зээлийн багтаамж багатай, хоёр том газар нутагтай их гүрний дунд оршдог, дэд бүтэц сул хөгжссөн, мөн авлигал, хээл хахуультай, хуулийн тогтворгүй байдалтай зэрэг олон хүчин зүйлээс болж гадаадын хөрөнгө оруулалт бага байгаа нь үнэн. Тэрнээс биш хууль нь муу байгаад, энэ шинэчилж байгаа хууль эрс өөрчилсөн юм, сайжруулах юм огт байхгүй.

Харин би энэ дээр бол зарим зүйл, заалт дээр ноцтой үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй гэсэн ийм болгоомжлол төрөөд байгаа юм. Тийм учраас бас эсрэг үг хэлж байгаа юм. Тэр гадаадын хөрөнгө оруулалт дээр байсан 100 мянган доллароос дээших хөрөнгө оруулалт орвол гадаадын хөрөнгө оруулалт гэж нэрлэж тодорхой эрх эдэлдэг байсан.

Гэтэл тэр босго байхгүй боллоо шүү дээ. 16.1.5-аар байхгүй болгож байна. Өчүүхэн төдий хөрөнгө оруулбал сая төгрөг хүрэхгүй ч байсан гадаадын хөрөнгө оруулагч болох нь байна. Байнга оршин суух эрх авах нь байна шүү дээ. Энэ ноцтой биш гэж үү? Би үүнийг ноцтой гэж үзэж байна.

Хоёрдугаарт тэр газрыг бол өмнө нь байсан тэр 60 дээр нэмэх нь 40 жил. Яах вэ Хүрэлбаатар сайд үүнийг эзэмшүүлэх байсанг нь ашиглуулах болгож байна гэж. Эзэмших, ашиглах гэдэг чинь бол Монгол үгийн санд хоршоо үг гэж хэлэгддэг юм адилхан. Өмчлөхөөс өөр харин бид нар Монголын иргэддээ газар олгохдоо ихэвчлэн 15 жилээр олгодог шүү дээ. 30 жилээр бас олгодог.

Тэгэхдээ яг адилхан гадаадын хөрөнгө оруулагч ч гэсэн 15-30 жилээр олгоод, тэгээд хөрөнгө оруулалтынх нь байдлаас 1 удаа сунгах энэ тэр байдлаар арай багасгах нь зүйтэй гэж бодож байна газар олголтыг бол. Ер нь тэгээд босохгүй байна гэдэг чинь хөрөнгө

оруулалтын босохгүй байна гэдэг чинь аюул дагуулна гэдгийг бас хэлэх гэсэн юм. Жижиг орон өөрийн гэсэн бас дархлаатай байх ёстой гэж үзэж байна. Үеийн үед жижиг орон хөгжихгүй бусадтай нийлье гэсэн бодлого 50 жилийн өмнө, 100 жилийн өмнө ч байсан юм. Өнөөдөр чухал гэдгийг хэлмээр юм.

Бараг ер нь гадаадын хөрөнгө оруулагч зөв орох ёстой л доо. Бид нар хуулийн цоорхойгүй, зөв дэмжиж оруулах ёстой. Хамгийн том хөрөнгө оруулагчид “Оюу толгой”. “Оюу толгой”-г би хувьдаа хөрөнгө оруулагч гэхээсээ “Оюу толгой”, “Рио Тинто” зээл зуучлагч, мөнгө хүүлэгч компани гэж хэлэх байна. Монгол Улс 48 он хүртэл ашиг авахгүй шүү дээ энэ байдлаараа. Монгол Улсын төсвийн 3 хувийг бүрдүүлэхгүй байна шүү дээ. “Оюу толгой” 3 хувийг бүрдүүлэхгүй байна шүү дээ. Уг нь бол 30, 50 хувь, түүнээс дээш хувийг бүрдүүлэх ийм том орд шүү дээ. Дэлхийд 2, 3-д орох том орд. Үүнийг бид нар гадаадынханд бэлэглэсэн шүү дээ. Энд байгаа олон сонгогдсон гишүүд тэр үед энэ хууль батлалцаад Оюу толгойг Монголыг хөгжүүлэх юм шиг бодоод л сайхан яриад л яг үүн шиг Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг ярьж байгаа шиг ярьж байгаад баталж байсан. Энэ алт, зэс, баялгийнх нь борлуулсан мөнгө Монгол Улсын банкаар Монголбанкаар дамжиж орж ирэхгүй шүү дээ. Үүнийг дээрэм, луйвар гэхээс өөр яах юм.

Харин 2 жилийн өмнө Даваасүрэн гишүүн гишүүн Оюу толгойн бүтээгдэхүүний мөнгийг Монголбанкаар дамжуулдаг, Монголынбанкаар дамжуулдаг Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлуулсан юм. Гэтэл Хүрэлбаатар сайд үүнийг унагасан. 30 хоногийн дараа тэр Оюу толгойн мөнгийг Монголбанкаар Монголын банкаар дамжуулдаггүй тийм тогтоолын төслийг оруулж ирээд унагасан. Бүгд мэдэж байгаа. Унах унахдаа хууль зөрчин байж унагасан шүү. Би юу хэлэх гэж байна гэхээр тэр үед

эсэргүүцээд гишүүд кнопоо хаяад гарч байхад тэр үед хүний кноп дарж болдог байсан. Хүрэлбаатар гишүүн босож байгаад 3, 4 кноп арагшаа дарж байгаад 2 хүний саналаар тэр Монголбанкаар Оюу толгойн мөнгө орох, дамжих энэ байдлыг унагасан шүү дээ. Худлаа гэж хэлж чадахгүй л байх. Худлаа гэвэл намайг шүүхэд өгөөрэй. Хүрэлбаатар сайд минь таныг мэднэ. Тантай би 10 жил энд цуг суулаа. Та хэзээ ч Оюу толгойн гэрээг засахын төлөө, энэ муу гэрээг өөрчлөхийн төлөө явдаггүй. Дандаа эсэргүүцэж байсан. Бидний тэмцэл, ажиллагаа бол та нар шиг хүмүүстэй тэмцээр байгаад л үндсэндээ цаг хугацаа алдчихсан. Чи Хотгор шанаганы уурхайг зарсан чинь худлаа юм уу? Үнэн шүү дээ. Ах, дүү нартайгаа нийлээд тэд нарын дансаар чинь, зөвлөхийн чинь дансаар чинь олон сая даалгавар орж ирсэн нь үнэн шүү дээ. Оюу толгойн гэрээ яагаад хам.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Гишүүд хэлэлцэх асуудалдаа орно.

**Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Одоо Байнгын хорооны саналаар, Ардчилсан намын бүлгийн санал, Наянтайн Ганибал гишүүн. Наянтайн Ганибал гишүүн Ардчилсан намын бүлгийн дэд дарга.

**Н.Ганибал:** Хөрөнгө оруулалтын хууль маш чухал шүү дээ. Ардчилсан нам хөрөнгө оруулалтын талд байнга зогсдог. Өнөөдөр Монгол улсад нийт орж ирсэн хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь яг Ардчилсан намын засаг барьж байх үед л орж ирсэн шүү дээ. Өнөөдөр яг ингээд энэ Монгол улсын эрх ашгийн энэ асуудлыг ярьж байх үед ийм сүржис

сүржин мэдэгдэлтэй ямар ч судалгаа, тооцоогүйгээр асуудалд ийм хандах нь буруу. Энэ чинь Монгол Улсын эрх ашиг байх ёстой шүү дээ. Өнөөдөр Ардчилсан намын бүлгийн гишүүд үг хэлэхэд Ардын намын гишүүд, бүлгийн гишүүд ингээд хашихчиж, гуугчиж бас болохгүй ээ. Энэ чинь Улсын Их Хурал гэдэг чинь өөрийн гэсэн дэгтэй асуудлыг хэлэлцдэг, өөрийн гэсэн дүрэм, зарчимтай. Үүнийхээ дагуу л асуудлаа ярья л даа.

Яагаад өнөөдөр Хөрөнгө оруулалтын хуульд шинэчилсэн найруулгууд орж ирээд, заалтууд орж ирээд үүнийгээ тэр судалгаа, тооцоон дээрээ үндэслээд тайлбаруудаа хэл л дээ. Би эх орондоо хайртай, чи эх орондоо хайргүй, би эх оронч, чи эх оронч биш гээд асуудлыг ийм байдлаар хэлэлцэх юм бол энэ хууль зөв гарахгүй. Өөрөө буруу яваад байна. Ийм учраас Ардчилсан намын бүлгийн зүгээс энэ Ардчилсан намын бүлгийн өргөн барьсан Баялгийн сангийн тухай хууль, энэ бүх хуулиудтайгаа нийцүүлээд Монгол улсынхаа эрх ашигт нийцүүлсэн Хөрөнгө оруулалтын хуулийг гаргах ёстой гэдэг үүднээс завсарлага хүсэж байна.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүд ээ,

Хаврын чуулган, намрын чуулган завсарлах дөхөж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тухай хууль бол чухал ач холбогдолтой. Гадаадын шууд хөрөнгө оруулалт төлбөрийн тэнцлийг сайжруулна, өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ, технологи нэвтрүүлнэ, эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулна, ажилгүйдлийг бууруулна, олон талын ач холбогдолтой. Тэгэхдээ энэ асуудлаар маргалдан мэтгэлцэж байгаа талууд, гишүүд байр суурьтай байгаа төдийгүй Засгийн газрын гишүүдийн байр суурь зөрүүтэй, Улсын Их Хурал руу үүн дээр маргаан, мэтгэлцээн өрнүүлсэн. Ийм байдалтай байгаа учраас завсарлагыг өгч байна. Үүнийгээ сайн хэлэлцэж, ард иргэдэд зөв ойлголт өгч, өрсөлдөөнийг

бууруулах ёстой. Ажлын 3 хоногийн завсарлага өгч байна.

11.00 цаг.

Дараагийн асуудалд орно. Өнөөдөр 18 асуудалтай, олон асуудалтай. Дараагийн асуудалд орно.

**Одоо Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэнэ. Хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна.

Тийм, намууд өөр өөр байр суурьтай байгаа учраас.

**С.Бямбацогт:** Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Иргэний нисэхийн тухай хуулийг баталсан. Иргэний нисэхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын тохируулагчийн агентлаг байна гэж тусгасан. Мөн хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн гэж гэж хуульчилсан байх бөгөөд шинэчилсэн найруулгаар Засгийн газрын тохируулагч агентлаг болгон өөрчлөн хуульчилсан.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын төсөвт 2024 оны төвлөрүүлэх орлого, зарлагын

бүрэлдэхүүнд Засгийн газрын тохируулагч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрыг өөрчлөн байгуулах асуудал тусгагдаагүй болно.

Иймд дээрх агентлаг 2024 онд байгуулагдахгүй болсон тул Иргэний нисэхийн тухай хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг 2024 оны 1 сарын 1 гэснийг 2025 оны 1 дүгээр сарын 1 гэж өөрчлөх тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

**М.Оюунчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Иргэний нисэхийн тухай хуулийг Улсын Их Хурал 2023 онд шинэчлэн баталсан бөгөөд уг хуульд иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байна гэж заасан.

Гэвч Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Иргэний нисэхийн ерөнхий газар байгуулахад шаардагдах төсөв, санхүүгийн асуудал тусгагдаагүй

тул Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх хугацааг өөрчлөх агуулга бүхий хуулийн төслийг төсөл санаачлан боловсруулсан болно.

Хуулийн төслийг D-parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно. Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, санал хэлэлцээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагдоржийн Батболд, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхээгийн Мяндасмаа.

Энэ чинь 1 л зүйлтэй, хугацаа хойшлуулсан хууль байгаа юм. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Жадамбын Бат-

Эрдэнэ гишүүн тасаллаа. Орчихсон байна.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл, Баттогтохын Чойжилсүрэн, Чимэдийн Хүрэлбаатар нарын урилгаар Увс аймгийн Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт багш нартаа соён гэгээрүүлэх боловсролын ажилд нь өндөр амжилт хүсэн ерөөе Улсын Их Хурлын гишүүний өмнөөс.

Одоо Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт.

**Ж.Бат-Эрдэнэ:** Иргэний нисэхийн тухай хууль батлагдаад багахан хугацаа өнгөрлөө. 2024 оны төсөвт уг нь бол тодорхой төсвийн асуудал дээр нь хөрөнгө мөнгийг нь шийдээд, тохируулагч агентлаг байгуулагдаад ажиллах нь зүйтэй байгаа юм. Бид өнөөдөр Хөрөнгө оруулалтын тухай хууль гээд энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийг хийхийн тулд энэ чинь дэд бүтэц нь байж байх ёстой. Бие бие рүүгээ аялах ёстой, бие биеийгээ таньдаг байх ёстой, бие биеийгээ улс орнууд хоорондоо харилцаагаа өргөжүүлж байж дараагийн хөрөнгө оруулалт нь өөрөөр хэлбэл аялал жуулчлал нэлээн том хөгжиж байж хөрөнгө оруулалт ордог гэсэн ийм теором, дүрэм байгаа шүү дээ. Нэг нэгийгээ мэддэг байх хэрэгтэй. Энд дэд бүтэц нь хамгийн гол, чухал. Тэр тусмаа иргэний агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах улс хоорондын тээврийн асуудлуудыг сайжруулах. Саяын энэ хууль дотор бол

асар том том өөрчлөлтүүд орсон шүү дээ. Ер нь бол либералчилъя, иргэний нисэхийн энэ агаарын тээврийнхээ асуудлуудыг либералчилъя гэдэг том том асуудлууд орж ирсэн. Бид хэд үндсэндээ бол төсөв дээр мөнгийг нь тавилгүй

ингээд л гар татаад л ингээд л өнгөрөөд явчихлаа.

Би үүнийг юутай холбож байна гэхээр Үндсэн хуультайгаа холбож байгаа байхгүй юу даа. Бид Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад бас хэсэг нэлээн шүүмжлэл хүлээсэн. Энэ юу юм гэхээр бид дараагийн энэ 24 оны сонгуулиас эхлээд ер нь бол энэ дотор нэлээн том либералчлагдсан ийм нөхцөл байдал бий болно. Улс орны асуудлыг шийддэг, улс орны асуудалд анхаарал тавьдаг. Өөрөөр хэлбэл, бидний тэр холимог тогтолцооны яриад байгаа нөгөө 48 гишүүн бол улс орныхоо эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг, ямар нэгэн тойргийн татлаа түлхээгүй ийм нөхцөл байдлаар бид нар улс орныхоо эрх ашгийг шийддэг ийм нөхцөл байдал руу бид нар орж байгаа юм.

Яг өнөөдрийн хувьд бол бид нар үндсэндээ иргэний нисэхийн тэр хэдэн төгрөг тавихад гар татаад, нөгөө тойрог тойрог дээр хэдэн төгрөгөө хуваахын тулд энэ улс орны эрх ашиг бүхий энэ иргэний агаарын тээврийнхээ асуудал дээр 5 төгрөг тавилгүй л, тавьж чадахгүй ингээд л төсөв дээрээ мөнгө татаад л баталчхаж байгаа байхгүй юу даа. Тийм болохоор 2 асуулт байна Бямбаа сайдаа. 2 асуулт байна.

Нэгдүгээрт, энэ төсөв мөнгөгүйгээр үйл ажиллагаа явуулах ийм боломж, бололцоо алга уу? Бүтэц юмандаа зохион байгуулалтаа хийж байгаа юу? Энэ хуулийн доторхоо тодорхой хэмжээний хэрэгжүүлэх асуудлуудыг урьдчилсан бэлтгэл байдлаар хийх ёстой байдаг юм уу? Ямар нэгэн бэлтгэл хийгээд явах асуудал чинь юу болж байна гэдэг тал дээр асуулт байна.

Хоёрдугаарт, хуулийг заавал хойшлуулах албатай юм уу? Хойшлуулахгүйгээр одоогийн байгаа бүтцийнхээ хэмжээнд зөвхөн одоо бол та зөвхөн төсөвтэй холбоотой



асуудлаар хойшлуулчихлаа л гэж би ойлгож байна. Тийм болохоор төсөв мөнгөнөөс үл шалтгаалаад одоогийн байгаа бүтэц дээрээ өөрчлөлт оруулж байгаад цаашаа явах ийм боломж, бололцоо алга уу гэж.

Хоёрдугаарт, хэдий хэмжээний яг төсөв, мөнгөтэй холбоотой асуудал хэдий хэмжээний төсөв мөнгөний хэрэг, зайлиггүй шаардлага гарч байгаа бол энэ чинь яг юу юунд зарцуулагдах гээд байгаа билээ? Ямар шалтгаанаас яг хойшилж байгаа билээ? Энэ төсөв мөнгөтэй л холбоотой асуудал шүү дээ наадах чинь үндсэндээ. Ийм 2 асуултад хариулж өгөөч.

**Г.Занданшатар:** Хэн хариул уу? Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

**С.Бямбацогт:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Иргэний нисэхийн тухай хуулийг бид нар өнгөрсөн жил баталсан 23 оны 7 сарын 7-нд. Анх1997 онд батлагдсан хууль. Түүнээс хойш 25, 26 жил үндсэндээ бол нэмэлт, өөрчлөлт хийгдээгүй, шинэчилж найруулаагүй ингэж явж байсан. 97 оны Монгол Улсын агаарын тээврийн салбарын харилцаа ямар байсан билээ, өнөөдөр ямар болсон билээ дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага юу болсон олон зүйлүүдийг бид нар бас харж, бодолцож Иргэний нисэхийн тухай хуулийг улам өөрчлөд баталсан. Яг үүндээ бас дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага агаарын тээврийн либералчлалын бодлого өнөөдөр амжилттай хэрэгжиж байгаа. Энэ бодлоготойгоо уялдуулъя, бас аюулгүй ажиллагаа улам боловсронгуй болгоё гэдэг агуулгаар энэ хуулийг шинэчилж баталсан боловч сая төсөв батлах үед энэ Иргэний нисэхийн ерөнхий газар буюу Засгийн газрын тохируулагч агентлагийн төсөв батлагдаагүй учраас энэ хуулийн хэрэгжилтийг хойшлуулах шаардлага үүсэж байгаа юм.

Гэхдээ энэ хуулийн хэрэгжилтийг хойшлуулснаараа үндсэндээ өнөөдрийн үйл ажиллагаа иргэний нисэхийн салбарын явуулж байгаа агаарын тээврийн салбарт явуулж байгаа бодлого, үйл ажиллагаа бол тасалдахгүй, хүндрэл учрахгүй. Урьд нь ч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байдлаар ажиллаж ирсэн. Одоо яг энэ бүтцээр ажиллаж байгаад ирэх онд үндсэндээ тохируулагч агентлагаар 25 оны 1 сарын 1-нээс ажиллаад явна. Тэр болтол ямар нэгэн байдлаар үйл ажиллагаа доголдох, саатах ийм зүйл гарахгүй, үйл ажиллагаа бол хэвийн хэмжээнд явагдана гэдгийг танд бас хэлье.

Иргэний нисэхийн ерөнхий газар, Иргэний нисэхийн үндэсний төвийн бас нийт орлого бас сая КОВИД, цар тахлын жилүүд нэлээн багассан, буурсан байсан. Энэ 23 оны сүүлийн хагасаас эхлээд жоохон нэмэгдэж байгаа. Ирэх онд харьцангуй бас жоохон нэмэгдэх болов уу. Ямар ч байсан бас алдагдалтай биш, ашигтай ажиллах ийм бас орлоготой ажиллах, улсын төсөвт бас төсөв мөнгө төвлөрүүлэх ийм бас боломж, бололцоо бүрдэж байгаа. 2022 онд 300 тэрбум төгрөгийн төсөвт орлого оруулах төлөвлөгөөтэй байсан. 150 тэрбум төгрөгийн орлого оруулж байсан бол энэ жил 170 орчим тэрбум төгрөг болж орлого маань бага бага зэрэг нэмэгдэж байгаа. Ийм байдлаар үндсэндээ бол бас ямар ч гэсэн үйл ажиллагаа саадгүй явуулах бас бололцоо, боломж бүрдэнэ гэдгийг танд бас хэлье.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдье. Санал хураалт бүртгэлийн санал хураалт. Өнөөдрийн анхны санал хураалт учраас. Энэ бүртгэлийн санал хураалт бүртгэлд ороогүй гишүүдийг дахиж бүртгэе.

Байнгын хорооны саналаар Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт

өргөн мэдүүлсэн Иргэний нисэх тийм уучлаарай. Хоёулаа хугацааг нь сунгаж байгаа. Адилхан юм байна.

Байнгын хорооны саналаар Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

65.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ анхны хэлэлцүүлгийг. Дараагийн асуудалд орёё.

11.13 цаг.

**Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Төмөр замын тээврийн тухай хуулийг баталсан. Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг байна гэж заасан.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын төсөвт 2024

оны төвлөрүүлэх орлого, зарлагын бүрэлдэхүүнд Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Төмөр замын газар байгуулах асуудал тусгагдаагүй болно.

Иймд дээрх агентлаг нь 2024 онд байгуулагдахгүй болсон тул Төмөр замын тээврийн тухай хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний гэснийг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний гэж өөрчлөх тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Монгол ардын намын бүлгийн дэд дарга, Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

**М.Оюунчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төмөр замын тээврийн тухай хуулийг Улсын Их Хурал 2023 онд шинэчлэн баталсан бөгөөд уг хуульд төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг төмөр замын газартай байна гэж заасан. Гэвч Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төмөр замын газар байгуулахад шаардагдах төсөв, санхүүгийн асуудал тусгагдаагүй тул

Төмөр замын тээврийн тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх хугацааг өөрчлөх агуулга бүхий хуулийн төслийг төсөл санаачлагч боловсруулсан байна. Хуулийн *D-parliamnt.mn* цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслүүдийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төмөр замын тухай, Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан, Төмөртоогоогийн Энхтүвшин нарын урилгаар Дорноговь аймгийн Сайншанд сум дахь Улаанбаатар төмөр замын Барилга, үйлчилгээний 3 дугаар ангийн ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын

гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн гишүүд түрүүчийн хуулийн төсөлтэй нэг адил. Итгэлт нэмэгдсэн байна. Энэ нэр нь ирээгүй байна.

Хууль санаачлагчийн итгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Гонгорын Дамдинням гишүүнээр тасаллаа. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Иргэний нисэхийн тухай хууль Төмөр замын тээврийн тухай хууль хоёр чухал хууль батлагдсан. Хэрэгжих хугацаа нь хойшилж байгаа юм байна. Яагаад хойшилж байна гэхээр үндсэндээ бол агентлаг байгуулагдаагүй нэгдүгээрт. Байгуулагдах үндэслэл нь төсөв дээр агентлагийн зардлыг тавьж өгөөгүй. Энэ шалтгаанаар болоод энэ хоёр тээврийн асуудал тээвэр дээр шийдэгдэх ийм том асуудлууд энэ хойшилж байна. Би үүнийг бас дахиад хэлье энэ юутай холбоотой байна гэхээр нөгөө л бид нарын тогтолцоо. Бид Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулсан энэ бол маш зөв зүйл болжээ гэдгийг одоо үүгээр харж байгаа юм. Үүнээс өмнө бид нар яаж байсан гэхээр ерөөсөө л тойргийн тогтолцоогоор л байлаа шүү дээ. Тойрог дээрээ 5 төгрөг тавихын төлөө л ингээд л төсвөө нааш нь цааш нь татаж чангааж л байсан.

Яг улсын чанартай төмөр замтай холбоотой асуудал, иргэний агаарын тээвэртэй холбоотой асуудал, бүх асуудлуудыг нь шийдэх энэ чинь хоёр улсын хооронд хоорондын тээврийн асуудлууд байж байна. Хоёр том улсын хооронд, дотор байж байгаа Монгол Улсын хувьд бол гадагшийг гарах бүх тээврийнхээ асуудлуудыг бүрэн дүүрэн либералчилж шийдэх ийм том асуудал харагдаад байгаа шүү дээ. Энэ тээврийн асуудлыг шийдэж байж бид нар яана

гэхээр цаад талд нь үнийн асуудлууд байж байна. Ард иргэд дээр очиж байгаа тээвэрт хөнгөлөлтийн асуудлууд байж байна. Үнэ өсгөх асуудлуудыг боомилох, үнэ өсгөх асуудлуудыг зогсоолгох асуудал чинь дандаа тээвэртэй холбоотой байна. Энэ гол асуудлуудыг та бүхэн маань мэдэж байгаа мөртөөрөө үндсэн төсөв дээрээ яг мөнгө төгрөгийг нь тавьж өгөөгүй. Энэ чинь юутай шалтгаалж байна гэхээр нөгөө л өөр өөрсдийнхөө тойрог дээр мөнгө төгрөгөө татаж чангаасаар байгаад л тэгээд л. Яг улсын чанартай, улсын асуудал дээр болохоор тодорхой хэмжээний мөнгөн асуудал шийдэж өгдөггүй.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулснаар энэ халагдана. Бид хойноосоо татлаа түлхээгүй яг улсынхаа асуудлуудыг хардаг ийм боломж, бололцоо бий болно. Нөгөө бид нарын шүүмжлээд байгаа 48 гишүүн буюу жагсаалтаар орж ирэх гэж байгаа гишүүд чинь жинхэнэ улс орныхоо эрх ашиг бүхий ийм том том асуудал дээр төсөв хуваарилдаг ийм боломж, бололцоо бид нарт гарна.

Өөрөөр хэлбэл, улсын эрх ашгийг нэгдүгээрт тавьж байх ийм боломж, бололцоо бол гарна. Энэ бол яг бид нарын хуучин тогтолцооны хортой үр нөлөө бол энэ төмөр зам дээр, энэ иргэний нисэх дээр гарч байгаа шүү. Бидний юмны үнэ нэмэгдээд л байна гэж байгаа. Хаана байна тэр гадагшаа гарч байгаа тээвэр бүгдээрээ зогсчихсон, төмөр замын асуудлууд бүгдээрээ зогсчихсон. Төмөр замын либералчлалын асуудлуудыг ярихаар тэр нь бол ярихын хувьд бол сайхан сайхан яриад байдаг. Гэтэл яг шийтгэх гэхээрээ хуулийг нь баталж өгчхөөд агентлагийн байгууллагагүй л асуудал байхгүй юу даа.

Хэрвээ төмөр замын асуудлууд байгаад энэ жилээс ядаж 1 жилийн дотор гүйцэтгэл нь бий болоод төмөр замын хоорондын холбооснуудыг шийдвэрлэх, зохицуулалтуудыг

шийдвэрлэх, тэгээд цааш цаашидаа бол хоёр улсын хоорондын, улс хоорондын төмөр замынхаа асуудал, төмөр замын тээвэрлэлтийн асуудал, транзит тээврийн асуудлууд эд нар гээд нэлээн том том хаалганууд нээгдэх боломж, бололцоо маань ингээд хаагдаад байна шүү дээ. Энэ юу вэ гэхээр эдийн засагт оруулах төмөр замын болон иргэний нисэхийн энэ том нөлөөллүүд чинь бас л хаалттай хэвээрээ бүтэн 1 жил хойшоогоо сунгах, сунгагдах, хойшоогоо тавигдах ийм асуудал бий болчхоод байгаа юм. Одоо яая гэх вэ одоо 1 жилээр хойшлох юм байна.

Гэхдээ хэлэх зүйл нь ямар ч л байсан хууль дотор тусгасан либералчилж байгаа тэр төмөр замын байгууллагуудын, аж ахуйн нэгжүүдийн хоорондын холбоос хэлхээсийг, зохицуулалтыг хийдэг олон төмөр замын байгууллагууд бий болж байгаа. Олон хувийн том компаниуд бий болж байгаа, дэд бүтэц хариуцсан, доод суурь бүтэц хариуцаж байгаа, тээвэрлэлт хариуцаж байгаа олон хувийн хэвшлийн компаниуд бий болж байгаа. Эд нарыг ажиллах боломж, бололцоог нь гаргаж цаашаагаа хуулийнхаа хүрээнд ажиллаарай. Хуулийнхаа боломж, бололцоог нь аль болох одоогийн нөхцөл байдалдаа тохируулаад, өөрчлөлт хийгээд, шинэчлэлт хийгээд ажиллаарай гэдэг зүйл л хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гонгорын Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Төмөр замын тээврийн тухай хууль өөрчлөлт ороод энэ агентлаг нь л хойшилж байгаа юм байна л даа. Зам, тээврийн сайдаас асуух асуулт бол хоёр асуулт байна.

Нэгдүгээрт, энэ агентлаг байгуулагдаад явах юм бол одоо манай эдийн засагт хэр хэмжээний өсөлт өгөх гээд байгаа юм? КОВИД-ын үеийн тээвэртэй холбоотой маш их будилаан, дуулиан сонсогдоод байгаа. Удахгүй бид

нар Их Хурлаараа ярих байлгүй дээ тиймээ? Тэгээд хэн нь хаана юу хийгээд байсан юм гэдгийг бүгдээрээ харж байсан байх. Бөмбөлөгч гээд л юмнууд явдаг. Төмөр замд ажиллаж байсан нэг залуугийн гэрээс нь 9 тэрбум төгрөг бэлнээр гарч ирж байдаг. Энэ заваарсан авлигын сүлжээтэй холбоотой юмнууд нь энэ хууль уг нь хэрэгжээд явсан бол арилах боломж нөхцөл нь дээрдэх байсан уу? Төсөв дээрээ орж ирээгүй гээд хойшилчхож байгаагаараа бид нар хэр хэмжээний боломжийг алдаад байгаа юм?

Хоёрдугаар асуулт бол манай Дарханы төмөр замчид маань бас надаас асуугаад байгаа юм. Энэ машинч, туслах машинчдын энэ хүмүүсийн хөөрхий улсын хэмжээнд энэ чинь бас нэлээн байдаг юм байна шүү дээ. 1000 гаруй хүмүүс байдаг юм байна. Энэ хүмүүсийн энэ хөдөлмөрийн аюулгүй байдлын тэр үнэлгээ хийлгээд хорттой нөхцөл болгох тэр асуудал ер нь хаана яваа юм бэ? Хөөрхий дундаж наслалтыг нь хараад үзвэл энэ хүмүүс чинь ерөөсөө шөнө оройгүй ингэж явдаг.

Тэгсэн мөртөөсөө хүнд нөхцөлд явдаг мөртөөсөө хорттой нөхцөлд ордоггүй, хорттой нөхцөлд ордоггүй учраас тэтгэвэрт эрт гарч чаддаггүй. Хөөрхий дундаж наслалт нь хэцүү юм байна лээ шүү дээ энэ хүмүүс. Тэгэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдлын энэ тэр зөвлөл гэдэг юман дээр нь л явж байгаа юм байна лээ. Энэ сайд нар хоорондоо ярьж байгаа юу? Энэ хүмүүсийн энэ хөдөлмөрийн нөхцөлийг хорттой нөхцөлд тооцуулах ажил ер нь ямархуу түвшинд явж байгаа вэ? Ийм 2 асуулт байна.

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Энэ Төмөр замын тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуулийн ажлын хэсгийг

манай Ж.Бат-Эрдэнэ гишүүн ахалж ажилласан. Мааш сайн ажилласан, мааш их бас анхаарал тавьж ажиллаж, өөрөө бас энэ салбарт ажиллаж сайд энэ хийж байсан хүний хувьд бас мааш их сэтгэл гаргасан Бат-Эрдэнэ гишүүндээ бас их баярлалаа. Хууль хэрэгжихгүй байж байгаад хойшилж байгаад бас харамсаж байгаад нь бас баярлалаа бас.

Дамдинням гишүүний асуултад хариулъя. Энэ манай салбар, тээврийн салбар өнгөрсөн 2023 онд хамгийн өндөр өсөлттэй салбар болсон. Монгол Улсын эдийн засаг 7 хувь өсөж байгаа 2023 онд. Манай зам тээврийн салбар 73 хувийн өсөлттэй гарч байгаа. Өнгөрсөн жил бид нар 2022 онд 60 сая тонн ачаа тээвэрлэж байсан бол бид нар 106 тонн ачаа тээвэрлэсэн. Авто тээвэрээр бид нар 30 гаруй сая тонн ачаа тээвэрлэж байсан бол 65 сая тонн ачаа тээвэрлэсэн. Төмөр замаар бид нар түүхэн дээд амжилтад 2021 онд 31 сая тонн ачаа Улаанбаатар төмөр зам тээвэрлэж байсан бол Улаанбаатар төмөр зам 32 сая тонн ачаа, нийтдээ төмөр замаар бид нар 35 сая тонн ачаа тээвэрлэсэн байгаа.

Ийм байдлаар үндсэндээ манай салбарт хамгийн өндөр өсөлтүүд бий болсон. Энэ хэмжээгээрээ үндсэндээ мэдээж ч энэ салбарт ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын орлого нэмэгдэж байгаа, ажиллах нөхцөл сайжрах бололцоо, боломж бий болж байгаа юм. Ийм бас өсөлтүүд гарсан гэдгийг танд хэлье. Мэдээж цаашидаа янз янзын хэл ам гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллаж байгаа. Урьд нь та ярьж байгаа тэр Батдөл мэтийн ашиг сонирхол, авлигал авдаг асуудлууд манай салбарт гараагүй. Цаашидаа гарахгүй. Энэ талд мааш хатуу анхаарч Зам, тээврийн хөгжийн яам 2023 оныг бүрэн цахимжсан, бүтээмжийг дээшлүүлж, хариуцлага үр дүнг тооцох жил болгон зарласан. Үүний бас үр дүн бас амжилттай гарсан гэдгийг танд бас хэлье.

Хоёрдугаарт нь Дарханы замчидтай холбоотой асуудал, төмөр замчидтай холбоотой асуудал ярьж байна маш чухал. Зөвхөн Дарханы төмөр зам ч биш Улаанбаатар төмөр зам нийт төмөр замтай холбоотойгоор үндсэндээ төмөр замчид маань бас нэлээн хүнд, хортой нөхцөлд, дээрээс нь бас онцгой нөхцөлд ажилладаг. Энэ төмөр замын тээвэр маш онцгой нийгмийн болон стратегийн чухал ач холбогдолтой салбар. Энэ үүднээс энэ ажиллаж байгаа төмөр замчдын хөдөлмөрийн нөхцөлийг бид нар бас Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай яриад хөдөлмөрийн бас хүнд, хортой нөхцөлд хамруулахаар явж байгаа. Энэ асуудал үндсэндээ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаман дээр шийдэгдэхээр шийдлээ олохыг хүлээж байгаа гэдгийг бас хэлье.

Энэ таирамд хэлэхэд Улаанбаатар төмөр зам бас өнгөрсөн 2023 онд бас өөрөө бас түүхэн дээд амжилтуудыг тогтоосон. Галт тэрэгний солилцоо, Эрээн-Замын-Үүдийн хооронд Орос-Монголын хооронд ч гэсэн гэдэг юм уу дээрээс нь юу гэдэг юм түүхэн тээвэрлэсэн ачаа, их өрнөөсөө салсан, 5 зүтгүүрүүд нэмэх бололцоотой болсон, дүрмийн сангаа нэмэгдүүлсэн гээд олон амжилтууд гарсан байгаа. Үүн дотор бас төмөр замчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлсэн 2023 онд. Дээрээс нь 200 хувиар 13 дахь сарын цалинг 200 хувиар бас олгосон гэх мэтийн бас. Үндсэндээ өнгөрсөн жил 22 онд 60 тэрбумын алдагдалтай ажиллаж байсан Улаанбаатар төмөр зам 23 онд 70 тэрбумын ашигтай ажиллаж байгаа. 70 тэрбумын ашигтай ийм байдлаар үндсэндээ үйл ажиллагаа нь бас сайжирч байгаа гэдгийг танд бас хэлье.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд ишлжүүлээ. Дараагийн асуудалд орно.

11.28 цаг.

**Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалттай машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.**

Хуулийн төслийг, хууль санаачлагчийн илтгэлийг Шадар сайд Сайнбуяны Амарсайхан танилцуулна.

**С.Амарсайхан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд 2019 онд байгуулсан Санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд онцгой байдлын байгууллагад агаараас эрэн хайх, аврах анги байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийг Онцгой байдлын ерөнхий газарт амжилттай хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд гал унтраах тусгай зориулалт бүхий нийт 42 автомашин нийлүүлэгдсэн бөгөөд 2023 оны 12 дугаар сарын байдлаар 2343 удаагийн дуудлагаар үүрэг гүйцэтгэж, 1699 хүний эрдэнэт амь нас

аюулгүй байдлыг ханган ажиллаж, 357.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг авран хамгаалаад байна.

Монгол Улсын Засгийн газраас энэ төслийн хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг харгалзан үзээд дараагийн шатын төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн билээ. Гэрээ байгуулах тухай санал, гэрээний төслийг урьдчилан Улсын Их Хуралд хүргүүлж, Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн зөвшилцсөн.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх санхүүгийн хэлэлцээрт талууд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Парис хотноо гарын үсэг зурсан болно.

Энэ хэлэлцээрийн дагуу олгох 13.3 сая еврогийн зээл нь жилийн 0.2 хувийн хүүтэй 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 15 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх хөнгөлөлттэй нөхцөлтэй болно. Төслийн 2 дугаар шатыг хэрэгжүүлснээр хэт хүйтний болон давчуу орчин нөхцөлд ажиллах чадвартай хөөсөөр гал түймэр унтраах болон 32, 42 метр хүртэлх өндөрт ажиллах шатын 18 нэгж гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэгдэх юм. Эдгээр автомашинууд нийлүүлэгдсэнээр Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа гал түймэр унтраах автомашин, техник тоног төхөөрөмжийн хүчин чадал нэмэгдэхээс гадна ялангуяа газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, агуулах, шатахуун түгээх станц, томоохон хэмжээний худалдааны төвд гарсан гал түймрийг түргэн шуурхай унтраах чадавх улам нэмэгдэх юм.

Энэ хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Амартүвшин:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Онцгой байдлын ерөнхий газар гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүйн байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Г.Амартүвшин нар хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Онцгой байдлын ерөнхий газарт хөөсөөр гал унтраах тоног төхөөрөмж хэчнээн байгаа, сүүлийн үед баригдсан, баригдаж байгаа 12 давхраас дээш өндөр давхартай барилга, байгууламжид галын нэгдсэн систем, гал унтраах төхөөрөмж

суурилагдсан болон суурилагдаж байгаа эсэх төслийн хүрээнд худалдан авах гал унтраах тусгай зориулалтын машины шинэ эсэхийг, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат уг зээл нь Засгийн газрын өрийн хязгаарт багтаж байгаа эсэх, эдгээр тусгай зориулалтын машины засвар үйлчилгээг хэрхэн шийдэх, техникийн үйлчилгээ үзүүлэх нэгж нь Монгол Улсад байгуулагдах боломжтой талаар ажлын хэсгээс тодруулан асууж, хариулт авсан болно Онцгой байдлын ерөнхий газраас гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Онцгой байдлын ерөнхий газар гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх талаарх Аюулгүй байдлын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Гочоогийн Ганболд гишүүнээр тасаллаа. Мөнх-Оргил, Цэндийн Мөнх-Оргил гишүүнийг нэмлээ. Ингээд тасаллаа. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг нэг. Соёрхон батална.

**Д.Өнөрболор:** Энэ санхүүгийн хэлэлцээрийг миний бие дэмжиж байгаа юм. Энэ онцгой байдлын байгууллагын ер

нь энэ гал түймрийг унтраах, аврах ангийн хүчин чадал өндөртэй ийм шинэ үеийн тоног төхөөрөмжөөр хангах зайлиггүй шаардлагатай гэж үзэж байгаа Энэ агуулгаараа ч гэсэн энэ чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагууд санал хүсэлтийг бас авч хэлэлцээд миний хувьд бол бас гадаад харилцаа, хамтын ажиллагааныхаа хүрээнд бас энэ гал унтраах автомашиныг Бүгд Найрамдах Солонгос Улсаас бас буцалтгүй тусламжаар бас тодорхой хэмжээгээр шийдвэрлэсэн байж байгаа. Нэн ялангуяа Сэлэнгэ аймаг бол хүнсний гол тээвэр хийдэг ийм бус нутаг байгаа. Энэ гамигийн эрсдэлийг бас бууруулах энэ бэлэн байдлыг хангах асуудал бол нэн шаардлагатай байсан.

Тэр агуулгаараа энэ Сэлэнгэ аймгийн хувьд энэ бүсчилсэн хэлбэрээр энэ Ерөө, Зэлтэр бүсэд амьдардаг иргэд, аж ахуйн нэгжсийн энэ аюулгүй байдлыг тодорхой хэмжээгээр хангасан гэж үзэж байгаа. Өнөөдөр энэ онцгой байдлын байгууллагын I албан хаагчид дунджаар 32.1 квадрат километр талбай ноогдож, өндөр ачаалалтай ажилладаг юм байна лээ. Орон нутаг, тэр дундаа алслагдсан энэ сумдад бүүр өндөр байж байх жишээний.

Тэгэхлээр Бүгд Найрамдах Солонгос Улсын тухайлах юм бол бид нар бас энэ онцгой байдлын улсуудтай бас харилцан туршилага судалж байхад энэ иргэдийнхээ эрүүл аюулгүй байдал, нэг хүний иргэний эрдэнэт амь насыг хангах, баталгаажуулах, хамгаалах тал дээр маш их ач холбогдол өгч, үндсэндээ дэд бүтэц, материаллаг баазын хувьд бол маш сайн хангагдсан байдаг юм байна лээ. Тухайлах юм бол I хүнийг аврах цаг хугацааг 3 минутад I хүнийг аврах ийм заалттай байхад манай Монгол Улсын хувьд гээд тэгэх юм бол үндсэндээ цогцыг эрж хайх ийм л нөхцөл байдалтай байгаад байгаа юм байна лээ.



Тэгэхлээр үүн дээр цаашидаа материаллаг бааз, нэн ялангуяа дэд бүтцийг бүрдүүлэх тал дээр маш ач холбогдол өгч зохицуулах нь чухал шаардлагатай юм байна лээ гэдэг эндээс харагдсан.

Нөгөөтээгүүр энэ Монгол Улсын Засгийн газар, энэ Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийн соёрхон батлах энэ хуулийн төслийн хүрээнд шийдвэрлэж байгаагаас гадна өнгөрсөн онд байна уу даа энэ нийслэлтэй ойролцоогоор бас яг энэ тусгай зориулалтын автомашин гал унтраах энэ аврах ангийн автомашиныг, 100 автомашиныг бас Бүгд Найрамдах Солонго Улсаас буцалтгүй тусламжийн хүрээнд бас нийлүүлэхээр ингээд зохицуулалт хийсэн байж байгаа. Тэгэхлээр Онцгой байдлын ерөнхий газар яг энэ нийслэлийн энэ зохицуулалт дээр бас тодорхой хяналт тавьж байгаа юу, эсвэл та бүгд бас энэ гэрээ хэлэлцээрийн талаар ямар ойлголттой байна? Энэ талаар бас та бүгдээс тодруулъя.

Нөгөөтээгүүр гээд тэгэхлээр энэ нисэгчгүй нисэх төхөөрөмж буюу тусгай зориулалтын агаарын дроныг ашиглах асуудал маш чухал юм байна лээ. Бас энэ Онцгой байдлын газрынхан маань бол энэ дээр нэлээн анхаарал тавьж ажиллаж байгаа байх. Нэн ялангуяа энэ Онцгой байдлын байгууллагатай хамтарч энэ гамшиг, осол, аюулт үзэгдлийн эсрэг бэлэн байдлыг хангах энэ мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийн тоо төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр, мөн хяналтын бүхэл бүтэн ийм удирдах ийм төвүүдийг байгуулах чиглэлээр бас нэн ялангуяа бас тэр Солонгос улсаас бол бас баг ирж ажилласан байж байгаа. Энэ талаар бас яг ямар шийдэлд хүрсэн байгаа талаар бас Ариунбуян генералаас тодруулж асууя.

Ер нь энэ гамшиг, ослын үед энэ иргэдийн амь нас, эд хөрөнгө аюулгүй бай.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Ариунбуян генерал хариулъя, 82.

**Г.Ариунбуян:** Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа гал унтраах тусгай зориулалтын автомашины хангалт 59 хувьтай, нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 55 хувьтай байгаа. Энэ ашиглалтын хэрэгцээ, шаардлагаас хамаараад ашиглаж байгаа нөхцөл байдлаас үүдээд бас тодорхой хугацаанд шинэчлэх, парк шинэчлэлийг хийх ийм зайлшгүй шаардлага тулгардаг. Өөрөөр хэлэх юм бол онцгой байдлын байгууллага өнөөдөр 50 гаруй хувийн хүчин чадалтайгаар энэ үйл ажиллагааг зохион байгуулж, ард иргэдээ авран хамгаалах ажлыг гүйцэтгэж байна.

330 гаруй сумаас яг гал унтраах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа манай салбар нэгжтэй, ангитай 30 сум л байна, 30 сум. Аймгийн төвөөс алслагдсан сумуудад бид нар хүрч зочилж ажиллахад бас хүндрэлтэй. Зам харгуй, дээр нь энэ нийслэл Улаанбаатар хотод гэхэд авто замын түгжрэл дээр нь энэ барилга, байгууламжийн, хот буруу төлөвлөлттэй холбоотой асуудлуудаас болж цаг хугацаа алдах ийм тохиолдлууд гарч байна.

Тийм учраас цаашидаа энэ алслагдсан сум, суурин газруудад нийслэл Улаанбаатар хотуудад энэ хүн амын төвлөрөл бий болсон суурин газруудад шинээр эрэн хайх, аврах анги, салбарыг байгуулах, орон тоог нэмэгдүүлэх, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах ийм хэрэгцээ, шаардлага байгаа юм гэдгийг хэлье.

Нисэгчгүй тоног төхөөрөмжийн хувьд бид нар их анхаарч байна. Ялангуяа сүүлийн үеийн алслалттай нисэх хүчин чадал бүхий нисэгчгүй тоног төхөөрөмжийг бэлэн байдлыг хангах чиглэлээр Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Турк улс, Солонгосын КОЙКА

байгууллагуудтай бид нар төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

**Г.Занданшатар:** Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Г.Ганболд:** Зээлийн хугацаа, зээлийн нөхцөл, эргэн төлөгдөх энэ тэр дээр ямар ч асуудал алга. Өмнөх төлсөн ч гэсэн ийм л хүүтэй байсан. Гэхдээ яг цаанаасаа нөгөө нийлүүлэгдэж байгаа техникүүдийн чанарын асуудал дээр бид нар бас анхаарах ёстой. Өмнөх нийлүүлсэн нисдэг тэрэгнүүдийн хувьд яг нисэхийн мэргэжлийн хүмүүсийн ярьж байгаагаар тэр мөнгөөр бараг л шинэ нисдэг тэрэгнүүд авчихаар хэмжээний л байсан гэж ярьдаг юм байна лээ. Тэгэхээр одоо яг энэ нийлүүлэх гэж байгаа техникүүд нь цаанаасаа яг ийм техникүүд нийлүүлэх ийм болзол, шаардлагатай юм уу, эсвэл манайхан өөрсдөө энэ авах техникүүдээ сонгосон юм уу? Яг энэ техникүүд нь яг өмнөхтэйгөө адилхан байна уу, эсвэл яг цоо шинэ Францын ийм машинууд байна уу гэдгийг асууя.

Улаанбаатар хотод хамгийн өндөр барилга хэдэн метр байгаа вэ? Яг энэ дотор бол хамгийн урт сунах нь 42 метр өндөр сунах юм байна. Тэгэхээр 14, 15 давхарт л хүрэх нь гэж би ойлгоод байна даа. Тэгэхээр энэ 32 метртэй 10 машин энэ тэрийгээ цөөлөөд өшөө илүү сунах, хамгийн өндөр барилгууд дээр гал гарах юм бол бид нар ямар ч нэмэргүй болчихоод байна шүү дээ. Энэ чиглэл рүү эсвэл энэ төслөөсөө өөрчлөөд 42-оос илүү 60, 70 метр сунадаг ийм машин явах боломж байгаа юу? Эсвэл яг Өнөрболор гишүүний хэлж байгаа үнэн л дээ. Одоо гал гарлаа гэхэд Улаанбаатар хот чинь түгжэрэл асар ихтэй, нөгөө гал командын машинууд түгжирч явсаар байтал энэ галын цаашаа бүүр даамжраад явчихдаг. Тэгэхээр тэр дроны асуудлыг энэ төсөл дотроо энэ зарим машинууд авах мөнгөнөөсөө шийдээд 1 ч болтугай дрон аваад энэ өндөр барилгууд дээр хэрвээ галын осол аваар гарах юм бол шийдээд

явах ийм боломжууд байгаа юу? Энэ дээр би товчхон хариулт авъя.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт багш, сурагчдадаа сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс.

Одоо хэн хариулах юм? Ариунбуян генерал 82, Онцгой байдлын ерөнхий газрын дарга.

**Г.Ариунбуян:** Ганболд гишүүний асуултад хариулъя. Энэ төслөөр нийлүүлэгдэх гал унтраах тусгай зориулалтын автомашинууд “Рено” гэдэг компанид үйлдвэрлэсэн Францын “Рено” компанид үйлдвэрлэсэн цоо шинэ машин. Үнэ өртгийн хувьд одоогийн зах зээлийн үнээс өөрөөр хэлэх юм бол Австрийн “Rosenbauer”, Польш гээд евро стандартыг хангасан машинуудаас 200-300 мянган доллароор бага ийм өртөгтэй байгаа. Хөөсний хувьд дундаж үнийг барьж байгаа юм.

Өнөөдөр Улаанбаатар хотоор жишээ авахад нийт статистик тоон мэдээллээр 8, 9 давхраас дээш барилга байгууламж байна. Энэ 42 метрийн шат бол 14-15 давхарт гарсан гал түймрийг унтраах, гамигийн голомтод үүрэг гүйцэтгэх боломжтой болох ийм нөхцөлтэй. Таны хэлдэг 60 метр гэдэг юм уу тэрнээс дээш өндөртэй гал унтраах зориулалтын автомашины хувьд 2 улсад л үйлдвэрлэдэг. Энд манайд орж ирээд үүрэг гүйцэтгэх бас талбай, орон зай их ч хамаардаг учраас одоо ийм шаардлагад нийцэхгүй байгаа гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** 15-аас дээш гэж байгаа юм уу?

**Г.Ариунбуян:** 15-аас дээш давхарт гал түймэр гарсан тохиолдолд барилгын норм, дүрэм, стандартын дагуу бид нар зураг хяналтаас авхуулаад барилгыг байнгын ашиглалтад хүлээж авах хүртэл хяналтаа тавина. Барилгын усан дотуур хангамж, галын аюулгүй байдлын тохиолдол энэ системүүдийг ашиглаж гал унтраах ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. Мөн энэ 42 метр шатыг ашиглаж манай аврагч, гал сөнөөгч нар гал барилга дотор гарсан галыг унтраах үйл ажиллагаанд бас дэмжлэг үзүүлж, богино хугацаанд үйл ажиллагаа зохион байгуулахад их ач холбогдолтой гэж үзэж байна.

**Г.Занданшатар:** Одоо Цэндийн Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Оруулж ирсэн асуудлыг дэмжиж байгаа юм. Хоёр л асуулт гэх юм уу, санал байна.

Нэгдүгээрт, Яах вэ бид нар машинаа аваад байдаг юм байж. Нөгөө машинууд маань энэ орон байр руугаа хүрч очиж чадах уу? Гэр хорооллууд руугаа тэр нарийхан хашаануудын дундуур явж амжих уу, манай энэ хотын төвд энэ олон давхардсан хашаануудын дундуур гарч чадах уу? Хэдэн жилийн өмнө манай Сүхбаатар дүүргийн энэ 8 дугаар хороонд Их сургуулийн хойд талд, 4 дүгээр байрны хойд талд гал гараад гал командын машин нь очиж чадаагүй шүү дээ. Тал талаас нь баахан хашаа татаад хаячихсан. Тэгээд хэчнээн гоё машинтай байгаад энэ олон хашаануудыг чинь нураахыг нь нурааж байшин болгонд гал команд, цагдаа, түргэний тэрэг очдог бололцоо бүрдүүлж өгөхгүй бол жинхэнэ гамшигийн нөхцөл чинь тэнд байна шүү. Энэ дээр хоттой нийлж ямар арга хэмжээ авч байна? Санал онол юу байна? Сонирхуулаач бидэнд.

Хоёр дахь асуудал энд би илүү Шадар сайдад хандаж санал тавьж байгаа юм. Яах вэ Францаас хэдүүлээ машин оруулаад ирлээ л дээ. Үүний

хажуугаар өшөө би санаж байна 2004 онд Японоос нэлээн их гал командын машин оруулж ирсэн юм. Одоо Солонгосоос орж ирж байгаа юм байна. Аягүй бол ингэж байгаад Оросоос орж ирнэ гээд л ерөөсөө салбар болгонд янз бүрийн машин, техник, тоног төхөөрөмж орж ирээд байдаг. Тэгээд сэлбэгийнх нь үнэ нь дийлддэггүй, тэрийг засдаг тэр засварын ажилчид нь олддоггүй, үйлчилгээнийх нь зардал нь дийлддэггүй. Нэгдсэн бодлоготой болмоор байгаа юм.

Жишээ нь бид нар энэ манай Нийгмийн бодлогын байнгын хороон дээр эмийн хууль эмийн хэрэгслийн хууль хэлэлцэж байгаа байхгүй юу. Ерөөсөө яг адилхан. Эмийн хэрэгсэл гэхлээр Японоос ороод ирнэ, Солонгосоос ороод ирнэ, Америкаас ороод ирнэ, Оросоос ороод ирнэ. Сэлбэг нь олддоггүй. Тэр нарийн засвар хийдэг техникчид нь цөөхөн. Уул нь төрөөс бодлого гаргаад ядаж төрийн өмчийн байгууллагуудад, эмнэлгүүдэд нэг газраас нэг чанартай тоног төхөөрөмж нийлүүлээд байх юм бол түүний сэлбэг, үйлчилгээ эд нар хамаагүй хямдхан болох гээд байгаа байхгүй юу. Үүнийг ганцхан манайд биш бусад олон оронд хийгээд байгаа байхгүй юу.

Жишээ нь миний сонссоноор, би зүгээр сонссоноор л ярьж байгаа шүү. Очиж үзээгүй. Лаос-д бол цагдаа, эмнэлэг, түргэн, шийдвэр гүйцэтгэл, хилийн цэрэг, энэ онцгойдоо Toyota-той гэрээ байгуулаад тусгай зориулалтын машинуудаа авчаж. Манайхаар бол аймгийн төвүүд дээрээ засвар үйлчилгээний төвүүдтэй, сэлбэгийн зардал багатай, засварын зардал багатай, найдвартай. Олноор нь олон жилийн хугацаатай Засгийн газар гэрээ байгуулчихвал нөгөө компаниуд ч дуртай, зардал мөнгө нь ч 20, 30 хувиар буугаад явчихдаг. Ингэж нэгдсэн техник, технологийн бодлого руу шилжүүлэхгүй бол, хангамжийн бодлого руу шилжүүлэхгүй бол энэ ерөөсөө учраа алдаж байна.

Манай зөвхөн Онцгой дээр гал унтраах тоног төхөөрөмж гэхэд л сая бид нар сонсож байна шүү дээ. Францаас Реногийн 40 машин ороод ирчихсэн байгаа юм байна. Эндээс ахиад хэдэн машин ороод ирэх юм байна. Хуучин Японы isuzu-ууд явж байгаа. Солонгосын машинууд ороод ирнэ, Орос машинууд ороод ирнэ. Энэ олон сэлбэг энэ чинь ерөөсөө сэлбэгийн л асуудал шүү дээ. Техник үзүүлэх засвар үйлчилгээний ажилчдын асуудал. Одоо рентгений машин, компьютер, томографууд бүр яг адилхан. Энэ дээр Шадар сайд засаг дээр ярьж, бодлого гаргамаар юм. Их Хурлаар оруулж ирээд, шаардлагатай бол бүр хууль батлуулаад нэг талдаа гармаар юм байна лээ.

**Г.Занданшатар:** Санал хэллээ, үг хэллээ. Үг, асуулт. Хаашааны асуултыг нь асуусан гэнэ. Ариунбуян генерал Онцгой байдлын ерөнхий газрын дарга хариулъя.

**Г.Ариунбуян:** Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Энэ зөв, зүйтэй асуудал ярьж байгаа юм. Үнэхээр Улаанбаатар хотын түгжэрэл, төвлөрөл, үүнээс үүдэлтэй газар зохион байгуулалттай холбоотой асуудлуудаас болж манай яаралтай тусламжаар ажиллах, аврах ажиллагааны энэ автомашинууд зорчиход, бас хөдөлгөөнд зорчиход галын голомт дээр очиход хүндрэл бэрхшээл бол байна. Ялангуяа орон сууцын хорооллын гадаа гэхэд автомашинууд бөөгнөрчихсөн байдаг, зогсоол байдаггүй. Гэр хороолол гэхээр гэр хорооллын гудамжийг нарийсгаад ингээд хаашаа бас ороо барьчихсан. Энэ асуудал дээр Нийслэлийн Засаг даргын Тамгын, газрын албатай хамтраад газар чөлөөлөх арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна. Бас тодорхой үр дүнд хүрч байгаа зүйл бий, хүрэхгүй ч асуудлууд байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр орон нутгийн захиргааны байгууллагатайгаа үргэлжлүүлээд ажиллана гэдгийг хэлье.

Дээр нь энэ Онцгой байдлын байгууллагад 2013 онд Японоос 22 ширхэг тусгай зориулалтын автомашиныг буцалтгүй тусламжаар манайд ирүүлсэн. Одоо ашиглагдаж байгаа. Ер нь Евро стандартыг хангасан манай байгаль цаг уурын нөхцөл байдалд тохирсон, бидний техникийн шаардлагад нийцсэн автомашиныг авах хүрээнд бид энэ Франц улстай энэхүү төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллаж байна.

**Г.Занданшатар:** Цэндийн Мөнх-Оргил гишүүн тодруулж асууя. 1 минут.

**Ц.Мөнх-Оргил:** Эхний асуудлаар генералаа бүүр шаардлагатай бол нэн яаралтай горимоор Засгийн газар хууль өргөн бариад энэ Газрын хуульд өөрчлөлт оруулаад зөвхөн тэр байшин барилгад биш, зөвхөн зам чөлөөлөх, хаашаа чөлөөлөх асуудлаар тусад нь хуулийн төсөл оруулж ирээд батлуулаадхаач. Тэгэх юм бол энэ яг цагаа тулахад хоёулаа дараа нь ингээд ингэсэн ч энэ хаашааг буулгаж чадаагүй, энэ байшин руу орж чадаагүй гээд яриад сууж байхын оронд хуулиа батлуулж аваад, тэр хууль дээрээ үндэслээд энэ орон сууцууд руу ордог замуудаа, хаашаануудынхаа эргээж болдоггүй олон тулчихсан хаашаануудынхаа асуудлыг шийдэж, ядаж түргэн тусламж, гал команд очдог замтай болгомоор байна. Энэ дээр та хэд Шадар сайдтай ярьж байгаад хуулийн төсөл өргөн бариадхаач.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэлийн урилгаар Компьютерын техник, менежментийн сургуулийн 1998 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Одоо Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн асуулт асууж, үг хэлсний дараа

санал хураалт явах. Асуулт хариултын цаг дуусна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Г.Мөнхцэцэг:** Энэ хоёр улсын хоорондын санхүүгийн хэлэлцээрийг дэмжиж байна. Бид нар бас онцгой байдлаа онцгойлон бас дэмжихгүй бол бас болохгүй байгаа. Өнөөдөр бас манай Онцгой байдлынхан өөрийнхөө нөөц бололцоо, дотоод хүчин зүйлээ ашиглаад сайн ажиглаж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Ер нь цаашид анги салбаруудаа бас нэмэгдүүлэх, боловсон хүчнээ чадавхжуулах гээд олон зүйлийн ажлуудыг бас хийх шаардлагатай байдаг гэдгийг чинь ойлгож байгаа. Энэ хэлэлцээрийн хүрээнд одоо зөвхөн энэ гал унтраах тоног төхөөрөмж авах юм байна гэж ингэж ойлголоо.

Ер нь цаашид бид нар бас энэ онцгой байдлынхаа тоног төхөөрөмжүүдийг бас парк шинэчлэлээ хийх тал дээр бас манай онцгой байдлынхан яаж анхаарч байгаа юм бэ? Тухайлах юм бол одоо манай говийн бүс энэ тал хээрийн бүсэд өвлийн өвөлд хаврын хаварт л дандаа байгалийн гамшигтай нүүр тулж байна. Өнөөдөр төвөөсөө алслагдсан энэ сумуудын хооронд, багуудын хооронд, айл өрхүүдийн хооронд цас зудын бэрхшээлтэй байгаа үе цаг үед бол зам, мөр гаргахаас авхуулаад олон зүйлийн ачаалалтай, бас дээрээс нь ийм зовлонгууд бий болдог. Тэгэхээр ер нь аймагт байж байгаа ганц нэгхэн тоног төхөөрөмж бид нар түрүүгээрээ тэр өчнөөн 100 км-т байгаад айл, өрхүүдийн хооронд зам гаргах, мөр гаргах гэдэг дээр үнэхээр хүрэлцдэггүй ийм зовлон бидэнд байна.

Тэгэхээр ер нь цаашид энэ хэлэлцээрээ сайжруулдаг юм уу, аль эсвэл хэлэлцээрээр нэмэгдүүлдэг юм уу, аль эсвэл ямар нэгэн байдлаар энэ шинэчлэлт хийхэд парк шинэчлэлт хийхэд тухайлбал, энэ хөдөө орон нутгуудад энэ

бас яг ийм цас зудын бэрхшээлтэй тулгарч байгаа аймаг, орон нутгуудад ийм тоног төхөөрөмжийг олгох тал дээр манай онцгой байдлынхан хэр хүчин зүйл, нөөц бололцоо чинь хэр байгаа вэ? Энэ дээр бас та бүхэн маань яаж анхаарч байгаа вэ гэдэг дээр би бас асуулт байна. Сая гишүүд бас хэлж байна л даа. Энэ хүрээндээ бид нар та нар байгалиас агаараас хийдэг ийм дроны зүйлүүдээр хангах тал дээр ийм өөрчлөлт оруулж болохгүй юу гээд асууж байна. Тэгэхээр бас яг ийм байгалийн цас зудын бэрхшээлтэй байгаа ийм орон нутгууд, бүс нутгуудад ийм тоног төхөөрөмжөөр хангах ийм хэмжээний гэрээгээ сайн бас шинэчлэх юм уу сайжруулах тийм талын бололцоо, нөхцөлүүд байна уу, үгүй юу гэдэг дээр ийм асуултыг тавья гэж бодож байна.

**Г.Занданшатар:** Мөнхцэцэг гишүүн. Ариунбуян генерал, 82 Онцгой байдлын ерөнхий газрын дарга.

**Г.Ариунбуян:** Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөлийг сайжруулах, техникийн тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах асуудал үнэхээр хэрэгтэй, шаардлагатай байгаа. Бид бүхэн батлагдсан төсвийнхөө хүрээнд техник, тоног төхөөрөмж худалдан авч, шаардлагатай анги, байгууллагуудад хуваарилж ажиллаж байна. Улсын төсвөөс гадна энэ гадаад улс орнуудын Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд ч гэсэн энэ төсөл, хөтөлбөрүүд үргэлжилж байгаа. Цаашидаа таны ярьж байгаа шиг энэ цас, зудын үед ажиллах туулах чадвар сайтай, тохилог, дулаахан манай аврагчдын үүрэг гүйцэтгэхэд бас хэрэгтэй ийм автомашинуудаар хангах асуудал бас үнэхээр хэрэгтэй байгаа. Тэгээд хөнжлийнхөө хэрээр хөлөө жий гэдэг шиг л байгаа төсөвтөө баригдаад л ингээд явж байгаа юм бий.

Тэр дроны асуудал дээр түрүүнд хэлсэн Солонгосын КОЙКА, Туркийн онцгой байдлын байгууллага, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай энэ дроны хангамжийг сайжруулах, ашиглалтыг эрчимжүүлэх чиглэл дээр бид бүхэн бас ажиллаж байна. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээд бид нар Элчин сайдын яамаар дамжуулаад, хүргүүлээд ажиллаж байна.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Одоо Байнгын хорооны саналаар хуулийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т зааснаар нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хуулийг эцэслэн баталсанд тооцно гэж заасан.

39-өөр, Пүрэвдорж гишүүн ээ та бүлгийнхээ гишүүдийг дуудаач. Манай Төв аймгаас сонгогдсон төвийн гишүүн хаагуур явна? 39-өөр. Энэ соёрхон батлах чинь ингээд. Зээлийн хэлэлцээр соёрхон батлах. Энэ Аубакир гишүүн хаачсан бэ? Энэ өглөө босоход яадаг юм? Энэ Тилеуханы Аубакир гишүүнийг дууд. Ундром, Сэргэлэн хоёр гишүүн байсан уу өглөө? Тэр наад Энх-Амгалан, Чойжилсүрэн хоёр хоёулаа байсан сайд. Амарсайхан сайд энэ сайд нарыг дуудмаар байна. Ж.Бат-Эрдэнэ байсан. Яг орж ирж байна. Баделхан гишүүн байсан. Ц.Мөнхцэцэг гишүүн, Цогтбаатар дарга Мөнхцэцэг гишүүн хажууд чинь байна шүү дээ дуудаач. Аубакир гишүүнийг дууд даа. Тилеуханы Аубакир гишүүн хаагуур зугаалж яваад ирэв? Энэ санал хураалт болохоор л алга болчих юм.

Санал хураалт явуулъя. Аубакир гишүүн ирсэн учраас Байнгын хорооны саналаар санхүүгийн хэлэлцээр соёрхон

батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Шууд хуулийн төсөл батлагдах учиртай. Пүрэвдорж гишүүн ээ энэ Адьшаа гишүүн, Адьясүрэн гишүүн хоёр байсан юмсан. Батсуурь гишүүн орж ирж байна. Тэр хэдийг дуудчихвал гэсэн. Санал хураалт явуулна. Айн, энэ Даваасүрэн, Энх-Амгалан, Чойжилсүрэн гурван сайд байсан. Энэ 3 гурван сайд. Дамбын Батлут гишүүн орж ирлээ. Буланы Бейсен гишүүн сайн байна орж ирлээ. Санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүн картаа хийчих.

Байнгын хорооны саналаар Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

40 гишүүн дэмжиж, хуулийн төсөл батлагдлаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл.

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийн санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Дараагийн асуудалд оръё. Дараагийн асуудал бас зээлийн хэлэлцээр байгаа. Гялс баталчихъя.

12.11 цаг.

**Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг соёрхон батлах хуулийн төслийг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд Сайнбуяны Марсайхан танилцуулна.

**С.Амарсайхан:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын 2019 онд байгуулсан санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд онцгой байдлын байгууллагад агаараас эрэн хайх, аврах анги байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлж байна.

Уг төслийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газарт 4 нисдэг тэрэг нийлүүлэгдэж, евро стандартын симулятор, засвар үйлчилгээний төв, оффис бүхий агаараас эрэн хайх, аврах анги шинээр байгуулагдаж нисгэгч, инженер, техникийн ажилтнуудыг сурган бэлтгэж байна.

Тус анги нь 2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт 94 удаагийн тусгай үүргийн нислэгийг үйлдэж, ослын улмаас бэртэж гэмтсэн, газраар тээвэрлэх боломжгүй нөхцөл бүхий 133 хүний эрдэнэт амь насыг аварч, анхан шатын тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж дараагийн шатын эмнэлгийн байгууллагад цаг алдалгүй хүлээлгэн өгч ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газраас энэхүү төслийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг харгалзан үзээд дараагийн шатын төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу гэрээ байгуулах

тухай санал, гэрээний төслийг урьдчилан Улсын Их Хуралд хүргүүлж, Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлэн зөвшилцсөн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Францад Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр Онцгой байдлын ерөнхий газраас Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх санхүүгийн хэлэлцээрт талууд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Парис хотноо гарын үсэг зурсан.

Энэ хэлэлцээрийн дагуу олгох 27.7 сая еврогийн зээлийг 5 жилийн хугацаатай үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 15 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх хөнгөлөлттэй нөхцөлтэй болно. Төслийн 2 дугаар шатыг хэрэгжүүлснээр Монгол Улсын онцгой байдлын байгууллагын нисгэгчид онцгой үүргийн нислэгийн өдөр, шөнийн цагт болон хүндрүүлсэн нөхцөлд бие даан гүйцэтгэх бүрэн чадвартай болохоос гадна инженер, техникийн ажилтнуудыг үргэлжлүүлэн бэлтгэж сургах, нисдэг тэрэгний сэлбэг, хэрэгсэл нийлүүлэх, засвар үйлчилгээ хийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх юм.

Энэхүү төслийн хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болохыг хэлье.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Онцгой байдлын ерөнхий газраас агаараас аврах, эрэн хайх ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна.

Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшиний урилгаар Хан-Уул дүүргийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

**Г.Амартүвшин:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүйн байдал, гадаад бодлогын байнгын хороо 2021, 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин уг төслийн хүрээнд сургалтад зарцуулах төсвийн нийт санхүүжилтийн 50 гаруй хувьтай тэнцэж байгаа гээд уг сургалтын төсвийн хэрхэн зарцуулах, сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн нисгэгчид, албан хаагчдыг цаашид тогтвор суурьшилтай ажиллуулах талаар баримтлах бодлогын тухай ажлын хэсгээс тодруулан асууж хариулт авсан болно. Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан төслийн хүрээнд авч байгаа зээлийн санхүүжилтийн үр дүнтэй, оновчтой зарцуулахад анхаарах, зарцуулалтыг нь ил тод байлгах шаардлагатай болохыг ажлын хэсэгт анхаарууллаа.

Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын хоорондын санхүүгийн хэлэлцээрийн соёрхон батлах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүйн байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүд түрүүчийнхтэй мөн адил, танилцуулна. Ажлын хэсгийн гишүүд Сайнбуяны Амарсайхан Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд, Гомбожавын Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал, Лувсаншаравын Өлзийбаяр Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа, Цэдэвийн Нямбаяр Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга нар.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Цэдэндамбын



Цэрэнпунцаг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ц.Цэрэнпунцаг:** Хуулийн төслийг дэмжиж байна. Нэг асуулт, тодорхой асуулт асуучихъя. Түрүүн бас асуух гэж байгаад амжаагүй юм. Энэ Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл гээд энэ төсөл цаашидаа үргэлжлэх юм уу? I удаагийнх юм уу? Цаашидаа үргэлжилбэл түрүүний бас энэ гишүүд ярьж байсан энэ нэг нийлүүлэгчээсээ цаашаа аваад явах, цаашидаа бас энэ нийлүүлэлтийнхээ талаас дараа энэ техникуудийнхээ үйлчилгээний тал дээр зардал, чирэгдлийг нь та нар сайн тооцсон уу? Ер нь хамгийн гол асуудал бол I удаагийн худалдан авалтаасаа илүү дараагийн энэ урсгалд гарах, үүнтэй холбоотойгоор урсгал зардлынхаа тал дээр сайн тооцоо, судалгаа хийсэн юм байгаа биз дээ?

Дээрээс нь энэ зөвхөн Улаанбаатар хотын асуудал биш, аймгийн төв суурин, том суурин газруудын асуудал биш. Сум дээр өнөөдөр бид нар энэ бас асуудал гарч байгааг одоо бид нар мэдэж байгаа. Саяхан бид нар Шадар сайд, Амарсайхан сайд бид хэд Завхан аймгийн хойд сумуудаар зудын байдалтай сумуудаар явж ажилласан. Энэ үед манай Баянтэс сумын сургууль шатсан. Тэгээд сургууль шатсан, сургууль шатсан шалтгаан тогтоогдох байх. Сургууль шатаад үүнийгээ бид нар бүрэн ингээд дундаас нь энэ галыг унтрааж чадаагүй сургуулийн байшин ингээд бүрэн шатчихсан байсан. Хажууд нь 45км-ийн зайтай Тэс сумд аврах анги байдаг. Гал унтраах ангитай. Тэгтэл энэ Баянтэс сум дээр гал унтраах ийм боломж өөрсдөө байсан юм уу гэвэл нэг техниктэй байсан тийм ээ? Тэр техник нь асдаггүй, өвлийн үед асахгүй ганц систертэй. Үүнийг зохион байгуулах хүн газар дээрээ байхгүй байсан.

Тэгэхээр зэрэг цаашидаа бид нар энэ сумдаа бид нар шиг хөрөнгө оруулалт их хийж байна, шинэ сургуулиуд баригдаж байна, шинэ эмнэлэг баригдаж байна, шинэ соёлын төвүүд, том том байшин барилгуудтай болоод л байна. Энэ хэдийгээ бид нар энэ ар талд нь энэ галын аюул гарвал яах юм? Энэ дээр яаж хамгаалах юм гэдэг дээр бид нар бодлого гаргаж, энэ цаашидаа бас энэ төслүүд дээр бид нар өргөтгөөд, энэ парк шинэчлэлээ өргөтгөөд аймгийн төв рүү энд ашиглаж байгаа энд техникүүдээ тэр аймаг руугаа, аймагт байгаагаа сумд руугаа юмаа явуулж, сумдаа ядах нь газар дээр нь энэ галын ийм онцгой байдал үүссэн тохиолдолд, гал гарсан тохиолдолд зохион байгуулах нэг хүнтэй байхгүй бол дандаа сайн дурын бүлгүүд үүнийг зохион байгуулж ажиллаж чадахгүй юм байна гэдэг нь саяын энэ манай Завхан аймгийн Баянтэс-д үүссэн нөхцөл байдлаас харагдаж байсан юм. Тэгэхээр энэ асуудлуудыг цааш нь, энэ төслийг цааш нь үргэлжлүүлж энэ чиглэл рүү явах ийм бодлого байна уу, үгүй юу ийм асуулт асууя.

**Г.Занданшатар:** Сайнбуяны Амарсайхан сайд хариулна. Шадар сайд Сайнбуяны Амарсайхан.

**С.Амарсайхан:** Энэ агаараас эрэн хайх, аврах ангийн үйл ажиллагаа 20 онд Францын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 3, 4 нисдэг тэрэг орж ирсэн. Ингээд энэ төсөл 20 оноос хойш хэрэгжээд явж байгаа. Харамсалтай нь КОВИД-ын нөхцөл, байдлаас шалтгаалаад бас тодорхой хугацаа алдсан. Өнөөдрийн байдлаар Франц нисгэгч, инженер техникийн ажилчид бас гамшигийн үйл ажиллагаанд энэ нисдэг тэргийг ашиглах, түүний зэрэгцээ манай улсын нисгэгч, инженер техникийн ажилчдыг бэлтгэх ажлууд явж байгаа.

Ялангуяа энэ онцгой үүргийн нислэгийн үеийн өдөр, шөнийн нислэгт үйл ажиллагаа явуулах нисгэгчид хамгийн

багадаа 4000 цаг ниссэн байх ёстой. Ердийнх бол 500 цаг ниссэн бол бас болж байна гэж үздэг. Тэгэхээр энэ төсөл хэрэгжсэнээр өнгөрсөн хугацаанд машин техник, хүн мал очих боломжгүй ийм ой хээрийн түймрүүд хилийн зурваст гарсан олон гал түймэр унтраах ажиллагаа амжилттай хэрэгжсэн.

Хоёрдугаарт, 133 хүний амь нас, эрүүл мэндийг хөдөө, орон нутагт аваар осол, гэмтэлд өртсөн, автомашинаар тээвэрлэх боломжгүй, яаралтай эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ийм дуудлага, цаашлах юм бол энэ байгалийн гамшигт үзэгдэл цасан болон шороон шуурганы үед төөрсөн олдохгүй байгаа иргэдийг эрэн хайх арга ажиллагаа, аврах ажиллагаа гээд олон ажиллагаанд энэ нисдэг тэрэг онцгой үүрэг гүйцэтгэж байгаа. Энэ хэлэлцээрийн үр дүнд бол дахиад нисгэгчдэдээ бэлтгэнэ. Энэ дотоодын чадавхаа бэхжүүлэх ийм ажлууд явагдах юм байгаа юм. Цаашилаад зөвхөн Улаанбаатар хотод биш, бүсчилсэн маягаар, аймаг орон нутгийн хэмжээнд нисдэг тэрэгний энэ агаараас эрэн хайх, аврах үйл ажиллагааг ангиудыг бид байгуулахыг зорьж байгаа.

Тэгэхээр энэ ажлууд өргөн уудам газар нутагтай, хүн тархаа суурьшсан, ялангуяа өдөр ирэх тусам хүн амын тоо нэмэгдэж байна, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, зүйлүүд нэмэгдэж байна, аюултай бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд хүртэл нэмэгдэж байгаа. Төрөл нь. Тэр хэрээрээ бас давхар цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан байгалийн элдэв гамшигт үзэгдлүүд нэмэгдэж байна. Тийм учраас бид энэ онцгой байдлын салбараа бүрэн бэхжүүлэх ажлын хүрээнд энэ ажил хийгдэж байгаа.

Гэхдээ энэ хангалттай биш. Та бүхэн маань мэдэж байгаа. Сая 24 оны төсөв батлахад хүртэл бид онцгой байдлын алба хаагчдын техник, хэрэгсэл, хувцас хунар, албаны бэлэн байдлыг

хангахад 40 тэрбум төгрөг тавьж эхний асуудлуудаа шийдвэрлэе гэсэн. Бас ярьж буурсаар байгаад 5 тэрбум нь 10 тэрбум төгрөг болсон. Өнөөдөр Монгол Улсын 21 аймгийн 330 гаруй сумд зөвхөн 30 сумд нь гал унтраах, аврах ангийн үйл ажиллагаа явуулж байна. Нэг сумнаас нөгөө сумд очих гэсээр байтал хамгийн саяын сүүлийн Цэрэнпунцаг гишүүний хэлсэн Баянтэс сумд гарсан гал түймрийн үеэр сургууль шатсан. Нэг сумаас нөгөө сумдаа очих хүртэл Тэс сумд очих хүртэл 2 цаг 30 минут зарцуулж очиж байгаа. Энэ хооронд сургууль битгий хэл сум даяараа шатах ийм эрсдэл бий.

Тийм учраас бид энэ Засгийн газар, Улсын Их Хурал дээр Улсын Их Хурлын гишүүдээ төсвийн үеэр энэ онцгой гамшигийн үеийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг, тэмцдэг байгууллагаа бэхжүүлэх дээр онцгой анхаарч, төсөв хөрөнгө гар татахгүй тавьцааж өгөөч. Улаанбаатар хотод хүн ам хүртэл нэмэгдэж байгаа. Түгжрэл, бөглөрөл гээд очих цагтаа очиж чаддаггүй. 9 дүүрэгт байгаа гал унтраах, аврах ангийг хүртэл өөрчилье гэж байгаа юм. Гэх мэтээр бид нар ер нь цаашаа энэ байгууллагаа үе шаттайгаар төсөв хөрөнгийг нь дорвитойхон ииг тавьж шийдвэрлэхгүй бол өнөөдөр амгалан тайван байна гээд тэрэндээ хууртаад бас болж байна гэж яваад байж боломгүй байгаа юм.

Цаашидаа ч гэсэн ирэх оны төсвүүд дээр гадаад, дотоодын зээл, тусламж гэхээсээ илүүтэй дотоодын төсөв хөрөнгөөрөө энэ шаардлагатай бааз сууриа бэхжүүлэх, чадавхыг нэмэгдүүлэх ажлууд маш чухал байгаа гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Жигжидийн Батжаргал нарын урилгаар Төв аймгийн Онцгой байдлын ерөнхий газрын албан хаагчид болон ахмадуудын төлөөлөл

Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Д.Өнөрболор:** Энэ хүний амь аврах шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжийг бас нийлүүлэх, парк шинэчлэл хийх, төрийн албан хаагчдыг бас чадавхжуулах тал дээр бол бас мэргэжлийн хүн учраас энэ Онцгой байдлын ерөнхий газрын дарга Ариунбуян генерал бас нэлээн удирдлага, зохион байгуулалтаар бол сайн хангаж ажиллаж байна гэж дүгнэгдэж байгаа.

Энэ онцгой байдлын энэ нисдэг тэрэгтэй агаараас аврах үйл ажиллагаатай холбоотой энэ албан хаагчдыг чадавхжуулах ажлаас гадна Шадар сайдаа нэн ялангуяа энэ материаллаг баазыг хангах тал дээр бол ажиллах нь, анхаарал хандуулж ажиллах нь бол их чухал юм байна лээ гэдэг нь бол бас хэд хэдэн тохиолдлоор бас батлагдсан.

Нэн ялангуяа энэ нисгэгчгүй нисэх төхөөрөмж буюу энэ тусгай зориулалтын агаарын дроныг ашиглах асуудал бол маш чухал байгаад байгаа юм. Энэ дрон орчин үед бол гал унтраахаас өгсүүлээд энд тэнд юу гэдэг юм энэ янз бүрийн цэгүүдээс мэдээлэл бүх түвшиндээ дамжуулж, хүлээж авахаас өгсүүлээд энэ гал түймэр гарсан газар иргэдийг бас аврах хүртэлх ийм үйл ажиллагаанд хүртэл дрон ажилладаг, ажиллах дроныг ийм түвшиндээ хөгжүүлчихсэн байна.

Тэгэхлээр үүн дээр та бүгд маань бас нэлээн их анхааралтай хандаач. Энэ тал дээр материаллаг баазыг бүрдүүлэх тал дээр анхаарлаа хандуулж ажиллаач гэж бол бас хүсэхээр байна.

Нөгөөтээгүүр энэ Сэлэнгэ, Дарханы бүс нутаг бол гол мөрөн ихтэй, бороо уснаас үүдэлтэй энэ осол, эндэгдэл гарч ард, иргэдийн бас энэ эрүүл, аюулгүй гамшигийн эрсдэлтэй бүсэд бас амьдардаг. Нэн ялангуяа гал гаталж төрийн болон бусад үйлчилгээ гэдэг бол иргэд бол нэлээдгүй ингэж авч амьдардаг юм байна лээ. Тэгэхлээр энэ уснаас эрэн хайх, аврах ажиллагааг бол сайжруулан шинэчлэх ажил маш чухал юм байна лээ.

Тухайлах юм бол, зөвхөн Сэлэнгэ аймгийг л аваад үзэхэд чинь зөвхөн энэ төрийн албан хаагчийн энэ тусгай зориулалтын албан хэрэгсэл, хувцас хэрэгслийг л аваад үзэхэд бол зөвхөн тэр олон албан хаагчдад ганцхан хэрэгсэлтэй байж байх жишээний. Энэ бол бас энэ иргэдийн аюул эрсдэлгүй орчныг бүрдүүлэх тал дээр бол бас энэ материаллаг баазыг зайлшгүй маш сайн хангах шаардлагатай юм байна гэдэг нь харагдсан.

Тийм учраас Шадар сайд бас үүн дээр бол бас анхаарлаа хандуулж зохицуулалт хийх нь бол зүйтэй байна гэж харж байна. Тэгэхлээр таны бас байр суурийг сонсьё. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Сайнбуяны Амарсайхан Шадар сайд.

**С.Амарсайхан:** Өнөрболор гишүүн маш чухал асуудлууд ярьж байна. Гал түймэртэй тэмцэх, гамшиг ослыг удирдах, тэгээд үер ус, ган, зуд, цаашилах юм бол энэ байгалийн аюулт үзэгдлүүдтэй тэмцэхэд бол бүх шатад манай энэ онцгой байдлын алба хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, тэгээд тоног төхөөрөмж, техник хэрэгслийн бааз суурийг бэхжүүлэх, орчин үеийн шаардлага хангасан инновац, технологи тоног төхөөрөмж дээр суурилж үйл ажиллагаагаа хөнгөвчлөх, хурдтай, түргэн шуурхай аврах, эрэн хайх, сэргээн босгох үйл ажиллагааг бэхжүүлэх тал дээр бид илүү онцгой анхаарах хэрэгтэй. Түүрүүн би хэлсэн 330 сумд 30-хан сумд

бид аврах анги, гал унтраах ангиудтай байна. Тэгэхээр бусад сумууд нь ямар хэмжээнд эрсдэл үүсэх вэ, ямар хэрэгцээ шаардлага байна вэ гэдгээ бас тооцох ёстой.

Тийм ч учраас энэ байгууллагын бааз суурийг бэхжүүлэхэд төрөөс онцгой анхаарч хөрөнгө оруулалтуудыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага бий. Бид энэ гадаадаас авч байгаа зээл, тусламжийг олон улс орноос авч байгаа. Тэгэхдээ боломж нь тийм байгаа учраас бас ашиглаж байгаа. Түрүүн бас Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагууд ч хэлсэн. Ерөнхийдөө цаашидаа бол нөхцөл байдал улам хүндэрнэ. Ялангуяа цаг уурын өөрчлөлттэй холбоотой аюулт үзэгдлүүд 40 хувиар, 30 хувь нь гэхэд нэмэгдэнэ гэж байгаа юм дэлхий нийтэд. Тэр дундаа байгалийн аюулт үзэгдэл, цаг уурын аюулт үзэгдэл 3 дахин нэмэгдэнэ гэж. Үүний тод илэрхийлэл бол өнгөрсөн зуны бороо, үер, энэ өвлийн хүйтэн зуд гээд иймэрхүү зүйлүүд бид бэлэн байхын тулд энэ албаа бэхжүүлэх ёстой.

Тийм учраас тэр хүрээнд өнөөдрийн энэ нисдэг тэрэг, агаараас эрэн хайх, аврах үйл ажиллагааны ангийг бэхжүүлэх төслийг үргэлжлүүлэх санал орж ирж байгаа юм. Сэлэнгэ аймаг ч бай ер нь манай 21 аймгийн бүхий л сумуудад төдийгүй Улаанбаатар хотод бид энэ гамшигийн үеийн арга хэмжээг түргэн шуурхай авч хэрэгжүүлэхтэй холбоотой бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтүүдийг бас хийж байгаа. Аль болох цаг алдахгүй түргэн шуурхай төрийн үйлчилгээг хүргэх өөрөөр хэлэх юм бол иргэдээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, аваар осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хохирол багатай даван туулах энэ чиглэлийн үйл ажиллагаануудаа илүү цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж, оновчтой зохион байгуулах ажлууд явж байгаа.

Цаашидаа ч гэсэн Улсын Их Хурлаар төсөв хөрөнгө батлахтай

холбоотой үе шаттайгаар шийдвэрлэх асуудал энэ салбарт олон бий. Та бүхэн маань бас тэр чиглэлүүд дээр анхаарч дэмжиж ажиллана гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо Наянтайн Ганибал гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Дараа нь санал хураалттай учраас гишүүд чуулганы танхимд цуглая. 39-өөр батална. Наянтайн Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Энэ бас онцгой байдал, техник тоног төхөөрөмжөө шинэчлэх, нэмэгдүүлэх, сургалт авах маш чухал байна. Өнөөдөр яг бодит амьдрал дээр Монгол Улсын хэмжээнд ер нь өмнөх он жилүүдээс илүүтэйгээр энэ онцгой байдлынхны ачаалал нэмэгдээд байна. Зүүн аймгууд дээр одоо шилэн буюу ийм мөсөн зуд болоод нэлээдгүй хоногийг өнгөрөөлөө. Бид бүхэн Монгол Улсын бэлчээрийн хамгийн сүүлчийн нөөц нутаг болох Мэнэнгийн талдаа зүүн аймгуудын бод мал ихэнх нь 60, 70 хувь нь тэнд нутаглаж байгаа. Тэнд бас алдагдаад олж авахгүй, эрэл хайгуул хийсэн хүмүүс маш ихээр явж байна. Энэ бүс нутагт энэ бензин шатахууны нийлүүлэлт бас доголдоод байна. Тэр газрын тосны 19 дүгээр талбай, тэр Матад сумын шатахууны нийлүүлэлтийг өмнөх байдлаас нь нэмэгдүүлэх шаардлагатай байна. Ердийн хэмжээнээс нь. Тэгэхгүй эрэлд явж байгаа залуучууд маань бензин, шатахуун олдохгүйгээс болоод, бензин тасалдаж байгаагаас болоод тулуу бензинтэй яваад, бензинээ байхгүй болж хөдөө хээр зогсох, даарах, бээрэх ийм асуудлууд гарч байна.

Орон нутгийн зүгээс Сүхбаатар, Дорнод аймгуудын зүгээс бас тодорхой хэмжээнд Онцгой байдал, аймгийн Засаг даргын Тамгын газрууд хээрийн штаб байгуулах, бас тодорхой хэмжээнд мэдээллийг олон нийтэд түгээх гээд ажлуудыг зохион байгуулж байгаа боловч бас яг энэ бензин шатахууны хомсдолын асуудлаас болоод бас

нэлээдгүй асуудал үүсээд байна. Энэ дээр бас манай онцгойгийнхон анхаарч өгөөч гэж хүсэж байна.

Энэ төсөлтэй холбогдуулаад ер нь энэ төслийн хүрээнд хэдэн нисдэг тэрэг авахаар болсон юм бэ? Өнөөдөр яг хэд нь ирчхээд байна, хэд нь явж байна? Ер нь бас яг л зөвхөн ойн түймэр гэхээсээ илүүтэй өнөөдөр энэ зам талбай хаагдсантай холбоотой бас эрэл хайгуулын асуудлууд зүүн аймгуудад өнөөдөр хүртэл тасрахгүй байна. Машинтайгаа гараад хэд хоногоор, хэдэн цагаар алга болдог. Үүнийг хайж явахад араас нь явж байгаа машин техникууд бас очиж чаддаггүй. Ингээд холбоо тасардаг. Энэ асуудал дээр бас та бүхэн бас нисдэг тэрэг ер нь цаг дулаартал тэнд бас онцгой нөхцөлтэйгөөр байлгах ямар боломж байгаа юм бэ? Дээрээс нь ер нь сургагч багш нарын зааж байгаа Монгол нисгэгч нар маань хэзээ ингээд бие даасан нислэгүүдийг хийх ийм боломжтой болох вэ гэсэн хэдэн асуултыг асууя.

**Г.Занданшатар:** Ариунбуян. Гомбожавын Ариунбуян хошууч, генерал.

**Г.Ариунбуян:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Одоо энэ төсөл хэрэгжихэд нисдэг тэрэг авахгүй. Одоо манайд урд төслийн хүрээнд 3, Евро ковтер 145 маркийн аврах ажиллагааны болон эмнэлгийн тусгай зориулалтаар тоноглогдсон ийм нисдэг тэрэг нийлүүлэгдсэн. Эдгээр нисдэг тэрэг бол газраар тээвэрлэх боломжгүй осол, аваарт орсон иргэдийг тээвэрлэх ажиллагаагаа үргэлжлүүлээд явж байгаа. Энэ төсөл маань одоо бэлтгэгдэж байгаа нисгэгч нар, инженер техникийн ажилтнууд, дээр нь эмч, эмнэлгийн ажилтан, аврах ажиллагааны мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах ийм төсөл 3 жилийн хугацаанд хэрэгжинэ.

Өнөөдөр манай нисгэгч нар доод тал нь 150-200 цагийн нислэгийн

лицензтэй байгаа. Олон улсын практикт онцгой чиг үүргийн буюу хүндрүүлсэн нөхцөлд үүрэг гүйцэтгэдэг нисгэгч нар доод тал нь 200-аас доошгүй цаг гэсэн туршилагатай байх ёстой байдаг. Тийм учраас өнгө энэ 3 жилийн хугацаанд бид нар доод тал нь 500 цагийн нислэгийн дадлагатай болгож, ингээд бие дааж үүрэг гүйцэтгэх ийм боломжтой болох юм.

Эрэл хайгуулын хувьд энэ сая хүчтэй салхи, шуурганы улмаас ялангуяа зүүн аймгуудад болсон салхины үед бид нар энэ нисдэг тэргийг ашигласан. Дорноговь аймагт төөрсөн иргэнийг олсон ийм зориулалтаар ашиглаж байгаа юм.

Бензин тосны хангамжийн асуудлыг би ойлголоо. Шадар сайд буюу Улсын онцгой комиссын даргын тушаалаар энэ гамигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт, ялангуяа зудын аюулд нүүрлэсэн аймаг, сум орнуудын бас харилцан ажиллагааг зохицуулах зорилгоор Улсын онцгой комиссын шуурхай штаб байгуулаад ажиллаж байгаа. Энэ шуурхай штаб дээр түлшний хангамж, нийлүүлэлт тогтвортой байдлыг хангах хүрээнд төлөвлөлтийн асуудлуудыг зохицуулж байна. Тийм учраас би эндээс гараад Матад сумын энэ шатахууны асуудлыг судалъя, хангамжийг нийлүүлэх тал дээр бас онцгой анхаараад эргээд танд илтгэе.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Эцэслэн батлах санал хураалт явуулна. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу нийт гишүүдийн олонх хуулийн төслийг эцэслэн батлахыг дэмжсэн бол баталсанд тооцно гэж заасан.

Байнгын хорооны саналаар Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

42 гишүүн дэмжиж хуулийн төсөл эцэслэн батлагдлаа. Хуулийг эцсийн найруулгыг уншиж танилцуулъя.

Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай,

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан Онцгой байдлын ерөнхий газрын газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийн санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

12.38 цаг.

**Г.Занданшатар:** Өвөлжилтийн байдал хүнд байгаа. Төрийн байгуулалтын байнгын хорооноос өнөөдөр санал гаргаад Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ. Энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсийн эдийн засгийн форумууд зохион байгуулах асуудлуудаар Улсын Их Хурлын гишүүд бүсийн хэмжээнд ажиллах ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран зохион байгуулах ийм ажил байгаа.

Энэ өвөлжилтийн бэлтгэлийг хангах, өвөлжилтийн байдалтай танилцах чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газар бас хамтарч ажиллаарай. Архангай аймаг хүндрэлтэй байна гээд Чинзориг гишүүн яриад байна.

Өвөлжилт хүндэрсэн байна. Дараагийн асуудалд оръё.

**Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Манай Чинзориг сайд Архангай, Баянхонгор хоёрт их санаа зовдог болсон. Отроор явж байгаа нөгөө малчдад эрүүл мэндийн үйлчилгээ хүрэхгүй байна. Машиныг нь нураагаад авчихсан. Тэр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг өөрчлөхгүй бол одоо хөдөө машингүй төрийн үйлчилгээ их хүнд байна шүү дээ. Тэр хуулийг өргөн барина гэсэн юм, Засгийн газар өнөөдөр яасан юм бол? Тийм, Энхболд даргаа та Амарбаясгалан даргатай яриад өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаад тэр бүсийн хэмжээнд ажиллах тогтоолыг тэр өвөлжилт энэ тэртэй уялдуулаад тэрийг өнөөдөр танай Байнгын хороо өнөөдөр хуралдах уу, маргааш өглөө хуралдах уу? Танай ч юу байх вэ манай Байнгын хороо. Манай Байнгын хороо санаачлах юм. Тийм. Тэр чинь Засгийн газар өргөн барьчихсан. Хоёуланг нь хэлэлцчихье. Өнөөдөр гялалзуулаад ирэх долоо хоногт бас Засгийн газар дээр юмаа шийдэж өгөх хэрэгтэй байгаа.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Байз үүнийг хойшлуулчихдаг ч юм билүү? Олон асуудалтай байна.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

**Г.Занданшатар:** Байж байгаарай. Энэ Сангийн сайд байхгүй учраас энэ асуудлыг хойшлууллаа. Үүнийг үдээс хойш хүртэл хойшлуулчихъя. Дараагийн асуудал. Олон асуудал байна. Хариуцсан сайд нь байхгүй учраас

хойшлуулъя. Дэгийн тухай хуулиар хойшлуулж болно. Сайд байхгүй.

12.40 цаг.

**“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах” болон “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын тогтоолуудын нэгтгэсэн төслийг хэлэлцэнэ. Анхны хэлэлцүүлэг явуулна.**

Энэ хоёр тогтоолыг нэгтгэж анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут танилцуулна. Дамбын Батлут гишүүнийг индэрт.

**Д.Батлут:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар нарын 12 гишүүнээс 2022 оны 6 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэлээс 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 02 дугаар тоот тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар нарын 12 гишүүнээс өргөн мэдүүлсэн “Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай”, Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэлээс өргөн мэдүүлсэн “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Батлутаар ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Ганибал, Доржханд, Чинзориг, Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

Тус Байнгын хороо тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал нэг бүрийг хэлэлцэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжлээ. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухай хуулийн төсөл батлагдах хүртэлх хугацаанд төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах замаар нэмж бий болохыг түр хориглох гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл, тухайн салбарын онцлог, хууль тогтоомжоор олгогдсон

чиг үүрэг зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан оновчтой ангилах, ангилал бүрд нийцсэн зохистой өмчлөл, сайн засаглал, санхүүгийн төлөвлөлтийн ялгамжтай бодлого хэрэгжүүлэх чиглэлээр бэлтгэл ажлыг ханган хэрэгжүүлэх гэж нэмж тусгахаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн. Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатараас Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасан компанийн хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу бүртгүүлж, арилжаалах хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах гэж тус тогтоолын төсөлд нэмж тусгуулахаар санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай” болон “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллын Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг төр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай” болон “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн ишийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр яах аргагүй энэ төрийн болон орон нутгийн өмчтэй компаниудын үр ашиг, хариуцлага, ил тод байдал гээд олон зүйлүүд олон удаа яригдсан. Тийм учраас үүнийг бид тал бүрээс нь нэлээн анхаарч, зөв шийдлийг нь гаргах ёстой. Зүгээр нэршил онож байгаа юм уу, үгүй юм уу? Төрийн болон орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай гээд байгуулаагүй юманд ямар үр ашиг байх юм. Тийм учраас төрийн болон орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн үр ашиг менежментийг сайжруулах, цаашид шинээр байгуулахыг түр хориглох гэж ингэж л нэршилээр явбал зөв болов уу гэсэн ийм бодол байна, нэг.

Хоёрдугаарт, үнэхээрийн үр ашигийг нь сайжруулъя, хараа хяналтыг сайжруулъя л гэж үзэж байгаа бол энэ төрийн өмчтэй компаниудаа олон нийтийн засаглалтай болгох чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ л энэ тогтоол дотроо л их тодорхой л оруулах ёстой. Тэгж байж л их бодит ажил болох ёстой л гэж л ингэж л хараад байна. Энэ талаар ямархуу байдлаар санал, бодол байгаа юм? Байнгын хороон дээр ямархуу байдлаар яригдсан юм? Үүнийг сонсчихмоор байна.

Гурав дахь зүйл ерөөсөө энэ Баялгийн сангийн тухай хуулиа маш яаралтай оруулж ирж баталж, үүгээр тэр заяагдмал баялаг дээр тулгуурлагдсан үр өгөөжийг яаж тэр баялгийн сандаа авах юм? Тэр хуримтлалын сан нь дотроо ямар бүрэлдэхүүн хэсэгтэй энэ баялгийн



сангийнхаа дотор явах юм? Энэ харилцаагаа зохицуулж байж сая энэ төрийн болон орон нутгийн өмчтэй компаниудын татварын дараах цэвэр ашгийг хэрхэн яаж хуваарилах вэ гэдэг юм өөрөө зөв болох юм байна лээ. Ямар хэсгийг нь тэр хөрөнгийн хувь, ноогдолд нь олгох ёстой юм, ямар хэсгийг нь тэр үйлдвэр хөгжүүлэх үйл явцад нь чиглүүлэх ёстой юм гэдэг юм тодорхой болж байж сая энэ төсвөөс гадуур гэдэг юм уу янз бүрийн байдлаар төсөл хөтөлбөр төрийн болон орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн хөрөнгөөр түрүүгээрээ зарцуулаад байдаг юм эд нар хязгаарлагдаж зөв голдиролдоо орох ёстой. Үүнийг юу гэж харж байна вэ? Ийм хэдэн зүйл дээр тодорхой хариулт авъя.

**Г.Занданшатар:** Байнгын хороо хэн хариулах юм? Батлут ажлын хэсгийн дарга. Дамбын Батлут гишүүн хариулъя. Батлут гишүүн карт чинь уншигдаагүй байна гэж байна. Одоо орчихсон. Дамбын Батлут гишүүний.

**Д.Батлут:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Манай ажлын хэсгээс бас нэмж хариулна байх. Ажлын хэсгийнхэн байгаа. Нэршлийн хувьд таны саналтай бас санал нэг байна. Тодорхой бас нэршлийг өөрчлөөд оруулах боломж, бололцоо байгаа. Түүн дээр эргээд ярилцаад явчих болох болох байх гэж боддоод байж байна.

Компаниуд төрийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн засаглалтай холбоотой асуудлыг сайжруулах шаардлага байгаа юу? Байгаа. Өнөөдөр төрийн өмчит компаниудаас үндсэндээ 2-3 аж ахуйн нэгж л ашигтай ажилладаг бусад нь дандаа алдагдалтай ажилладаг. Тэр 2, 3 компани нь бусад аж ахуйн нэгжүүдийнхээ алдагдлыг үүрч явж байдаг ийм л дүр зураг байгаа. Төрийн болон орон нутгийн өмчийн олон аж ахуйн нэгжүүд шинээр байгуулагдаад байдаг, төдийлөн ашигтай

ажилладаггүй, үр дүн өгөөж муутай байдаг гээд олон асуудлууд байгаа. Түүнээс улбаалсан нийгэмд бас нэлээн сенсац тарьж байгаа хулгай зэлгий олон асуудлууд энэ төрийн өмчийн компанийн үйл ажиллагаатай уялдаж гарч ирж холбогдож байгаа. Тэрийг бас үгүйсгэхгүй.

Тийм учраас энэ нийгмийн ч шаардлагаар энэ төрийн өмчийн компаниуд, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг олон нийтийн оролцоотой болгох, засаглалын шинэ загварыг, сайн засаглалын загварыг бий болгож ажиллах шаардлага байгаа гэж үзэж байгаа. Үүний дагуу бид бүхэн бас ажлын хэсэг дээр, ажлын дэд хэсэг дээр ярилцаж тодорхой чиглэлүүдийг гаргаж байгаа юм.

Энэ аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэж байгаа чиг үүрэг, байгалийн баялгийн хуваарилалт, нийгмийн тэгш байдлыг хангаж буй байдал, засаглал, бүтэц, санхүү, эдийн засгийн үзүүлэлт, хөрөнгийн өгөөжийн байдал, богино, дунд, урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, бодлоготой эсэх, хууль болон салбарын бодлогын баримт бичгүүдэд нийцэж байгаа эсэх гээд, өмчлөлийн маргаантай эсэх зэрэг олон шалгуур үзүүлэлтийг баримталж байгаад салбарын зохицуулалттай нийгмийн үйлчилгээ үзүүлэгч, дэд бүтэц, эзэмшигч, төрийн өмчит хуулийн этгээд, стратегид суурилсан төрийн өмчит хуулийн этгээд, өрсөлдөөнд суурилсан төрийн өмчит хуулийн этгээд гэж үндсэн 3 ангилалд хувааж ангилал тус бүрд ялгамжтай бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Энэ 3 ангилалд орсон компаниуд дээр бид нар бас олон нийттэй оролцоотой болгох асуудал дээр яг саяын дурдсан зүйлүүд дээр тулгуурласан ингэж нийцтэй, зөв зохицуулалтуудыг засаглалын хэлбэрийг гаргаж ирж өгөх нь зүйтэй. Ингэж байж энэ компаниуд нь цаашид нээлттэй, үр өгөөжөө өгсөн ийм байдлаар ажиллах боломж, бололцоо бүрдэнэ гэж харж байгаа юм.

Мэдээж энэ асуудлыг гол зонхилж ярихад стратегид суурилсан төрийн өмчийн хуулийн этгээд гэдэг дээр байгалийн баялгийн сантай холбоотой асуудал нэлээн уялдаж өгнө. Мэдээж энэ стратегид суурилсан төрийн өмчийн компаниудын хувьд хуулийн этгээдийн хувьд бол уул уурхайн компаниуд голчлон орж байгаа. Ингэхээр баялгийн сантай холбоотой асуудлыг яг энэ асуудал дээр бас нэлээн холбож өгөх. Үүнтэй холбоотой засаглалын менежментийг бас сайжруулахтай холбоотой асуудал ч гэсэн энэ дээр давхар яригдах боломжтой гэж харж байна.

**Г.Занданшатар:** Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Энэ хуулийн төслийг санаачилсан гишүүдийн нэг нь бас би байгаа. Бид бас цаг алдаж хэлэлцэж байна. Яагаад үүнийг санаачлахаар болсон юм бэ гээд харахад хамгийн сүүлийн жишээ сая нүүрсний сонсгол дээр л харахад хаана хамгийн их хулгай, авлигал, мөнгө угаалт явагдаж байна тэнд төрийн болон орон нутгийн өмчит компаниуд дээр, бид өмнө Эрдэнэт рүү их шахаад ямар аймаар түвшинд хүрч энэ манай улсын эдийн засагт яаж сөргөөр нөлөөлж байсан талаар ярьж байсан бол одоо харин “Эрдэнэс Тавантолгой” дээр жишээлбэл нүүрс тээвэрлэлт, энэ нүүрс олборлолт, нийлүүлэх тоног төхөөрөмж дагасан бизнес ямар түвшинд хүрснийг л харцаааа шүү дээ. 800 тэрбумаас 1 их наядын тендер зарлахад Монголд тэнд шалгарах стандартыг хангах компани бараг байхгүй. Нэг, хоёрхон компани.

Гэхдээ тэрийг шалгаруулахын тулд тэр стандартыг нь адилхан болгож өгнө, тэрийг дагасан авлигал төрийн албан тушаалтнуудад наалдана гээд л энэ асуудал үнэхээр аймаар түвшинд хүрчхээд байгаа шүү дээ. Өнөөдөр нийтийн тээвэр дампуурахад хүрээд ямар түвшинд хүрсэн. Энэ өөрөө

жишээ нь автобус 1, 2 баазууд өөрөө аж ахуйн үе бас үйлдвэрийн газар буюу төрийн өмчтэй. Тэнд бас яасан дандаа автобус шинэчлэл нэрээр ба баахан мөнгө угаалт явдаг, бизнес явдаг. Харин нийтийн тээвэр маань бүүр дорд ороод өнөөдөр дампуураад явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бүхнийг цэгцлэх зайлиггүй шаардлага байгаа учраас бид энэ хуулийг гаргах ёстой байгаа юм. Бид нар бас нэг зүйлийг сүүлийн үед харж байна шүү дээ. Төрийн өмчит болон орон нутгийн өмчит энэ компаниудаар дамжаад томоохон их хэмжээний мөнгөтэй тендер зарлаад энэ нь хэрвээ бас асуудал үүсээд юм бол сүүлдээ бүүр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр ороод зөвшөөрүүлчихдэг юм уу, эсвэл нууцын зэрэглэлд хүртэл оруулчихдаг ийм буруу жишиг хүртэл тогтоож байгаа байхгүй юу. Энэ нь өөрөө улсын эдийн засагт өнөөдөр иргэдийн маань амьжиргаанд гаднаас олж ирж байгаа экспортын орлого, валютын нөөц маань улам баяжаад байх ёстой байхад буруу зам руу урсаад явж байгааг өнөөдөр жишээ нь хуульчид, шинжээчид л нотлох баримттай нь гаргаад ирж байгаа зүйлүүд байна.

Тийм учраас би асуулт асуух гээгүй. Харин энэ хуулийг бид нар цаг алдалгүй гаргах ёстой байна. Төрийн өмчийн компаниуд, олон нийтийн өмчтэй энэ компаниуд дээрээ тавих хяналтыг тавьж, менежмент энэ удирдлага энэ тэр дээр нь өөрчлөлт хийх. Тэгэхгүй бол цаашидаа бид энэ яриад л байна яриад л байна. Хуульд нэмэлт, өөрчлөлт юм уу, хууль гаргасан болоод тэр нь өөр аргаар улам тэр мөнгө угаах арга нь боловсронгуй болоод цаашаа яваад байх магадлал өндөртэй байгаа учраас бас энэ дээр сүүлийн үед бас Улсын Их Хурал Хянан шалгах түр хороо энэ тэр байгуулаад бид асуудлыг гаргаж тавьж байна.

Засгийн газрын зүгээс зарим энэ тал дээр бас зоригтой ажиллаж байгаа зүйл зарим нэг зүйл дээр байна. Бусад дээр ингээд л юм нэг сайн ярьж байгаад л гагцхиаад байгаа. Тэгэхээр бид үүнийг гацаамааргүй байна. Цаашаа явуулах хэрэгтэй байна. Өмнө нь төрийн өмчит энэ болон төрийн өмчит хуулийн этгээд гэдэг дээр орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийг бид орхичихсон байсан бол одоо энэ дээр орон нутгийн өмчит гэдэг орж ирж байгаа. Бас энэ Нүүрсний сонсгол явсантай холбоотой Улсын Их Хурлын тогтоолын төслийг бид нар өчигдөр бас хэлэлцсэн. Энэ дээр ч гэсэн энэ заалтыг бид нар бас оруулж ирж байгаа. Ялангуяа тэр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр нууцын зэрэглэлд оруулчихдаг. Энэ нь өөрөө томоохон хэмжээний тендер энэ тэрийг эргээд шударга явж уу, хуулийн дагуу явж уу, үгүй юү гэдгийг гаргаад тавихад үзэж ч болохгүй, ярьж ч болохгүй, буруу, зөв, хууль зөрчсөн, зөрчөөгүй гэдэг нь тодорхойгүй ингэж асуултын тэмдэгтэй үлддэг байх явдлыг ч бид хаах ёстой.

Тийм учраас энэ асуудлуудыг цаг алдалгүй хэлэлцэж гаргах нь өөрөө улс орны эдийн засаг, цаашидаа авлигал, хээл хахуульдаа төрийн мөнгийг хууль бусаар урсгадаг юмтай хатуу тэмцэхэд туйлын чухал ач холбогдолтой гэдгийг хэлмээр байна.

Сүүлийн үед яг хэлж байна шүү дээ. Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид Монголын төртэй өрсөлдөх үнэхээр хэцүү байна, чадахгүй юм байна, эсвэл авлигал юм өгч байна явах, эсвэл тэр тендерт нь оролцохын тулд тэр тухайн албан тушаалтнуудтай нөхөрлөх буруу замаар ч гэдэг юм уу тээ, ингэхгүй бол юм явахгүй байна гээд байна. Тэгэхээр төр энэ бизнест хутгалдах явдлаа зогсоох ёстой гэсэн байр суурьтай байна.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирж байна. Үзэл баримтлалын хувьд бол дэмжиж байгаа энэ тогтоолыг. Энд аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай гээд үзэл баримтлал нь бол ер нь сая Оюунчимэг гишүүний ярьсанчлан үнэхээр зөв, зүйтэй. Өөрөөр хэлбэл энэ хувийн хэвшил хийх боломж, бололцоотой зүйлийг төр өмнүүр нь орж хийдэг, өрсөлдөх боломж бололцоог нь хаадаг, давуу эрх эдэлдэг энэ зүйлийг больё гэж байна шүү дээ. Энэ бол үзэл баримтлалын хувьд бол зөв, зүйтэй хууль.

Гэхдээ орж ирж байгаа хуулийнх нь үг үсэг чинь арай болохгүй байгаад байна. Нэгдүгээрт хязгаарлая, дахиж компани байгуулахгүй гэдэг маань юу гэсэн үг юм бэ? Яах вэ тэр байж болно. Гэхдээ аливаа зүйлийг сайжруулахын тулд арга хэмжээ авах ёстой байтал энэ чинь зүгээр үүсгэн байгуулахыг нь зогсооно гэдэг бол бас л нэг талдаа буруу асуудал байхгүй юу даа. Бид нар сайжруулах ёстой, үүнийг сайжруулах ёстой.

Тийм болохоор энд магадгүй зүгээр Засгийн газар дээр тодорхой хэмжээний арга хэмжээ аваад, зарим аж ахуйн нэгж төрийн өмчит үйлдвэрийн газруудыг шалгаад, үзээд, үнэхээр зайлшгүй байх ёстойг нь байлгаад, байхгүйг нь татан буулгаад, тэрийг нь хувийн хэвилээр орлуулаад, ийм үг үсэгтэй жоохон арай ондоо байдлаар орж ирэх нь зүйтэй байсан юм болов уу гэж бодож байна.

Тэгэхээр мэдээж хэлэлцэх нь зүйтэй, хэлэлцээд ажлын хэсэг гарна. Ажлын хэсэг дээр бас нэлээн үг, үсэг юмнуудыг нь засах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Ер нь бол цааш цаашидаа улс орны үйл ажиллагааг, улс орны төрийн үйл ажиллагааг хэн

хэрэгжүүлэх юм бэ? Энэ чинь аж ахуйн нэгж иргэд өөрсдөө л аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байж л улс орны энэ бүх зүйлүүдийг чинь авч явах ёстой шүү дээ. Бид бол стратегийн гэдэг том үг барьчхаад л тэрнийхээ хүрээнд бүх юмыг хамж авсаар байгаад төр хамаг зүйл дээр нь очоод суучихдаг. Аж ахуйн нэгж үйл ажиллагаа иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь бол тасалдаг, зогсдог, дампуурдаг ийм нөхцөл байдлыг л бид нар бий болгоод байгаа. Ер нь бол нэг гэр бүл, нэг иргэн, нэг аж ахуйн нэгж хөл дээрээ босох бүх боломж бололцоог бид нар хангах ёстой. Одоо төрийн өмчийн зохицуулалтын газрын дарга Цэнгэл дарга орж ирж байна. Бас энэ дээр хариулт гаргаадхаач. Цааш цаашидаа ийм бодлогоо ямар хэмжээнд авах юм? Зарим нэгэн аж ахуйн нэгжүүдийг татан буулгах хэрэгтэй байна. Одоо бид жишээ нь сая тэр АЗЗА-тай холбоотой авто замын засвар ачилттай холбоотой асуудлуудыг хувийн аж ахуйн нэгжүүд наана чинь хийгээд явж байгаа шүү дээ. Яагаад өшөө хувийн аж ахуйн нэгжүүдэд нь гаргаад нэг аж ахуйн нэгж ч гэсэн хөл дээрээ босоод, нэг иргэн, өрх гэр гэрийн амьжиргаа дээшлэх ийм боломж, бололцоог нь хаагаад заавал төр дээр ингэж аваад байгаа юм. Энэ чинь нэлээн олон 50-иад аж ахуйн нэгж байдаг билүү дээ. Тэр дотроос чинь 7, 8 нь бол хувийн аж ахуйн нэгж үйл ажиллагааг нь хийгээд яваад, ажиллаад болоод байдаг шүү дээ.

Тийм болохоор төрийн бид нарын бодлого бол ерөөсөө л нэг ч гэсэн аж ахуйн нэгж, нэг ч гэсэн иргэн хөл дээрээ босдог, орлого нь нэмэгдэх ийм боломж, бололцоог л бид нар хангах. Тэрнийх нь хууль, эрх зүйн орчныг бид нар бий болгох л төрийн үүрэг шүү дээ. Гэтэл бид нар тэрийг нь л өөрсдөө булааж аваад өөрсдөдөө давуу эрх эдлээд байгаа. Тийм болохоор цаашидаа энэ Цэнгэл даргын хувьд төрийн өмчийн компаниудаа цомохтгох, хариуцлагажуулах, тэгээд цаашидаа зарим нэгийг нь бол, би бол жишээ нь сайд байх үед АЗЗА-нуудыг

хувьчилъя гэж оруулж ирж байсан Улсын Их Хуралд. Хэлэлцээгүй тухайн үед. МИАТ компанийг хувьчилъя гэж оруулж ирж байсан. Хэлэлцээгүй. Тэгээд хардаад л хэн нэг нь авах гээд байна уу гэсэн ийм хардлага төрөөд л ингээд л явчихдаг. Нөгөө тамын тогоон дотроо бид нар чинь нэлээн хөөрхөн хөөрхөн бие биеийгээ хардаад ингэж явсаар байгаад өнөөдрийн 30 жилийг өнгөрөөлөө шүү дээ.

Тийм болохоор цаашидаа аж ахуйн нэгжүүдээ хувьчлах, аж ахуйн нэгжүүдийн хувьд аваачих, хувийн хэвилийг дэмжих, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх ийм ямаршуу бодлого барьж байгаа вэ? Энэ талаасаа бас хариулт өгөөч? Ерөнхийдөө тогтоолын төслийг дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Батлут. Дамбын Батлут ажлын хэсгийн дарга хариулъя.

**Д.Батлут:** Манай ажлын хэсгийнхэн бас нэмж хариулаарай. Бат-Эрдэнэ гишүүнтэй санал нэг байгаа. Мэдээж хувийн хэвшлийнхэн хийж, хэрэгжүүлж чадах ажилд төр төдийлөн оролцоод байх нь өөрөө өнөөдөрт хамгийн буруу зүйл гэдэг нь харагдаж байгаа. Тийм учраас бид нар энэ дээр ч гэсэн нэлээн ач холбогдол өгч, цаашидаа төрийн өмчийн компани байгуулах уу, үгүй юү? Байгуулбал ямар нөхцөл, байдал байгуулах вэ гэдэг дээрээ ч нэлээн сайн бодлого гаргаж ажиллах ёстой гэж харж байна.

Тэгэхдээ төрийн өмчийн компаниудыг шинээр барьж байгуулах асуудал нь түр зуур хориглох ийм чиглэлтэй, агуулгатайгаар энэ тогтоолын төсөл орж ирж байгаа. Одоо Улсын Их Хуралд Төрийн болон төрийн өмчийн компанийн тухай хууль орж ирсэн байна. Энэ хуулийг батлагдах хүртэл хугацаанд бид бүх энэ тогтоолын хэрэгжилт үйлчилнэ гэж үзэж байгаа юм.

Түүнээс хойш мэдээж дараа дараагийн асуудлууд яригдаад явах байх. Энэ хүртэлх хугацаанд бас энэ төрийн өмчийн болон төрийн өмчийн компаниудын засаглалтай холбоотой асуудлуудаа бид нар цэгцлэх, үйл ажиллагааныхаа чиглэлүүдийг тодорхой болгох энэ тэр гээд олон асуудлуудыг хийж хэрэгжүүлэх шаардлага байгаа гэж харж байгаа. Энэ хүрээнд ч гэсэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар бусад холбогдох яам тамгын газрууд ч гэсэн тодорхой алхмууд хийж байгаа. “Эрдэнэс Монгол” компани гэхэд жишээлбэл нийт 38 компани байсныг 10-ыг татан буулгаж 28 компани болгосон. Төрийн өмчийн бодлого зохицуулалт газрын харьяа 43 аж ахуйн нэгжүүдийг 20 болгосон. Үйл ажиллагаа чиглэлийнх нь дагуу нэгтгэсэн зохион байгуулалтад оруулсан гээд олон зүйлүүд байгаа. Энэ зүйлүүдийг ч гэсэн цаашидаа эрчимтэйгээр хийгээд хэрэгжүүлээд явах ёстой гэж харж байна. Манай ажлын хэсгээс нэмэлт мэдээллүүд өгөх үү Цэнгэл даргаа?

**Г.Занданшатар:** Ер нь төрийн оролцоог хязгаарлах гэж ойлголт байсныг нь байхгүй болгоод төрийн өмчийн компаниудыг түр хориглох гэхээр зарчмын өөр ялгаатай л болчихоод байгаа юм л даа. Үр ашиг менежментийг сайжруулах гээд. Төрийн оролцоо гэдэг чинь л бүх салбарт, бүх чиглэлээр, янз янзын л. Тэрийг л тодруулаад байх шиг байна. Тэрийг хариулаарай. Одоо Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуулт асууя. Цэнгэл дарга саяын асуултуудад хариулт бэлдээрэй.

Цэндийн Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Тогтоолын төслийг дэмжиж байгаа. Ажлын хэсгийн боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг дэмжиж байгаа. Би асуух гэсэн юм. Энэ Цэнгэл даргаас асуух юм уу? Сая Баярсайхан даргаас л асуудаг байж дээ

Санхүүгийн зохицуулах хорооны. Бид нар чинь хууль банкны хууль батлаад 20 хүртэл хувийг нь, 20 хувийг нь биржээр борлуулна гээд хууль баталчихсан шүү дээ. Тэгээд одоо хэрэгжилт нь 4.5 хувьтай байна гээд байх юм. Тэр юунаас болоод байна? Энэ Цэнгэл дарга хариулж чадах юм болов уу? Эдийн засгийн байнгын хорооныхон хариулж чадах юм уу? Тэгээд бид нар чинь хугацааг нь сунгая гэж яриад байгаа шүү дээ. Хугацаа сунгаад дүн гарах уу, юунаас болоод байна? Хэрэв, эсвэл хууль эрх зүйн орчин дутуу байна уу, эсвэл худалдаж авах сонирхол байхгүй байна уу? Эсвэл худалдах сонирхол байхгүй байна уу, эсвэл худалдах механизм бүрдээгүй байна уу? 4 л шалтгаан байна л даа.

Өчигдөр манай Сүхбаатар дүүргийн сонгогч 2 дугаар хорооны иргэн Зоригтбаяр гэж залуу ирж уулзлаа. Эдийн засагч залуу юм байна. Тэр энэ дээр судалж, Улсын Их Хурал дээр судалж үзээд олон түмэнд хариулт өгөөч. Боллоцоо нь байна. Худалдаж авах сонирхолтой иргэд аж ахуйн нэгжүүд байна. Үүнийг зарах сонирхолгүй этгээдүүд нь банкнууд өөрсдөө байна. Тийм учраас 2 жилээр хойшлуулаад дүн хүрэхгүй. Ядаж жил болгоод жилийн дотор шахаад энийг хийгээч гэдэг жишээ нь хүсэлт тавьж байна л даа. Би нарийн ширийнийг нь мэдэхгүй учраас Эдийн засгийн байнгын хорооныхноос асууж байгаад хариулъя гээд. Одоо бол энэ Зоригтбаярт хариулт өгчихмөөр байх юм. Энэ хуулийн хугацааг 2 биш, 1 жилээр сунгах бололцоо байна уу? Үр дүн гарах бололцоо байна уу? Тийм шахах арга механизмууд байна уу? Ийм л асуулт байх юм. Сая Баярсайхан дарга гараад явчихлаа л даа. Тэгье баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярсайхан дарга чинь Үнэт цаасны зах зээлийн хууль дээр байх л даа. Энэ чинь тийм. Энэ чинь яг энэ төрийн өмчийн компани хязгаарлахтай шууд холбоотой. Баттөмөр гишүүн хариулъя. Эдийн засгийн байнгын хороо.

**Б.Баттөмөр:** Банкны тэр хувьчлалтай холбоотой Мөнх-Оргил гишүүний тавьж байгаа асуултад хариулъя. 2021 онд Монгол Улсын Их Хурлаар банкны 1 хувьцаа эзэмшигчийн хэмжээг 20 хувиас ихгүй байна гээд. 23 оны 12 сарын 31-ний дотор энэ хууль хэрэгжинэ гээд, дуусна гээд ингээд хууль гарчихсан юм. Яг 5 банк системийн нөлөө бүхий 5 банк хувьцаа гаргасан. 5-10 хувь, 11 хувь гэж байгаа юм. Яг дунджийг нь аваад үзэхээр 6.9 хувь нь л арилжаалагдсан байгаа. Тэгээд өнөөдөр ямар байдалтай байна гэхээр Зэрэг Хаан банкин дээр 32.6 хувийн төвлөрөл үүссэн байгаа. Худалдаа хөгжлийн банкин дээр 50 хувийн төвлөрөл байна. Одоо хамгийн их нь Чингис хаан банк гээд байгаа шүү дээ. Манайх 12 банкттай. Тэн дээр 80 хувийн төвлөрөл.

Ингээд үзэхээр энэ хугацаа дууссан байдаг. Хууль хэрэгжээгүй. Энэ яг юунаас болчхов гээд үзэхээр энэ 5 банкны хувьцааг зэрэг IPO гаргаад авах тийм хөрөнгийн боломж алга байна нэгдүгээрт тэгж үзэж байгаа.

Хоёрдугаарт бол манай өнөөдөр эдийн засгийн байдал, тэр банкны хувьцааг авах уу, банканд 12 хувийн хүүтэй хадгалуулах уу гэхээр 12 хувийн хүүтэй хадгалуулах нь илүү эдийн засгийн хувьд илүү тэр хүмүүст ашигтай байна. Ингээд судалгаа ямар хүмүүс авчих вэ гэхээр тухайн банканд хадгаламж эзэмшигчид авсан байгаа. Өөрөөр хэлбэл мөнгөө өсгөө гэж аваад, тэр нь өсөхгүй. Өнөөдөр үнэлгээнээсээ доор орчихсон. Зөвхөн, ганцхан Хаан банкных үнэлгээндээ байгаа.

Тийм учраас үүнийг их бодолтой хийхгүй бол болохгүй болчихоод байгаа юм. Энд нэг айхтар асуудал гарч ирнэ. Энэ баланс гараад 2 сарын 15-нд баланс гардаг байх тийм ээ? 2 сарын 15-нд банкнуудын баланс гараад хувьцаа эзэмшигчийн хурал хийнэ. Тэгээд ирэхээр

20 хувиас дээшгүй байна гээд заачихаар нөгөө энэ төвлөрчихсөн байгаа энэ юунууд чинь бүгд саналын эрхгүй болчихож байгаа байхгүй юу. Нөгөө 5-10 хувь худалдаж авсан улсуудын эрх нь дээшлээд энэ банкны засаглалын хямрал болж болзошгүй ийм ноцтой байдал үүсчихсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр анх үүнийг оруулж ирэхдээ 2026 он хүртэл системтэйгээр ингэж явъя гэж тооцсон байсан юм. Яг хууль батлахдаа 23 оны 12 сарын 30 гээд баталчихсан байхгүй юу. Тэгэхээр энд бол өнөөдөр стратегийн хөрөнгө оруулалт ч алга. Тэр тодорхой тийм санхүүгийн эх үүсвэр нь алга байна. Хувьцаа эзэмшигчид бол, тэр хадгаламж эзэмшигчид нэмж авахгүй байна. Одоо ганцхан банк Монголд зөв засаглалтай байгаа. Тэр нь юу вэ гэхээр “Хас” банк. EBR дээр 11 хувийн хөрөнгө оруулалт хийсэн. Тэнд бүх хувьцаа эзэмшигчид нь 20-оос доош хувь. Энд маш сайн засаглалыг нь их зөв хэлбэр үүссэн байгаа байхгүй юу. Энэ 23 оны балансаараа тэгэхэд л 142 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Хувьцаа эзэмшигчдэдээ 10 хэдэн хувийг нь тарааж байх шиг байгаа юм л даа. Ийм байдал үүссэн байгаа юм. Үүнийг Их Хурал дээр хуулийн төсөл нь өргөн баригдсан байгаа. Засгийн газар яриад үүнийг тэр бүлгээр хэлэлцэж гэсэн. Бүлгээр хэлэлцээд олонх нь дэмжчихсэн байгаа. Өнгөрсөн 3 дахийн Засгийн газрын хурлаар хэлэлцэх байх гээд харж байсан Засгийн газрын хурлаар хэлэлцсэнгүй. Ирэх долоо хоногт хэлэлцээд, чуулган завсарлахаас өмнө амжихааргүй шахуу л болчихоод байна. Ийм ноцтой байдал үүссэн байгаа. Хувьцаа эзэмшигчийн хурал болоход энэ асуудал нэлээн ноцтой тавигдаж магадгүй ийм л нөхцөл байдал үүссэн байгаа. Тийм учраас тэр хугацааг бол 1 жилээр ч сунгаж болно, 2 жилээр.

**Г.Занданшатар:** Энэ хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой асуудал биш. Энэ тусдаа тэр Эдийн

засгийн байнгын хороогоор.  
Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Би энэ нэг зүйл асууя. Энэ дээр байгаа юм. Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасан гээд ийм заалт орчихсон байгаа юм. Би бол юу гэж асуух гээд байна вэ гэхээр би энэ Их Хуралд суусан 20 жилийн хугацаанд энэ Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, энэ улс орон оршихуйн үндэс болсон газар, түүний хэвлийн баялаг, цаашилах юм бол түүний тэгш шударга хуваарилалт, энэ хүн оршихуйн үндэс болсон байгаль орчны тэнцвэрт байдал гээд ийм л асуудлуудыг их түлхүү тавьж, үүний төлөө уйгагүй хөөцөлдөж явж ирсэн хүний хувьд энэ орж байгаа асуудал яг юуг зохицуулах гэж байгаа юм бэ гэж нэг.

Дараагийнх нь юм бол энэ төрийн өмчит хуулийн этгээд компанийг байгуулах, эсвэл татан буулгах, тэдгээр компаниудаа үр ашигтай ажиллуулах ч байдаг юм уу энэ асуудал Засгийн газрын бүрэн эрхийн асуудал байхаар байтал ингээд Их Хурлын гишүүд маань ийм хуулийн тогтоолын төсөл санаачлаад ороод ирж байна л даа. Энэ маань цаанаа ямархуу агуулга, санаатай байгаа юм бэ? Эсвэл Засгийн газар үүнийг юу гэж үзэж байгаа юм бол гээд нэг асуудал байгаа юм.

Ер нь зүгээр бодит байдал дээр түрүүн Батлут гишүүний хэлж байгаа энэ олон төрийн өмчит, Адьяасүрэн гишүүн ээ би энд үг хэлээд, асуулт асуучих гээд байгаа юмсан. Тэгээд энэ төрийн өмчит олон компаниуд үр ашиггүй ажиллаж байгаа. Үүнтэй санал нэг байгаа юм. Яг бодит байдлаар бол энэ чинь зарим хүмүүст зориулаад энэ төрийн өмчтэй нэгж аж ахуй юмнууд байгуулж өгдөг, өгч байсан ийм тохиолдлууд бий шүү дээ. Энэ үр ашиггүй байгаа ийм аж ахуйнуудаа бол цэгцлээд, хувьчлаад, татан буулгаад, цэгц журамд нь оруулаад, энэ хувийн хэвшил аж ахуй

байгууллагууд хийж чадах энэ аж ахуй бизнес рүү нь төр хутгалдаад оролцоод байдаггүй загасны мах заагтай ялгаатай гэж гэдэг шиг үүнийг нь зааглахдаа үүнтэй бол санал нэг байгаа юм.

Үнэхээр энэ улс орныг чинь авч явах, өнөөдөр ч авч явж байгаа энэ том, ялангуяа энэ дахин сэргээгдэж бий болгохгүй байгалийн баялаг дээр тулгуурласан энэ том компаниуд байна шүү дээ. Өнөөдөр бодит байдал дээр бол Эрдэнэт, Тавантолгой ч гэдэг юм уу, энэ Монросцветмет нэгдэл өөр юу гэдэг юм энэ том компаниуд чинь л энэ улс орныг авч явж байна шүү дээ. Хамгийн гол нь тэнд тавьж, менежментийг хийж байгаа, ажиллуулж байгаа хүмүүс маань л итгэл дааж, хариуцлагатай ажиллаж чадахгүй байгаа юм. Тэнд хувийн ашиг сонирхол, бусдын ашиг сонирхол ийм жижиг ашиг сонирхлын төлөө ажиллаад, хулгай худал янз бүрийн булхайтай юмнууд тэндээс гараад байгаа байхгүй юу. Үнэхээр хүнээ тавиад, менежментийг нь сайжруулаад ажиллах юм бол одоо болохгүй юм энд огт байхгүй л гэсэн ийм хатуу байр суурьтай байдаг. Энэ чаддаг хүнийг нь хаанаас олж ирж тавьдаг юм? Ингээд ажиллах бололцоо байдаггүй юм уу? Эрдэнэтийг бид мэдэж байгаа шүү дээ. 49 хувийг нь Оросын Холбооны Улсаас авч ирээд ажиллуулсан хүмүүс маань бол энэ Монголын төр, ард түмэнд төсөвт төвлөрүүлдэг хөрөнгө мөнгө нь бүүр эрс багасаад буугаад явчихсан. Гэтэл онцгой дэглэм тогтоогоод, төр эргүүлээд авахад энэ КОВИД-ын цар тахлын үед чинь аж ахуйн нэгж, ард иргэдийнхээ дулаан, цахилгаанаас эхлүүлээд л бүх асуудлыг нь даагаад л явж байна. Өнөөдөр Тавантолгойг хар. Ямар.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Дамбын Батлут гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулъя.

**Д.Батлут:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Маш чухал сэдвийг хөндөж байна. Өнөөдөр бас энэ

тогтоолын төслөөр Монгол Улсад Улсын Их Хурлаар батлагдаж гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх асуудлыг бас нэлээн эрчимжүүлж өгөхөөр зааж өгсөн байгаа. Тэр дотроо Ашигт малтмал малтмалын тухай хуулийн 5.6 дахь хэсэгт заасан энэ заалтыг хэрэгжүүлэх асуудал. Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг гаднын хөрөнгө оруулалттай компаниуд гадаадад өөрсдийн хувьцаа, IPO гаргадаг мөртөө Монголд энэ Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олон нийтийн оролцоотой болох энэ боломжийг бүрдүүлэх тал дээр ямар ч идэвх, санаачилга гаргахгүй байгаа.

Тэгэхээр энэ хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр ер нь Засгийн газар цаашилаад энэ гаднын хөрөнгө оруулалттай компаниудтай бас нэлээн сайн ажиллах ёстой гэж харж байгаа юм. Тухайлбал, “Оюу толгой” компани байна гээд олон компаниуд нэрлэж болно. Өнөөдөр хөрөнгийн бирж дээр ганц хувьцаа гаргаж, нээлттэй арилжаа хийж байгаа ганцхан гадаадын хөрөнгө оруулалттай л компани байна. Өөр компаниуд байхгүй байх жишээтэй. Тэгэхээр энэ талдаа нэг талдаа Улсын Их Хурлаас чиглэл өгөөд Засгийн газар бас энэ хуулийн хэрэгжилтийг хангах тал дээрээ анхаарч ажиллах ёстой.

Нөгөө талдаа иргэд бас нэлээн сайн мэдээлэлтэй, ойлголттой болох ёстой юм байна гэж харж байгаа юм. Хэдийгээр хууль, эрх зүйн орчин бүрдээд гараад ирсэн байлаа ч гэсэн иргэд маань энэ тал дээр ойлголтгүй төдийлөн бас үр дүн гарахгүй. Тэгэхээр энэ дээр ч гэсэн холбогдох байгууллагууд нь яг энэ хууль сурталчлах, цаашилаад энэ олон чиглэл дээр нэлээн хурдацтай сайн ажиллах шаардлага байна гэдэг л харагдаж байгаа юм. Тэгэхээр энэ заалтын хүрээнд мэдээж энэ хуулийг хэрэгжүүлэх, дээрээс нь хууль сурталчлахтай ч холбоотой олон асуудлыг гаргаж өгөх нь зүйтэй гэж харж байна.

Энэ нийгэмд гарч ирж байгаа хулгай зэлгий гээд л олон зүйлүүд яригдаж байгаа үнэн. Энэ нь төрийн болон төрийн өмчит төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд дээр бас нэлээн гарч байгаа зүйлүүд бий. Зардал маш өндөр байдаг, ашигтай үйл ажиллагааны хувьд маш муу.

Тийм учраас бид нар энэ компаниудыг ер нь олон нийтийн оролцоотой болгох, засаглалын шинэ, зөв загварыг гаргаж өгч явах л шаардлага байна гэж үзэж байгаа. Энэ ганц нэг тэр захиралдаа ч биш гэж үзэж байна. Энэ засаглалын менежментийг сайжруулах, үр өгөөжтэй хамгийн сайн загварыг гаргаж авч, үүн дээр тулгуурласан бодлогоо хэрэгжүүлэх. Өөр өөрсдийн тухайн тухайн салбарынх нь онцлогт тулгуурласан тийм бодлогуудыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа л гэж харж байгаа юм. Ингэж чадах юм бол төрийн болон төрийн өмчийн компаниуд аж ахуйн нэгжүүдийн бас үйл ажиллагаа сайжрах, нээлттэй болох, аливаа бас эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх боломжууд бүрдэнэ л гэж харж байна. Манай ажлын хэсгийнхэн нэмэлтээр хариулаарай. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Бадмаанямбууги  
ийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Би цаг багтаж асууж чадсангүй л дээ. Би 2 жишээ хэлээд байгаа нь Эрдэнэтийг би хэлчихлээ. Хагас хугас ч гэсэн ойлгогдохоор асуусан байх гэж бодож байгаа юм. Дараагийнх нь юу хэлэх гээд байгаа гэхээр энэ Тавантолгой. Энэ чинь байгуулагдсан цагаасаа л хэл амтай. Үүнийг томилогдсон хүмүүс нь дандаа хэрэг төвөгт, асуудалд орооцолдсон. Үүнийг чинь ингээд ямар нэгэн тийм ашиг сонирхлоос ангид, төрийн албаны хамгийн дээд ажил албан тушаал хашиж байгаа Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргыг тавиад, ажиллуулаад 1 жилийн хугацаанд ямархуу үр дүн гарав?



Энэ чинь татварын дараах ашиг нь хоёр аравны хэдэн их наяд төгрөг гаргачихсан. Одоо ингээд хувь, ноогдол ашгийг хуваая, хуваарилъя, энэ улсын төсвийн орлого яаж давж биелэв, татвар, валютын ханш, нөөц ямархуу хэмжээнд байна гээд. Энэ чинь байна шүү дээ тогтолцоо, системийнх нь асуудлыг шийдэхээс гадна энэ хүний асуудал, хүний хүчин зүйл гэдэг чинь чухал юм. Илэрхий.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Чимэдийн Хүрэлбаатар гишүүн алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Тасаллаа. Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна. Асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Баттөмөр:** Энэ асуудлыг өчигдөр Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцсэн юм. Би бас түүн дээр нэлээн тодорхой хэлсэн юм. Ер нь энэ тогтоол маань зөв гараасай гэдэг утгаар бас дахиж зарим асуудлыг ярихгүй бол болохгүй гэж үзэж байна л даа. Энэ төрийн өмчит компани байгуулах ер нь Засгийн газрын ажил шүү дээ. Засгийн газрын гарыг боогоод л, хаагаад л, тэгж байгуулж болохгүй, барихгүй гээд байх нь буруу гэж би үзээд байгаа юм. Засгийн газар үүнийг дэмжээгүй. Засгийн газрыг яагаад дэмжээгүй гэхээр бид нар энэ 5 сарын 4-ний өдөр төрийн болон орон нутгийн өмчид чинь Компанийн тухай хуулийг Их Хуралд өргөн барьчихсан.

Түүн дээр чинь энэ бүх асуудлуудыг чинь тавьчихсан байгаа. Хэрэггүй ээ гэсэн ийм л хариу өгсөн байгаа шүү дээ. Энэ бол барьснаас хойш 1 сарын дараа энэ хуулийг өргөн барьсан байгаа. Яах вэ дээ их төвөгтэй л дөө. Стратегийн ордууд дээрээ бид төрийн өмчтэй компани байгуулж л таарна шүү дээ. Хармагтаа, Асгат гээд. Ер нь Монгол Улсын хөгжлийн загвар бол ямар байх вэ гэхлээр зэрэг баялаг дээрээ хувьцаат компани байгуулах, хувийн өмчөө дэмжих, төрийн өмчтэй

компаниудаа хувьцаат компани болгох. Ингэж байж хуримтлалтай болно. Хуримтлал хамгийн чухал асуудал. Өнөөдөр Монголын ард түмний чинь үндсэндээ 42 хувь нь ядуурчихсан байна шүү дээ.

Тийм учраас үүнийг их зөв гаргах нь зүйтэй гэдгийг л хэлэх гээд байгаа юм л даа. Энэ төрийн өмчит компани гэхлээр л их муу муухай гээд л яваад байгаа байхгүй юу. Өнөөдөр нийтийн тээврээр 1 хүнийг 1000 төгрөгөөр тээхэд бол алдагдалтай байгаа. Татаас өгч байгаа. Цахилгааныг өдөрт 110 төгрөгөөр, шөнө 89 төгрөгөөр нийлүүлэх хувийн компани байна уу, энэ цахилгаан станцыг хувьчилж аваад? Байхгүй шүү дээ. Үүнийг төр чирч яваа шүү дээ. Багануурын нүүрсний уурхай 43 мянган төгрөгөөр 1 тонн нүүрсийг олборлоод 49 мянган төгрөгөөр олборлоод 43 мянган төгрөгөөр нийлүүлж байгаа. 6 мянган төгрөг тонн тутамд алдагдалтай.

Яагаад гэхээр нөгөө дулаан үйлдвэрлэх, цахилгаан үйлдвэрлэхийг л улс авч явахын тулд л ингэж байна шүү дээ. Цэвэр усыг одоо 1 литрийг 1 төгрөг 34 мөнгөөр нийлүүлэх компани байна уу? Байхгүй шүү дээ. Бохир усыг 1 литрийг нь 1 төгрөг 7 мөнгөөр нийлүүлэх компани байна уу? Байхгүй шүү дээ. Хувьчлаад аваг л дээ. Бүгдийг нь өгье. 1 м2 орон сууцын халаалтыг 506 төгрөгөөр нийлүүлэх компани байна уу? Байхгүй шүү дээ. Хувьчилъя л даа. Хувьчлаад авъя авах гэсэн улсууд нь аваг л дээ. Чадахгүй шүү дээ. Энэ ийм алдагдалтай. Хэрвээ хувийн компани авах юм бол энэ тариф чинь нэмэгдэнэ. Ард түмний амьдралын түвшинтэй уялдуулаад үүнийг чинь төр чирч яваад байгаа байхгүй юу. Тийм учраас, чи сууж бай. Чамтай яриагүй байна.

Ер нь бол иймэрхүү асуудлууд бүх улсад байдаг. Европын Холбоо цаашаагаа Америкт бол тодорхой салбаруудаа чирч явдаг шүү дээ. Манайх ялгаа байхгүй шилжилтийн эдийн засагтай энэ улсад

үүнийг чирч явахаас өөр арга байхгүй. Үнэхээр үүнийг сонирхоод сая хэлж байгаа тоонуудын хэмжээнд аваад явна гэвэл тэр хувийн компаниуд нь хувьчлаад өгөх хэрэгтэй Цэнгэл даргаа. Тийм юм байхгүй шүү дээ. Үүнийг авах хүн байхгүй. Хувийн компани бол зөвхөн ашигтай л бизнес, ашигтай ажилд хөрөнгө оруулалт хийнэ шүү дээ. Төрийн өмчийн компанийг буруу гээд байж ерөөсөө болохгүй. Тэнд бол юу гэхлээр засаглал нь, засаглал гэж том юм ярихын, тэнд хулгайч нар хувийн сонирхолтой улсууд очиж ажиллаад байна шүү дээ. Цүнх баригч нар очиж ажиллаад байна. Үүнийгээ л больчих. Тэр мэдлэгтэй, чадвартай манлайлагч нарыг аваачаад тавь. Тэгсэн тохиолдолд.../минут дуусав./

**Г.Занданиатар:** Үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

14 цаг хүртэл чуулган завсарлалаа. 14 цагаас санал хураалтаар эхэлнэ. 14 цагаас санал хураалтад бэлтгээрэй.

13.22 цаг

Пүрэв гараг 11 Нэгдүгээр сар 2024  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
14 цаг 07 минут.

### ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданиатар:** Өдрийн амгаланг айлтгая. Гишүүд үг хэлж, асуулт асууж дууссан.

Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 9 санал

байгаа. Зарчмын зөрүүтэй саналуудыг дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно.

Нэгдүгээрт, өргөн мэдүүлсэн төслүүдийг нэгтгэж, нэгтгэсэн төслийн гарчгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Гарчгийг бол Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай. Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар нарын 12 гишүүнээс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэлээс өргөн мэдүүлсэн “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Хөөш энэ саналыг байна шүү дээ гүйцээн боловсруулах чиглэл өгөхгүй бол энэ байна шүү дээ хуулиар бас ингээд заавал байгуулах ёстой төрийн болон төрийн өмчит хууль. Тэгье тэгье. Хуульд заачихсан ордуудыг. Энэ асуудлаар үг хэлэх гишүүд байна уу? Санал хүртэл үг л хэлчихье. Байна дэмжсэн, дэмжээгүй. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Одонгийн Цогтгэрэл гишүүн гээд, Занданиатар тасаллаа.

Батжаргал гишүүн үг хэлнэ. Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Бид тогтоолоор асуудлаа зохицуулахаар оруулж ирсэн. Тэгэхээр зэрэг эхлээд энэ төрийн болон орон нутгийн өмчийнхөө үр ашгийг дээшлүүлэх асуудал нь бидний хамгийн том зорилго. Тийм учраас энэ нэршил өөрөө ингэж явмаар байгаад байгаа юм.

Тийм учраас би гүйцээн боловсруулах чиглэл өгүүлээд, энэ найруулга юман дээр нь янзлах ийм зайлиггүй шаардлага байгаад байгаа юм байна гэж ингэж л ойлгож байгаа.

**Г.Занданшатар:** Гүйцээн боловсруулах чиглэл авах. Одоо Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

**Ц.Даваасүрэн:** Тийм. Би бас гүйцээн боловсруулах. Тэгэхдээ энэ хуулийн зөрчлийг анхаараач гэж хэлэх гээд байгаа юм. Яагаад гэвэл энэ Үндсэн хуулийн зөрчилтэй болчихоод байгаа юм. Нөгөө бусад хуулиуд дээр чинь стратегийн ордын тэдэн хувь гээд байж байгаа юм. Мөн Үндсэн хууль дээр байгалийн баялаг ард нийтийн нийтийн өмч гээд байгаа шүү дээ. Тэгвэл бид нар тэр стратегийн ордуудыг заавал төрийн оролцоотой байгуулахаас өөр арга байхгүй. Энэ хууль дээрээ ч байна. Үндсэн хууль дээрээ ч гэсэн ер нь төрийн өмчийн оролцоотойгоо байж байж ард нийтэд бол баялаг хүргэх ёстой. Энэ хуулиуд дээр байгаа төрийн өмчийн оролцооны энэ заалтуудыг тогтоолоор давж болохгүй шүү дээ. Үндсэн хуулийн заалт хуулийг хүндэтгэнэ гэдэг. Тэгэхээр үүнийг Цэцэд хэн нэг нь өгчихөд л энэ гарах гэж байгаа тогтоол хүчингүй болно.

Тийм учраас энэ Үндсэн хуулийн зөрчлийн асуудлыг энэ хэлэлцүүлгийн явцдаа эргэж харахгүй бол болохгүй нь даргаа. Тогтоолоор хууль давсан ийм зохицуулалтыг хийж болохгүй. Хуулиуд дээр тодорхой төрийн өмчийн хувь, хэмжээнүүд байна гэдгийг анхаараач гэж. Ер нь хүнд цаг үед, КОВИД-ын үед төрийн өмчийн “Тавантолгой”, “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэт” л иргэдийн гэрэл цахилгааны мөнгө, мөн түлшний хөнгөлөлтийг өгсөн шүү дээ. Тэр тусмаа хэрэглээний зах зээл багатай оронд ер нь төрийн өмчгүй байна гэж ингэж хатуу хуульчилж огт болохгүй. Тэр тусмаа Засгийн газрынхаа гэдэг юм уу, төрийнхөө үйл ажиллагааг хэдэн

гишүүн санаачлаад л тас цохидог байж болохгүй шүү дээ. Ёс зүйн хувьд ч гэлээ гэсэн энэ бас жоохон утгагүй байгаа байхгүй юу. Тийм учраас энэ Үндсэн хуулийн зөрчлийн асуудал энэ эргэж харж, ингэж хэлэлцэхгүй бол болохгүй нь гэдгийг хэлэх гэсэн юм.

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Яг энэ тогтоолын төслийг өргөн барихдаа миний томъёолол болохоор аж ахуйн үйл ажиллагаанд төрийн оролцоог хязгаарлах тухай, аж ахуйн үйл ажиллагаанд төрийн оролцоог аажмаар багасгая, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг аль болох нээлттэй хувьцаат компаниуд болгоё. Энэ чиглэлүүдэд явъя. Богино хугацаанд тэр оролцоог хязгаарлах гэдэг тодорхой хэмжээний төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн тооны хувьд хязгаартай байя. Тэрнээс цоо шинээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг ор тас байгуулахгүй гэвэл энэ өөрөө хэтэрхий механик зүйл болчих байх. Магадгүй ураны салбарт ч юм уу харилцаа гарч ирдэг. Үүнийг бас яг яах юм? Тэгэхээр цоо шинээр нэгийг ч байгуулахгүй гэдэг чинь өөрөө ингэхэд механик зохицуулалт.

Тийм учраас би өргөн барьсан агуулга дээрээ болохоор тооны хязгаарлалт тавьчихъя, тэр дотроо нэмэгдэж, хасагдаад явна биз. Ер нь аж ахуйн үйл ажиллагаанд, бизнесийн үйл ажиллагаанд, бусад бизнесүүд хийчхэж болдог үйл ажиллагаанд төрийн оролцоог бодлогын хувьд аажмаар хэрхэн яаж хязгаарлах юм бэ? Хэрхэн яаж төрийн өмчүүд нээлттэй болох юм бэ? Энэ дотор магадгүй төсөв ч гэсэн Монгол Улсын эдийн засагт эзэлж байгаа төсвийн хувь, хэмжээ ч гэсэн аажмаар буурмаар байна шүү дээ. Яг одоо явсаар байгаад бид нар төрийн капитализм байгуулчихсан ийм л улс орон болоод хувирчихлаа шүү дээ. Үүнийг бодлогынх нь хувьд гаргая. Магадгүй

үүнийг дагаад хуулиуд, Төр болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд олон зүйлүүдээр нарийн зүйл мэдээж энэ шийдэгдэж гарах ёстой.

Тэгэхээр яг одоо энэ дээр байгаа нэришл бол шинээр байгуулахыг хориглох тухай гэгчээр бол нэлээн тийм их механик нэришлтэй болчихоод байна л гэсэн би саналтай байгаа юм. Ийм учраас тэр жишээ нь бусад нэр авч болно. Хамгийн гол нь тэр аж ахуйн үйл ажиллагаанд, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог хэрхэн, яаж хийж болох юм бэ гэдэг энэ агуулга руу нь илүү чиглүүлээч ээ гэж бас ажлын хэсгийг би санаачилга, энэ тогтоолын төслийг санаачилсан гишүүний хувьд бас энэ ажлын хэсгийг энэ тал руу нь илүү чиглүүлээч. Энэ механик зохицуулалт биш, илүү тийм чанарын зохицуулалт үүнд хэрэгтэй байна. Чанарын зохицуулалт. Одоо бол ингээд ийм механик үгнүүд орчихоод энэ чинь л дахиад л амьдрал дээр хэрэгжихэд төвөгтэй, хэцүү болдог шүү дээ л гэж хэлэх байна.

**Г.Занданшатар:** Гишүүдээ анхааралтай бай. Энэ 3 гишүүн, Батлут гишүүн ээ, Цогтбаатар гишүүн ээ, хууль санаачлагч нар аа, 3 гишүүн гүйцээн боловсруулах, Цогтбаатар даргаа, Батлут гишүүн ээ, 3 гишүүн гүйцээн боловсруулах шаардлагатай гэж үзлээ, үг хэллээ. Тэр дотроо хамгийн гол нь хууль санаачлагч, хууль тогтоолын төсөл санаачлагч Одонгийн Цогтгэрэл гишүүн бол бас энэ нэгтгэсэн хуулийн төслийн нэгтгэсэн хуулийн төслийн үзэл санааг аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах гэдэг агуулгаараа та дэмжиж байгаа биз дээ тийм ээ? Төрийн оролцоог хязгаарлах, түүнээс гишүүнийг түр хориглох. Тэгэхээр үүнийг гүйцээн боловсруулахад чиглэл өгөхөөс аргагүй.

Яагаад гэвэл хууль санаачлагч нар нэгдсэн байж байж хоёр тогтоолын төслийг нийлүүлж хэлэлцэнэ. Тогтоолын төслийг ч айн? Нэришл дээр гэхээр

гүйцээн боловсруулахгүй бол энд чинь санал хураагдчихвал ингээд л явчихна шүү дээ. Тийм учраас үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Тэгээд Тогтохсүрэн дарга ч тэр.

Ер нь уг язгуур нь эхлээд гүйцээн боловсруулах нэришлээсээ авхуулаад үзэл баримтлал нь гүйцээн боловсруулах чиглэл өгч байгаа учраас үндсэн, үлдсэн 9 нь энэ толгойтойгоо уялдах ёстой. Үүнийг, үлдсэн саналыг 9 саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Ингээд санал хураалт явуулах ч гэсэн энэ чинь. Үүнийгээ Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хууль хэлэлцэж байгаа тэр энэ тэртэй ч бас уялдах шаардлагатай болно л доо энэ тийм. Тэгэхгүй бол үг, үсэг нь бас зөрчилтэй болчихоод байна. Түр хориглож байгаа мөртөө тэдгээрийн үйл ажиллагааг үр ашгийг сайжруулах энэ тэр гэхээр чинь. Гэх мэтчилэн үзээд гүйцээн боловсруулахаар тогтлоо. Дараагийн асуудалд орно.

Хүүхэд хамгааллын, үгүй ээ толгой нь гүйцээгээд боловсруулагдахаар, хөл нь бас дагахаас өөр аргагүй болчихоод байна. Тийм. Дараагийн асуудалд орёё.

14.17 цаг

**Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна. Эцсийн хэлэлцүүлэг. Хүүхэд хамгааллын хуулийн эцсийн хэлэлцүүлэг. Тийм, таныг эзгүй байх үед анхны хэлэлцүүлэг хийчихсэн юм.

**Ц.Идэрбат:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр, 2024 оны 1 дүгээр сарын 4-ний өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг хуулийн төсөлд Хүүхэд хамгааллын ажилтны орон тоо, хүний нөөц, төсвийн талаар тодорхой тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт, орон тоо нэмэгдүүлснээр гарах үр дүнгийн талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасныг баримтлан зарчмын зөрүүтэй 3 саналаар санал хураалт явуулснаас 1 санал дэмжигдсэн бол хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д

заасныг баримтлан 2 санал хураалт явуулж дэмжигдсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль зүйн туслацааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшигаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Энэ холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдтэй энэ хуулийн багц төслийг хэлэлцэхийг шийдчихвэл дараа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг хэлэлцэнэ. Хүрэлбаатар сайд танилцуулбал бэлдэж байгаарай. Энэ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль явуулчихвал Мөнх-Оргил гишүүн ээ та ажлын хэсгээ хэзээ цуглуулах вэ гэж асуугаад байсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дараа нь

хэлэлцэгдэнэ. Тэгэхээр ажлын хэсгүүдээ тэгж бэлтгэсэн нь зөв байна гэж үзээд.

Одоо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар танилцуулчихсан. Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Энэ хооронд Байнгын хорооны танилцуулгатай, эцсийн хэлэлцүүлэг хийсэн тухай танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулчихъя. Хүрэлбаатарын Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сархадын Зулхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Нарантуяагийн Баярмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Аюурзанын Өнөржаргал Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний газрын дарга, Жанцандоржийн Азжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, Пүрэвээгийн Баттулга Хуулийн зөвлөх, өмгөөлөгч, Ганчулууны Оюунболд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч, Сүхээгийн Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Шагдаржавын Чинбат Гэр бүл, хүүхэд хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Чулууны Амарбаясгаланг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Адилбишийн Батхишиг Монгол Улсын Их сургуулийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш, дэд профессор, доктор, Пүрэвээгийн Болормаа Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Жадамбаагийн Мягмар Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн

дарга, Батсуурийн Дуламсүрэн Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжээч, Энхбаатарын Оюун-Эрдэнэ Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн, Андрей Уранчимэг Харилцаа холбооны зохицуулах хорооны мэргэжилтэн.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 3 санал байгаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Нийгмийн бодлогын байнгын хорооноос дэмжсэн санал байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дүгээр зүйлд заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу боловсруулсан саналууд байгаа.

1.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “орон нутгийн байгууллага,” гэсний дараа “хамтарсан баг” гэж нэмэх. Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулах уу Тогтохоо даргаа? Санал хураалт явуулъя, Хамтарсан баг гэж нэмчихлээ гэж.

Санал дэмжигдлээ. 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дугаар зүйлийн дагуу хураалгасан санал байна.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын, 36 дугаар зүйлийн 36.2.4 дэх заалтын “тохиолдлын зохицуулалт” гэснийг, мөн зүйлийн 36.2.5 дахь заалтын “тохиолдол” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 25 дугаар зүйлийн 4 дэх тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэ зүйлд заасан “цахимаар дарамтлах” гэж хүний хувийн болон эмзэг мэдээллийг ашиглан цахим орчинд хүүхдэд түгшүүр төрүүлэх, шахалт үзүүлэх үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.”. Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Маргааш өглөө чинь 100-аад хууль эцэслэн батлах байна уу? 100 гаруй хууль эцэслэн батална. Хамт өргөн мэдүүлсэн хуулиудтайгаа. Дараагийн асуудалд орёе.

14.26 цаг

**Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төсөл байгаа байх тийм ээ?

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг

Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Бейсен:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Улсын Их Хурлын өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг баримтлан Байнгын хорооноос боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нийцүүлэн 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр баталсан Зөрчлийн тухай хуульд цахим орчинд хүүхдийг дээрэлхсэн, дарамталсан тохиолдолд болон хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч өөрийн үйлчилгээндээ хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах үүргээ биелүүлээгүй бол гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг насанд хүрсэн хүнд харгалзуулалгүй орхисон хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахаас бусад тохиолдолд хүүхдийн байгаа газраас нь авч явсан, тээвэрлэсний улмаас хүүхэд эрсдэлт нөхцөлд орсон зэрэг тохиолдлууд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчилд нь шийтгэл оногдуулахаар тусгаж, Хүүхэд хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их

Хурлын гишүүн Идэрбатаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны танилцуулах санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн? Алга байна.

Байнгын хороо Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд оръё.

14.30 цаг

**Арав.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Жаргалмаа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг баримтлан Байнгын хорооноос боловсруулсан Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар явууллаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлдөө нийцүүлэн 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Боловсролын ерөнхий хуулийн зарим зүйл, заалтын дугаарлалтад өөрчлөлт оруулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөх зохицуулалтыг тусгаж боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Идэрбатаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасны дагуу хуулийн



төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Боловсролын ерөнхий хуульд оруулах өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсэг өмнөх хуультай ажил, албан тушаал, нэр овог нэг адил.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

Байнгын хороо Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлтгэе. Энэ хооронд Өнөрболор гишүүнийг суух хооронд зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалангийн урилгаар Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Сод-Эрдэм сургуулийн багш, эцэг эх, сурагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт багш, эцэг эхчүүд, сурагчдадаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сайн сурцгаагаарай.

Санал хураалт явуулна. Цогтбаатар даргаа, Батлут гишүүнээ санал хураалт. Санал хураалт.

71.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Сая хэн зураг аваад байсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн дагуу хүүхдийг сурталчилгаанд ашиглах, зургийн зөвшөөрөлгүй авах, эцэг эхээс зөвшөөрөл авахыг хориглоно гэж заасан байгаа шүү. Эцэг эхчүүдээс нь зөвшөөрөл аваагүй.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд оръё.

14.34 цаг

**Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь

хэсгийг баримтлан Байнгын хорооноос боловсруулсан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нийцүүлэн 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн зарим зүйл, заалтын дугаарлалтад өөрчлөлт оруулж, Хүүхэд хамгааллын тухай хууль шинэчилсэн найруулгын хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөх зохицуулалтыг тусгаж боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн? Алга. Үг хэлэхгүй, асуулт л асууна. Байхгүй.

Байнгын хороо Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Хөөе Бейсен гишүүн хаачих нь вэ? Санал хураалт.

60.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төлөвлөснөөсөө арай урт явж байна. Түрүүн хойшлуулчихсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиа явуулах уу?

Саяын хуулийн төслийг Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Одоо Үнэт цаасны тухай Зах зээлийн тухай хуулийг хэлэлцэнэ.

14.38 цаг

**Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Эдийн засгийн хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Ч.Хүрэлбаатар:** Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын зүгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдах бусад хуулийн төслийн хамт Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулан өнөөдөр та бүхэнд танилцуулж байна.

Үнэт цаасны тухай анхны хууль нь иргэдэд өмчийн хуваарилалтыг оновчтой хийх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 1994 онд батлагдаж үүнээс хойш компаниуд хувьцаагаа олон нийтэд санал болгох үйл ажиллагаагаа амжилттай хийгдэж, зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүд үүсэж эхэлсэнтэй холбоотойгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд 2002 онд, үүний дараа дэлхийн санхүүгийн хямралтай холбоотойгоор үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас гаргасан зарчим, зөвлөмжид тулгуурлан 2013 онд тус тус шинэчилсэн найруулгаар батлагдан мөрдөгдөж байна.

Энэхүү хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлт нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд туссаны дагуу Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид хамтран боловсруулж хуулийн төсөлд хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдүүлэх, мэргэжлийн урт хугацаат хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааг дэмжих, мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх, хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалыг

сайжруулах чиглэлээр гол өөрчлөлтүүдийг оруулан боловсрууллаа.

Хуулийн төслийг боловсруулах явцад ажлын хэсгийн хэлэлцүүлгээр 3 удаа, олон нийтийн хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулж, хуулийн төсөлд ирсэн нийт 300 гаруй саналын 90 орчим хувийг хүлээн авч, хуулийн төсөлд тусгаснаар одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 30 хувьд өөрчлөлт орж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор олон улсын хөрөнгийн зах зээл дээрх шинэ бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдэх, урт хугацаат хөрөнгө оруулалт нэмэгдэх улмаар хувийн хэвшлийн компаниуд хөрөнгийн зах зээлээр дамжуулан урт хугацаат санхүүжилт татах үйл явц хялбаршиж дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхол, санхүүгийн зах зээл дээрх мөнгөн урсгал нэмэгдсэнээр татварын орлого нэмэгдэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих зэрэг ач холбогдолтой юм.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

**М.Оюунчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь хөрөнгийн зах зээл, технологийн дэвшилд суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, түүний эрх зүйн орчныг бий болгох, мэргэжлийн урт хугацаат хөрөнгө оруулагчдыг татах, тэдгээрийн тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, олон улсын жишигийн дагуу үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа болон нэмэх үнэт цаас гаргаж ажиллагааг зохион байгуулах, хөрөнгийн зах зээлд үнэт цаасны арилжааны дараа төлбөрт горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэх, үүнтэй холбоотойгоор төлбөрийн чадваргүйдлийн эрсдэлийг удирдах, зах зээл дээр шинээр бий болох клирингийн гишүүн, төлбөрийн баталгааны сан, төлбөр тооцоог эцэслэх, үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн номинал данстай холбогдох зохицуулалтуудыг нэмж тусгах, хөрөнгийн зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагуудын төрлийг ялган тэдгээрийн эрх, үүргийн хүрээг тодорхойлох, хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдал, засаглалыг сайжруулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хууль хоорондын уялдааг хангах, зарим давхардал, зөрчил, хийдлийг арилгах зорилготой хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийн *D-parliamnt.mn* цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Монголын хөрөнгийн бирж дээрх хөрвөх чадварын индексийн үзүүлэлт сул байгаа талаар, үүсмэл санхүүгийн хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээл дээр арилжаалах талаар, хөрөнгийн зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулагчдын урт хугацаанд татах зохицуулалтыг тусгасан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс эдгээр хуулийн төслүүдтэй холбогдуулан санал гараагүй болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татвараас хөнгөлөх тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны

санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Шатарбалын Раднаасэдийн урилгаар Говь-Алтай аймгийн Шарга сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт багш нарынхаа соён гэгээрүүлэх, эрдэм боловсролын ажилд их өндөр амжилтыг хүсэн ерөөе гишүүдийн өмнөөс.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд? Хүрэлбаатар, Хавдисламын Баделхан гишүүнээр тасаллаа. Тасалчихсан шүү, нэмэхгүй шүү. Ажлын хэсгийг танилцуулъя.

Дэмбэрэлдашийн Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Түдэвийн Цэрэнбадрал Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга, Түндэвийн Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга, Баттулгын Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, Бархасын Долгорсүрэн Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын зохицуулалтын газрын дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн дарга, Нүрсэдийн Ундраа Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн зөвлөх, Намжилын Энхбаатар Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах мэргэжилтэн, ахлах референт, Алтанбулагийн Нинжин Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах референт,

Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

**Б.Баттөмөр:** Би өчигдөр энэ Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр нэлээн асуулт асуучихсан. Тэгэхдээ маш том хууль, эдийн засагт их үр нөлөөтэй хууль учраас асуултууд маш их байна.

Тэгэхээр зэрэг товчхон товчхон хариулаарай. Би нэлээн олон асуулт асууна. Энэ хууль маань анх 1994 онд батлагдаад, одоо мөрдөх гэж байгаа хууль 2013 оноос эхлээд мөрдөгдөж явж байгаа юм. Тэгэхээр бол 7 удаа өөрчлөлт орсон гэж байгаа. Дорвитой их томоохон өөрчлөлт бол ороогүй.

Ер нь бол 13 оноос хойш 10-аад жилийн хугацаанд байтугай ер нь 10 хоногийн хугацаанд бараг маш богино хугацаанд энэ хөрөнгийн зах зээл, үнэт цаасны зах зээл бол өөрчлөгдөж байна л даа. Тийм учраас энэ дээр бид их онцгой анхаарах ёстой гэж. Энэ “Алсын хараа-2050” гэдэг хөтөлбөрийг боловсруулахдаа би бас оролцсон хүний хувьд бол бид олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ гэж ингэж бид нар оруулж байсан юм. Энэ хүрээнд бол бас нэлээн юмнууд хийгдэж байгаа байх гэж ингэж үзэж байна. Ер нь зохицуулалттай, зохицуулалтгүй, муутай энэ биржийн бус арилжаа гээд байж байна шүү дээ тээ, харилцааг зохицуулах шаардлагуудыг та нар ер нь юу гэж харж энэ дээр яаж асуудал оруулж, нэг дэх асуудал байна.

Энэ 2019 онд Хууль зүйн яамнаас хийсэн судалгаагаар энэ бусад хууль энэ тэртэй давхацсан тийм хийдэгдэл 134 байна гэж гарсан 2019 онд шүү дээ. Тэгээд тэрнээс хойш судалгаа хийгдсэн үү? Энэ хийдлүүдийг яаж шийдэж байх вэ гэсэн хоёр дахь асуулт байгаа.

Гурав дахь асуулт бол юу гэхээр энэ үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос мөн 2019 онд хийсэн судалгаагаар энэ Хөрөнгийн биржийн шимтгэл их өндөр байна. Бараг 100-аад

хувь өндөр байна гэж, илүү байна гэж. Тэгэхээр энэ Хөрөнгийн биржийн энэ шимтгэл дээр та нар ямар бодлого барьж орж ирж байна? Бирж дээр мөн 19 оны энэ яагаад 19 он гэхээр энэ хууль 19 онд өргөн баригдсан юм уу хаашаа юм, 4 жил болчихсон юм уу хаашаа юм. Энэ судалгаанууд нь дандаа 19 он гэсэн юм явж байгаа байхгүй юу. 19 оноос чинь хойш 4-5 жил болчихлоо шүү дээ. Тэгэхээр энэ хөрөнгийн бирж дээр 196 компани байна. Үүний 30 хувь нь шаардлага хангаж байгаа. 70 хувь нь бол шаардлага хангахгүй байгаа гэсэн ийм бас юм байгаа. Энэ маань шаардлага хангалтын тоо, энэ хэмжээ яаж байгаа вэ гэж? Энэ глобал дотоод, гадаадын энэ “Кастадион” банк гээд байж байгаа шүү дээ тийм ээ? Энэ банканд тавигдах шаардлагууд ер нь яаж шинэчлэгдэж байна гэсэн ийм асуулт байна. Одоо 5 дахь болчихов уу яав тийм ээ?

Биржийн бус арилжаагаар 1.7 их наяд төгрөг гүйлгээ хийгдсэн байж байгаа шүү дээ тиймээ. Тэгэхээр энэ биржийн болон биржийн бус арилжааг ялгааг тогтоох чиглэлээр та нар юу хийж, энэ хуульд яаж орж ирж байна гэсэн. Энэ санхүүгийн зах зээлийн харьцаа байгаа 60, 30, 10 гээд манай хөрөнгийн зах зээл их сайн хөгжиж байгаа, Баярсайхан даргатай Санхүүгийн зохицуулах хороо сайн ажиллаж байгаа. 22 хувь дотоодын нийт бүтээгдэхүүний 22 хувь болж ирж байгаа. Тэгэхээр зэрэг энэ даатгал маань юу болж байна? Даатгалын шинэчлэлийг хэзээ хийх вэ? Тэр 10 гэсэн тоондоо даатгалын дотоодын нийт бүтээгдэхүүнд хамрах хэмжээ даатгал хэд байна? Даатгалын эрх зүйн орчныг яаж яах вэ? Энэ хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө татах чиглэлээр та нар юу хийж байна?

Хамгийн сүүлчийн асуулт. Энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн асуудлыг эрх ашгийг яаж хамгаалах юм, ямар зохицуулалтууд хийгдэж байна? Ийм асуултуудад хариулт авъя.

**Г.Занданшатар:** 80,  
Дэмбэрэлдашийн Баярсайхан.

**Д.Баярсайхан:** Баттөмөр гишүүний асуултад товчхон хариулаад явъя. Монгол Улсын бодлогын баримт бичгүүд, “Алсын хараа-2050” дунд хугацааны стратеги гээд бүхий л бодлогын баримт бичгүүдэд ухаалаг санхүүгийн зах зээлийг хөгжүүлж гэдэг байдлаар туссан. Ерөнхий агуулга нь олон тулгуурт санхүүгийн салбарыг хөгжүүлэх тэр дотроо энэ банкнаас бусад санхүүгийн салбарыг дэмжих чиглэлээр маш олон бодлогын шийдвэрүүд гарсан байгаа. Энэ хүрээндээ анх удаагаа зээлийн хүүг бууруулах стратеги дотор зардлыг бууруулах замаар өрсөлдөөнийг бий болгож, хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх гээд ийм заалт заасан. Энэ хүрээндээ ч гэсэн бас энэ Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.

Дээрээс нь 2022, 2023 оны төсвийн тухай хуулиудад дагаж мөрдөхөөр бас энэ татварын хөнгөлөлтүүд суусан байгаа. Энэ хүрээндээ маш богино хугацаанд хөрөнгийн зах зээл маань багагүй өсөлт үзүүлсэн. Сүүлийн 5 жилийн хугацаанд гэж ярих юм бол 337.8 хувь өссөн байгаа. 2020 оны эцэстэй харьцуулах юм бол 3.7 хувийн өсөлт үзүүлээд өнөөдөр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ маань 11.6 их наяд төгрөгт хүрсэн нь одоо түүхэн дэд үзүүлэлт болсон. Ингэхдээ мэдээж мэдээж Улсын Их Хурлаас гаргаж байгаа бодлогын шийдвэрүүд, дээрээс нь Санхүүгийн зохицуулах хорооноос гарч байгаа шийдвэрүүд, дэд бүтэц, манай салбарынхны хамтын үйл ажиллагаа байсан гэдгийг хэлэх нь зөв байгаа.

Энэ дотроо онцолж нэг хэлэх гэж байгаа зүйл бол сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд ерөөсөө хөрөнгийн зах зээл маань Монголын хөрөнгийн биржээс л санхүүжилт татдаг байсан бол

биржийн бус зах зээлийн зах зээлийн зохицуулалтын журмыг 2021 оны 9 сараас хэрэгжүүлж эхэлсэн. Тийм, энэ хүрээндээ одоо бас багагүй санхүүжилтийг татаад их өндөр өсөлт үзүүлсэн гэж хэлж болно. Том дүнгээрээ харах юм бол 2.4 их наяд төгрөгийн өрийн хэрэгсэл бүртгэгдсэн байгаа. Олон нийтээс энэ 1.74 их наяд төгрөгийн энэ санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Ер нь хөрөнгийн зах зээлийн хамгийн суурийн суурь гэдэг өрийн хэрэгсэл, бондын зах зээлийг хөгжүүлнэ гэж бид ийм бодлогын зорилт тавьсан. Энэ хүрээндээ ч гэсэн бүртгэлийн журмыг анх удаагаа олон улсын стандартад нийцүүлээд хувьцааны бүртгэл, өрийн хэрэгслийн бүртгэл гээд 2 ангилсан байгаа. Энэ хүрээндээ ч гэсэн маш их ашиг, дэвшил гарсан. Дээрээс нь анх удаагаа бид энэ олон улсын төлбөр тооцооны горимтой нийцүүлсэн ди ви ти, ти плас 2, 3 гэдэг ийм олон улсын зарчмууд байдаг. Бид одоо EBRD, IFC олон улсын байгууллагуудаас нэлээдгүй олон судал.../минут дуусав./

**Г.Занданшатар:** 80 гүйцээд хариулчихъя. Хуулийн төсөл хэлэхээр салбарын бүх асуулт л асууж харилцаад байгаа юм.

**Д.Баярсайхан:** Тэгээд энэ хүрээндээ Ди ви ти ти плас 2 гээд горимд шилжсэн. Энэ хүрээнд ч гэсэн Фүтси Раслас Монгол Улсыг энэ олон улсын ажиглагчийн жагсаалтад оруулсан байсан бол дахиад биднүүсийг бүүр хөгжингүй орнуудын, хөгжиж буй орнуудын жагсаалтад орсон. Энэ хүрээндээ олон улсын хөрөнгө оруулагчид Монголын хөрөнгийн бирж дээр оролцох энэ үүд хаалгыг нээсэн байгаа гэдгийг бас хэлэх нь зөв байх.

Дээрээс нь энэ Даатгалын тухай хууль ялт ч үгүй манай хөрөнгийн зах зээл дээр дунд урт хугацааны хөрөнгө оруулагчид зайлигүй шаардлагатай

байгаа. Энэ хүрээнд одоо холбогдох газруудтай хамтраад даатгалын багц хуулийн төслийг, ер нь төслөө гаргачихсан. Засгийн газраас өргөн барихаар ажиллаж байгаа. Ингээд явах юм бол магадгүй хамгийн чухал нь даатгалын сангууд, даатгалын нөөц сангууд бол энэ урт хугацааны хөрөнгө оруулагчид байдаг. Энэ хүрээндээ оролцох байх.

Хэдийгээр хууль батлагдаагүй байгаа ч гэсэн энэ даатгалын компаниудад тавигдах зохистой харьцааны шалгуур өөрчлөлтүүд, хөнгөлөлт өөрчлөлт Хорооны зүгээс оруулсан энэ хүрээндээ 183 тэрбум төгрөг хөрөнгийн зах зээл дээр даатгалын сангуудаас оролцох үүд хаалгыг нээсэн гэдгийг бас хэлэх нь зөв байх. Дээрээс нь хамгийн чухал бас нэг асуудлыг хөндсөн нь бол энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тухай асуудал байгаа. Энэ хүрээндээ ч гэсэн биднүүс одоо аккоммулитив санал хураах ийм журмыг баталсан.

Өөрөөр хэлбэл, жижиг хувьцаа эзэмшигчид нэгдээд ТУЗ-даа компанийн ТУЗ-даа төлөөлөн оролцох, оролцуулах тэр хүрээндээ мэдээлэл авах, олон нийтэд мэдээ тайланг хүргэх ийм эрх нь нээгдсэн байгаа. Бас кэйс хэлэхэд одоо энэ компанийн засаглал маш чухал байдаг. Энэ хүрээндээ OECD-гийн энэ зарчмыг дахин шинэчлээд биднүүс компанийн засаглалууд хийх үнэлгээг хийсэн байгаа гэдгийг хэлье.

Дээрээс нь энэ аж ахуйн нэгжүүдийг олон нийтийн компани болох үйл явцад татан төвлөрүүлэх талаар нэлээдгүй санаачилга гаргаад ажиллаж байгаа. Энэ Мянганы хөгжлийн сорилтын хүрээнд ялангуяа энэ жендерийн мэдрэмжтэй ногоон ийм байгаль орчин, засаглал И Эс Жи гээд энэ стандартуудтай нийцсэн ийм төсөл хөтөлбөр орж ирэх юм бол Санхүүгийн зохицуулах хорооны ажлын 10 хоногт

шийдэхээр ийм зохицуулалт хийсэн байгаа. Дээрээс нь үндэсний том аж ахуйн нэгжүүдийг олон нийтийн компани болгох хүрээнд Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимтай санамж бичиг байгуулсан. Топ 100 аж ахуйн нэгжид барьцаа, баталгаагаа шаардахгүйгээр өрийн хэрэгсэл бонд гаргахыг зөвшөөрч байгаа.

Дээрээс нь маш хөнгөвчилсөн нөхцөлөөр бүртгэх ийм хэлбэрийн үйл ажиллагаа хийгдсэн. Энэ хүрээндээ ч гэсэн анх удаагаа Монгол Улс олон улсын зах зээл дээрээс 60 сая ам.доллартой тэнцэх ногоон бонд гаргасан. Дотооддоо бас бонд гаргаад явж байна. Дээрээс нь энэ бондуудыг гаргахад үндэсний мөнгөн тэмдэгтээс гадна бас гадаад валютаар гаргах энэ зохицуулалтыг хийгээд явж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх. Тэгээд юу билээ? Шимтгэл хураамжийн хувьд нэлээдгүй ажиллагааг биднүүс хийж байгаа. Хэрвээ мэдээж салбар маань харьцангуй олон оролцогчтой, тоглогчидтой.

Дээрээс нь 2020 онтой харьцуулахад нийт 70 гаруй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ Монголын хөрөнгийн бирж дээр гарсан байгаа. Анхны төслийн бус хөрөнгөөр баталгаажсан үнэт цааснууд гарлаа. Хаалттай, нээлттэй хөрөнгө оруулалтын сангууд нээлттэй арилжаалдаг болсон. Доллар, төгрөгийн хосолмол бонд гарсан гээд нэрлээд явах юм бол 70 гаруй шинэ бүтээгдэхүүн гарсан байгаа. Биржийн хувьд шимтгэлийг 0.4 байсныг 0.3 хувь болгоод буулгачихсан.

Дахиад дараагийн хорооны хурлаар дахиад бууруулах ийм чиглэлийг өгсөн байгаа. Монголын хөрөнгийн биржээс санал нь ирэх байх гэж бодож байна. Дээрээс нь манай дэд бүтцийн байгууллагууд бас тодорхой шимтгэл хураамж авдаг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн шимтгэлийг 0.24 авдаг байсанг 50 хувь бууруулаад 0.12

хувийн ийм шимтгэл авч байгаа. Мэдээж салбарын оролцогчид, дээрээс нь энэ арилжааны давтамж, цар хүрээ нэмэгдэж байхтай холбоотойгоор бол цаашидаа хүү, шимтгэлийг буулгаад явуулъя гэдэг ийм бодлогын ийм чиглэлтэй ажиллаж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

**Г.Занданшатар:** Баттөмөр гишүүн. Энэ хуулийн төсөлтэйгөө л холбогдуулж яримаар байгаа юм.

**Б.Баттөмөр:** Энэ миний сая асууж байгаа асуулт дандаа хуулийн төсөлтэй холбогдож байгаа шүү. Танай энэ хуулийн тэр зорилтуудтай, шаардлагуудтай нийцсэн асуултууд асууж байгаа гэж ойлгож байгаа. Ингээд хөрөнгийн зах зээл тэлж байна, сайн байна. Гэхдээ үр ашиг гэж юм байна тийм ээ? Аливаа юм үр ашгаар хэмжигддэг юм шүү дээ. Энэ 22 болсон. Урьд нь энэ чинь арван нэг, хоёр энэ тэр байж байгаад 22 боллоо. Энэ үр ашиг гэдэг юм юу гэхлээр татварт ямар хэмжээгээр татварын энэ орлого нэмэгдэж байгаа вэ? Энэ компаниудын энэ гаргасан үр маржин тийм ээ, үйл ажиллагааны үр ашгийн маржин ямар байна нэг дэх асуулт. Үүнийг тодруулъя.

Хоёр дахь нь тэр даатгалын хэмжээхэд байна? Яаж нэмэгдүүлэх вэ, ямар бодлого юм байна? Яах вэ даатгал энэ орж ирээгүй яах вэ Санхүүгийн зохицуулах хорооны бас гол юу учир. Энэ асуулт хариултгүй байж болно. Тэр Маржинг.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Өөр сэдэв. 80 Дэмбэрэлдашийн Баярсайхан асуултад хариул.

**Д.Баярсайхан:** Энэ үр өгөөжийн талаар асуух их зөв асуудал байна. Даатгал, ялангуяа энэ олон нийтийн компани болсноор ямар үр ашигтай болов гээд асууж байна. Юу гэдэг юм бэ, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор юу гэдэг юм 4,



5 эзэнтэй байсан банк бол одоо 72 мянган анхдагч зах зээлийн арилжаан дээр хувьцаа эзэмшигчтэй болсон.

Дээрээс нь нийгмийн ач холбогдлоор нь биднүүс судалгаа хийгээд үзсэн юм. IPO хийсэн, өнгөрсөн онд гэхэд 7 компани IPO хийсэн байгаа. Энэ өнгөрсөн оны компаниудаас өмнөх оны компаниуд дээр биднүүс судалгаа хийгээд үзэхэд хийсний дараагийн жил татвар төлж байгаа. Татвар төлөлт нь 4 дахин нэмэгдсэн 4-6 дахин, бүүр дээшээ ч нэмэгдсэн гэсэн ийм статистик судалгаа хийсэн байгаа. Энэ өнгөрсөн банкнуудтай ялангуяа хийсэн энэ судалгааны дүнг нь нийлүүлээд хэлэх юм бол биднүүс өшөө нарийвчилсан судалгаа хийгээд илүү их үр дүн гарах байх. Ялангуяа энэ банкнууд ашиг их өндөр ашигтай ажилласан учраас энэ ондоо тайлан нэгтгэгдээд гарсны дараа бас танд үүнийг хүргүүлье гэж бодож байна.

Даатгалын багц хуульд юу гэж том өөрчлөлт орсон бэ гээд асууж байна. Бид харж байгаа. Даатгал дотоодын нийт бүтээгдэхүүнд 1.2 хувь орчимтой байгаа. Зайлишгүй цаашидаа өсөх орон зай, шаардлагатай байгаа. Энэ хүрээндээ Хорооноос ямар бодлогын шийдвэр гаргасан бэ гэхээр заавал даатгалын нэр төрлийг олируулъя. Ер нь энэ салбарын хуулиудаа 26 хуульд заавал даатгалд хамруулах ёстой гээд хуульдаа заачихсан байдаг. Гэхдээ хэрэгждэггүй.

**Г.Занданшатар:** Чимэдийн Хүрэлбаатар гишүүн асуулт асууна.

**Ч.Хүрэлбаатар:** Би нэг л асуулт асууя гэсэн юм. Энэ 2023 он хөрөнгийн зах зээл дээр их том өөрчлөлтүүд гарсан гэж би үзэж байгаа. Хөрөнгийн зах зээл дээр ажилладаг олон байгууллагуудын хувьд орлого, ашиг нь нэмэгдсэн ийм жил болж өнгөрсөн гэж би дотроо үнэлж дүгнэж байгаа. Удахгүй энэ байгууллага бас энэ Монгол Улсын хөрөнгийн зах зээл яаж хөгжсөнийг бас харуулах байх гэж бодож байгаа. Зүгээр нэг энгийн жишээ

аваад л үзэхэд энэ Хөрөнгийн бирж дээр нүүрсийг арилжаалдаг, худалдаалдаг болсноос хойш Хөрөнгийн бирж ашигтай ажилладаг болсон шүү дээ түүхэндээ анх удаагаа.

Тэгэхээр сая Баярсайхан дарга хэлж байна. Нийтдээ 70-аад бүтээгдэхүүнийг шинээр гаргаж, хөрөнгийн зах зээл дээр хэрэглэж ашиглаж байна гэдэг ийм зүйлийг хэлж байна. Тэгэхээр мэдээж хөрөнгийн зах зээл нь хөгжиж байгаа учраас холбогдох хуулиудыг улам боловсронгуй болгох, нарийвчлах, тодорхой болгох ийм шаардлага бий болж энэ хуулийг, төслүүдийг оруулж ирлээ гэж би харж байгаа. Тийм учраас би өнөөдөр хэлэлцээд, Улсын Их Хурал дээр хэлэлцээд явах нь зөв гэж үзэж байгаа. Асуух гэж байгаа асуулт маань нэг л асуулт байгаа.

Дэлхий нийтээрээ энэ инфляцтай тэмцээд бодлогын хүү нэлээд өндөр тогтчихсон учраас зээл их өндөр хүүтэй байгаа. Тэгэхээр улс орнууд гадаадын хөрөнгө оруулалтын төлөө явж байна, зүтгэж байна. Эсвэл хямдхан эх үүсвэрийн төлөө зүтгэж байгаа. Тэгэхээр аж ахуйн нэгжүүдийн хувьд хямдхан эх үүсвэр яаж олж авах вэ гэдэг л ийм зовлон болж байгаа юм. Тэгэхээр арилжааны банкнуудаар явна манай цөөхөн хэдэн арилжааны банкт гаднаас банк оруулъя гэхээр нь бүгдээрээ улайраад эсэргүүцчихдэг ийм байгаа үед хөрөнгийн зах зээлийн үнэхээр гүйцэтгэх үүрэг их чухал байна.

Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгжүүд хөрөнгийн биржийн хөрөнгийн зах зээл дээрээс санхүүгийн эх үүсвэрүүдийг татах ямар бололцоонууд улам нэмэгдэж өгөх вэ? Банк тэрүүн дээр нь гадаадын хөрөнгө оруулалттай банкнууд орж ирэх дээр хэлэлцэгдээд л явж л байна л даа. Эсэргүүцэх нь нэг нь эсэргүүцээд л, улайраад л, чичрээд л, айгаад л явж л байна. Гэхдээ яваандаа энэ болно гэж үзэж байгаа. Харин банкнаас бус хөрөнгийн зах зээлээр

дамжуулж санхүүгийн эх үүсвэр татах чиглэл дээр ямар өөрчлөлтүүд энд орж ирж байгаа юм?

Дээр нь та бүгдэд байгаа мэдээллээр манай үндэсний аж ахуйн нэгжүүд энэ хөрөнгийн зах зээлээр дамжуулж гаднаас хэчнээн хэмжээний хөрөнгийн эх үүсвэр татав, дотоодоосоо хэчнээн төгрөгийн эх үүсвэр татав гэдэг дээр та бүгд хариулт өгөөч. Энэ дээрээс үндсэндээ хөрөнгийн зах зээлийн хөгжил дэвшил дээр нь харагдах байх гэж би бодож байна. Баярсайхан даргыг хариулахыг хүсье.

Мэдээж энэ 1 минут дутуу байна. Би энэ дээр нийтдээ энэ Санхүүгийн зохицуулах хороон дээр бас талархал илэрхийлье. Нүүрсийг биржээр зарахад Санхүүгийн зохицуулах хорооны үүрэг, роль асар их байсан шүү. Биржээр хэдийгээр арилжаа явагдаж байгаа хэдий ч цаана нь Санхүүгийн зохицуулах хорооноос бараг 20-оод журам дагаж баталж байж хийгдсэн богинохон хугацаанд шуурхай бас ийм амаргүй үед бол их шуурхай ажилласанд та бүгд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье. 80 доллароор зардаг байсан нүүрс чинь одоо 180 доллароор зардаг болсон шүү. Монгол Улсын валютын нөөц чинь нэмэгдчихсэн, төгрөгийн хани тогтворжоод 3560 хүрч байсан нь өнөөдөр 3410 болоод бууж байгаа. Тэгэхээр та бүгдийн тэр хэдэн журмууд асар их чухал үүрэг гүйцэтгэсэн шүү гэдгийг хэлээд бас баярлалаа гэдгийг энэ далимдуулаад хэлчихье. Яагаад гэвэл дандаа цаастай ноцолддог хүмүүст баярлалаа гэж хэлдэг хүн цөөхөн байдаг болов уу гэж бодож байна. Асуултад хариултаа авъя.

**Г.Занданшатар:** 80  
Дэмбэрэлдашийн Баярсайхан. Санхүүгийн зохицуулах хороон дарга хариулна.

**Д.Баярсайхан:** Гишүүний асуултад хариулъя. Гадаадын шууд хөрөнгө оруулалт Монгол Улсын зах

зээлд хамгийн чухал амин ийм шаардлагатай байгаа. Энэ хүрээндээ ч гэсэн юу гэдэг юм байгаа юм статистик харах юм бол дотоодын арилжаанд оролцож байсан гадаадын хувь хүн иргэд 2012 гэдэг юм эдийн засгийн хамгийн өндөр өсөлттэй. 11, 12 онд бол арилжааны 70 орчим хувьд нь байсан юм байна лээ. Одоо бол 5 хүрэхгүй хувь байгаад байгаа. Хорооны зүгээс энэ ялангуяа энэ Монголын хөрөнгийн зах зээл дээр гаднын энэ хөрөнгө оруулагчдыг татах талаар нэл хэдгүй ажлуудыг хийлээ. Өнгөрсөн онд Шанхайн хөрөнгийн биржтэй Монголын хөрөнгийн бирж хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

Дээрээс нь Санхүүгийн зохицуулах хороо, Австралийн болон Хонконгийн зохицуулагч байгууллагуудтай уулзалтуудыг зохих түвшний бүхий л уулзалтуудыг хийлээ. Энэ хүрээндээ дараагийн шатын буюу энэ өөрөө өөрийгөө зохицуулах байгууламж бирж хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар урьдчилсан тохиролцоог хийлээ. Ингэснээр юу гэдэг юм байгаа өндөр өсөлттэй байгаа Ази, манай бүс нутгийн ийм олон улсын биржүүдтэй Монголын хөрөнгийн биржийг холбох ажлууд амжилттай хийгдээд явж байна гэж ойлгож болно. Ирэх жилүүдэд биднүүс Сингапурын хөрөнгийн бирж, энэ жил Торонтогийн хөрөнгийн биржтэй бас уулзахаар зохицуулагчтай саналаа солилцоод явж байна. Хамгийн чухал нь эхлээд энэ бирж хооронд гэхээсээ илүү зохицуулагч ...-тод бас саналаа нэгтгэж, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах шаардлагатай байдаг юм билээ. Энэ үйл явц амжилттай хэрэгжээд явж байгаа.

Ингээд хэрэгжээд явах юм бол магадгүй давхар бүртгэлийн асуудлууд манай дээр бүртгэгдсэн компаниуд гаднын бирж дээр бүртгэх, гаднын бирж дээр бүртгэж байгаа компаниуд дотоодын бирж дээр бүртгэх тэгээд зөвхөн Монголын аж ахуйн нэгжүүдээс

гадна Монголд хэрэгжих төслүүдэд хөрөнгө оруулах ийм орон зай байгаа гэдгийг ерөнхийдөө нэлээдгүй сайн ойлголцсон байгаа. Тэгэхээр энэ онд одоо манайхаас дотоодын аж ахуйн нэгжүүд ялангуяа хамгийн эхний ээлжид энэ Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орохтой холбоотой энэ банкны салбарт гадаадын хөрөнгө оруулагчдыг татъя.

Дээрээс нь бэлэн төсөл, хөтөлбөр гээд ярих юм бол уул уурхайн төслүүд дээрээ бас санхүүжилт татах нь зөв юм гэдгийг бүх юм түвшинд ярилцаад тохиролцоод явж байгаа гэдэг нь хэлэх нь зөв байх. Дээрээс нь бас нэг зүйлийг онцлоод хэлэхэд энэ ялангуяа энэ дотоодын аж ахуйн нэгжүүдээсээ энэ IPO-ээс гадна бондын зах зээлд нэлээн санхүүжилт татдаг болсон. Түрүүн бас Баттөмөр гишүүний асуултад хэлэхэд товчхон хэлэхэд Монголын хөрөнгийн зах зээл бол хос дугуйтай болсон шүү. Биржгийн бус зах зээлийн орчин маш амжилттай хэрэгжээд явж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

**Г.Занданшатар:** 80 Баярсайхан дарга товч тодорхой гүйцээж хариулъя.

**Д.Баярсайхан:** Энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулж арилжаалах энэ хуулийн хэрэгжилтийг хангуулаад явж байгаа. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 13 журмыг батлаад хэрэгжүүлээд мөрдлөг болоод явж байна. Арилжааны хувьд 2 валютаар арилжаа хийгдээд байгаа. Доллар болон Юанийн арилжаа хийгдсэн. Нэг нь 6 хувь, нөгөөх нь 10 хувийн өсөлттэй гарсан байгаа.

Нүүрсний арилжаа бол дунджаар 9.5 хувийн өсөлттэй дуудсанаасаа яриад байгаа юм. Төмрийн хүдрийн баяжмал дунджаар 8.75 хувийн өсөлттэй арилжаалагдаж байгаа. Дээрээс нь саяхан Монгол Улсын Засгийн газраас энэ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг бас тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүнийг биржээр арилжуулъя гээд тогтоол

гарсан юм байна лээ. Үүнтэй холбоотой бас холбогдох газрууддаа санал холбогдоод холбогдоод явж байгаа гэдгийг бас хэлчихье гэж бодсон юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баделхан гишүүний дараа санал хураалт явуулна. Нэг асуултын дараа санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд цуглая. Хавдисламын Баделхан гишүүн асуулт асууна.

**Х.Баделхан:** Баярлалаа. Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл сайн хөгжиж байгаа. Үүний үр шимийг нь бид нар үзэж байгаа. Тухайлбал наад зах нь бид нар нүүрсээ биржээр арилжаад нүүрсний үнэ нь нэмэгдээд өнөөдөр төсөв давж биелэгдээд сайхан эерэг үзүүлэлттэй болсон. Компаниуд бол дотооддоо бол хувьцаа гаргаад, мөнгө босгож байна. Энэ бол маш сайн хэрэг. Ер нь гадаад зах зээлээ бас сайн хөгжүүлж байгаа юм байна. Энэ бол дэвшилтэй тал. Би хоёр зүйл асуух гэсэн юм.

Нэг дэх нь бол бид нар 90 он гараад анх удаа хувьцаа, үнэт цаас гаргаж нөгөө ягаан цэнхэр тасалбараар бид нар өмч хувьчилсан шүү дээ. Тэр бол анхны үнэт цаас гэж би бодож байгаа. Тэгэхлээр тэр цэнхэр тасалбараар бол нөгөө бүх улсын өмчийг хувьцаат компани болгож, хувьцаагаар арилжиж Хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэн. Гэхдээ энэ үйл ажиллагаа нь сайн явагдсан уу муу явагдсан уу тэрийг би сайн мэдэхгүй л дээ. Гэхдээ олон хувьцаат компани дампуурсан. Цаана нь олон хувьцаа эзэмшигч нар бол ямар ч үрлэнгүйгээр тэр хувьцааны үр шим үзэж чадаагүй ингээд өнгөрсөн. Зарим хөдөө иргэдтэй уулзалт хийж байхад тэр цэнхэр тасалбараа одоо хүртэл эзэнтэй болгож чадаагүй, тэр нь хаана байгааг мэдэхгүй тийм иргэд байдаг юм байна. Ер нь үүн дээр бас иргэж дүгнэлт гаргасан тийм юм байгаа юу ер нь? Түүн дээр бид нар ер нь маш их алдсан гэж би

тэр үед амьдарч байсан хүний хувьд тэгж боддог юм.

Хоёр дахь нь бол бид нар Монгол банкнуудыг бол арилжааны банкнуудын хувьцаат нээлттэй хувьцаат компани болгоно гэж 3 жилийн өмнө Их Хурал шийдвэр гаргаж байсан. Сая эргээд энэ дахиад хуулийн төсөл оруулаад энэ хугацааг нь сунгая бас сайн хэрэгжсэнгүй гэсэн асуудал ярьж байна. 1 хүн 20 хувиас илүү хувьцаа эзэмшихгүй гэж. Ер нь энэ шийдвэр яагаад хэрэгжихгүй байна? Одоо 3 жилээр сунгана гэсэн хуулийн төсөл явж байгаа юм байна. 3 жилээр сунгаад сунгаад энэ төсөл хэрэгжих үү ер нь? Энэ банкнуудын дотроо хувьцаагаа арилжаалах талаар хамгийн сайн ажилласан ямар банкнууд байна сайн ажиллаж байгаа? Ер нь идэвхгүй байгаа ямар банкнууд байна? Ер нь цаашидаа энэ Их Хурлын шийдвэр ер нь хэрэгжих боломжтой юу гэсэн ийм хоёр асуулт байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** 80,  
Дэмбэрэлдашийн Баярсайхан дарга  
хариулъя.

**Д.Баярсайхан:** Их зөв асуулт байна. Ер нь яах вэ өмч хувьчлал хийгдсэнээс хойш нэлээд олон иргэн цэнхэр, ягаан тасалбараар аж ахуйн нэгжүүдийг хувьцааг нь авсан. Тэгээд хүртэл бас үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр тодорхой хэмжээний иргэдийн хувьцаа байдаг. Хорооноос Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй хамтраад энэ мэдээллийг тодорхой давтамжаар хүргүүлдэг. Иргэдийн маань бас юу гэдэг юм нас барсан байж болно, тодорхой мэдээлэлгүй байж болно. Энэ учраас Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хандаад өргөдлөө гаргаад энэ хувьцаа үнэхээр яг өөрт чинь байна уу, өвлөгдөх боломжтой байна уу гэдгээ лавлаад явах ийм бүрэн боломжтой байгаа. Энэ дээр байнгын давтан мэдээлэлтэй яваад байгаа.

Нөгөө талаас асуултыг би тэгж харж байна. Мааш олон тооны хувьцаат компаниуд байгаад байдаг. Гэхдээ бүгд үр ашигтай ажилладаггүй. Яг компанийн засаглал нь хэр сайн байна гээд. Энэ тал дээр Хорооноос 2 бүртгэл байгаад байгаа юм. Хувьцаат компани Санхүүгийн зохицуулах хороон дээр нэг бүртгэл байна. Яг Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаат компаниудын бүртгэл байгаа. 230 орчим тийм ээ хувьцаат компани байснаас дю листинг гэдэг юм уу ийм амьгүй цаашид хувьцаат компани хэлбэрээр явах боломжгүй этгээдүүдийнхээ тэр хувьцаат компанийн жагсаалтаасаа хас гээд ийм бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа. Өнөөдрийн хувьд 173 хувьцаат компани болоод буучихсан байгаа. Цаашидаа ч гэсэн энэ амьгүй үхмэл компаниудыг өшөө тэр бүртгэлээс хасах үйл ажиллагаа шат дараатай явагдана гэж ойлгож болно.

Нөгөө талаас ялт ч үгүй энэ хувьцаа эзэмшигч гэж тэр дотроо жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах бол ялт ч үгүй Хорооны чухал үүрэг. Энэ тал дээр одоо иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхээс гадна компаниудын хувьд ч гэсэн мэдээ, тайлангаа цаг тогтмол гаргадаг, олон нийтэд хүргэдэг, компанийн засаглалыг нь сайжруулах гээд ийм олон шаардлагын арга хэмжээ аваад явж байгаа гэдгийг хэлье.

Ер нь бас Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төсөл дээр бас холбогдох газруудтай ажиллаж байгаа гэдгийг хэлэх байна. Энэ нь зөвхөн жижиг хувьцаа эзэмшигчид гэхээсээ илүү нийт санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалагдах ийм том хуулийн зохицуулалт болох байх гэж бодож байгаа.

Банкнуудын хувьд одоо яг өнөөдрийн байдлаар 6 банк хувьцаат компанитай болсон. 1 нь системийн

нөлөө бүхий биш банк, 5 нь яг хууль маань 2 шаардлага тавьсан. Системийн нөлөө бүхий банкнуудыг өнгөрсөн онд багтааж олон нийтийн компани болго гээд. Олон нийтэд санал болгосон хувиуд нь өөр өөр. 5 хувиас 20 хувь хүрт.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Товч тодорхой хариулахгүй нуршаад байх юм. Гол юмаа ярь. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Дараа нь санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Дамдины Цогтбаатар гишүүн.

**Д.Цогтбаатар:** Энэ хуулийг дэмжиж байгаа. Энэ бол үнэхээр чухал хууль орж ирж байна. Энд хэд хэдэн их чухал л заалтууд орж ирж байгаа. Энэ мөнгөн хөрөнгийн номинал данстай холбогдох зохицуулалтыг нэмж тусгаж байгаа нь үнэхээр том урагшаа хийж байгаа алхам. Нөгөө талаасаа энэ нөгөө зах зээл дээр өөрийгөө зохицуулах байгууллагуудын эрх мэдлийн хүрээг илүү тодотгож өгч байгаа, ялгаж өгч байгаа нь маш чухал. Энэ дээр бол үнэхээр тэгэхгүй бол энэ байхгүй болохлоор өөрийгөө зохицуулж болох юмнуудад ёстой хажуугаас нь орж ирээд төр нь ч ороод л зохицуулаад яваад байдаг. Энэ төрийн оролцоог ахиад л нэмэгдүүлээд байх энэ эрсдэл байгаа учраас энэ дээр энэ зарим тоглогчдын, зарим хуулийн этгээдүүдийн энэ зах зээлийн үйл ажиллагаанд оролцох, ялангуяа бодлогын түвшинд энэ оролцох боломжийг нь өөрийгөө бие даагаад оролцох боломжийг нь илүү бэхжүүлж өгч байгаа нь үнэхээр маш чухал байна гэж үзэж байна.

Компанийн ил тод байдал, засаглал дээр ялангуяа яг засаглал нь сайн байхыг гарцаагүй өөрсдөө бараг хүсээгүй байхад нэгэнт хувьцаа нь л гарсан бол ил тод засаглал сайн байхыг шаардсан, тэр рүү шахаж түлхсэн энэ зохицуулалт нарийвчилж орж ирж байна

гэдэг бол хөрөнгө оруулалт хийх хамгийн суурь үзүүлэлт байгаа юм. Хүн энэ олон үнэт цаасны бүтээгдэхүүнүүдээс, зах зээл дээрээс авъя гэхэд ялангуяа компаниудын гаргаж байгаа төрөл бүрийн бүтээгдэхүүнүүдээс авъя гэхэд компанийн засаглал тэр нь ил ил тод байх, хариуцлага хүлээх гарцаагүй хүлээх энэ тогтолцоонууд нь бүрдэж өгсөн байж байж сая хөрөнгө оруулалт орно. Сая харин төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг байгуулахыг хорих, марагор тавих тогтоол түр хойшилж байна. Би үүнд жаахан харамсаж байна.

Яагаад гэхлээр яг энэ тогтоол дотор энэ нөгөө гадаад стратегийн ордуудыг гаргачихсан байгаа компаниуд Монголд дю листингээ хийхгүй байгаад байгаа. Хуулийн заалт нь байгаад байгаа. Үүнийг хэрэгжүүлэхийг бас шаардсан ийм заалт энд орсон байсан. Энэ тэгээд гарах юм бол, өөрөөр хэлбэл энэ хөрөнгийн бирж дээр гаднын хөрөнгө оруулалтыг чинь харин нэмж өгөх, үүнд нь хүч нэмж өгөх бодлогын ийм заалт уг нь орж ирэх гээд хүлээгдэж байгаа. Энэ бол Монгол Улсын хууль. Монгол Улсын хуулийг тэр гаднын хөрөнгө оруулагч хэчнээн том байсан ч биелүүлэх үүрэгтэй. Тэрийг нь сануулах эрхтэй бөгөөд сануулах ёстой газар нь Улсын Их Хурал. Тэгэхлээр энэ тогтоолыг бас энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг шинээр байгуулахгүй байх марагор тавих энэ тогтоолыг бас ойрын хугацаанд дэмжиж гаргана гэж итгэж байгаа. Энэ хуулийг дэмжиж байгаа.

Мөн энэ бирж дээр нүүрс зардаг болох үнэхээр энэ бирж гэдэг ямар ил тод тогтолцоотой байгууллага вэ гэдэг нь, бүтэц вэ гэдэг нь маш тодорхой харагдаж байгаа. Ер нь сум энэ юун дээр Цэрэнпунцаг гарди бүүр дээр яг Чикагогийн түүхий эдийн бирж шиг, эксченж шиг үүнийг байгуулъя гээд бүүр дээр үед ярьж байсан. Энэ яван явсаар үнэхээр ийм дэвшилтэт санаа олон жил болж байж хэрэгждэг юм байна. Тэгээд одоо хэрэгжээд энэ биржээр нүүрс

зарагддаг болсноор нээрээ Монголын нүүрсний үнэ өссөн. Хамгийн гол нь үнэ өсөх өдөр бий, унах өдөр бий. Бүх транзакцууд ил тод болоод, хяналттай болоод тэр авлигын нүх сүв чинь багасаад хаагдаж байгаа нь маш чухал ахиц юм. Энэ дээр Хүрэлбаатар сайд ч, энэ Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны бирж ч гэсэн маш идэвхтэй ажилласан. Үүнийг бас цохоож хэлмээр байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Санал хураалт явуулна. Дамдины Цогтбаатар гишүүн дэмжиж үг хэллээ. Одоо санал хураалт явуулна. Гишүүд үг хэлж дууссан.

Байнгын хорооны саналаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татвараас хөнгөлөх тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулна. Болчихсон уу? Санал хураалт явуулъя. Санал хураалт.

55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гишүүдийн олонх дэмжиж төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Ажлын хэсэг явж болно. Дараагийн асуудалд орно.

15.23 цаг

**Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил танилцуулна.

4 цагт гэсэн 36 минут арай хурдан л явсан байна.

**Ц.Мөнх-Оргил:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 14 дүгээр тогтоолоор хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Пүрэвдорж, Раднаасэд нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Ажлын хэсэг сэжигтнийг хойшлуулишгүйгээр баривчлах үндэслэлүүдийг нарийвчлан тодорхойлж, практикт баривчлах үндэслэлийг субъектив хандлагаар харилцан адилгүй хэрэглэж байгааг нэгмөр зохицуулах хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг хойшлуулишгүйгээр баривчилж болох 3 үндэслэлийг тусгалаа. Мөн хойшлуулишгүйгээр баривчлах ажиллагаанд тавих шүүхийн хяналтыг бэхжүүлж, сэжигтнийг хойшлуулишгүйгээр баривчлах ажиллагаанд прокурор хяналт тавьж, мөрдөгчийн тогтоолыг батлан, шүүхэд даруй хүргүүлэх, эсхүл тогтоолыг үндэслэлгүй гэж үзвэл батлахаас татгалзах тухай шийдвэр гаргах. Мөн хойшлуулишгүйгээр явагдсан баривчлах ажиллагааны үндэслэл үр дүнг хянуулахаар холбогдох материалыг шүүхэд хүргүүлэхээр, сэжигтэн яллагдагчийн шүүхэд хандах эрхийг хамгийн богино хугацаанд шуурхай хангах боломж бүрдүүлэх зорилгын хүрээнд сэжигтнийг хойшлуулишгүйгээр

баривчлах тохиолдолд прокурорын саналыг гэмт хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд хүргүүлэх. Хэрэв баривчлагдсан сэжигтнийг 24 цагийн дотор уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд хүргэх боломжгүй бол баривчлах ажиллагаа явагдсан газрын шүүх хянан шийдвэрлэх зэрэг 15 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргил хуулийн төслийн хэрэгжих хугацаатай холбогдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцэн батлах шаардлагатай талаар зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Сандаг-Очир нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд олонхын санал авсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт

болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийг танилцуулъя.

Максимын Чинбат Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх, Отгонбаярын Мөнхбаатар Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, Батзэвэгийн Энхболд Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн, Ганзоригийн Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Батмөнхийн Батсуурь Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга, Цагдаагийн хурандаа, Дашин Энхтөр Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга, Энэбишийн Бадамсамбуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль, тогтоомжийн хэлтсийн дарга, Шагдарсүрэнгийн Цолмон Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, Лхагвын Данзанноров Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, Доржсүрэнгийн Батсүх Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч асан, өмгөөлөгч.

Одонтуяа гишүүнээр тасаллаа. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууя.

**С.Одонтуяа:** Энэ маш чухал зүйл, заалттай нэмэлт, өөрчлөлт орж ирж байна. Тэгэхээр өнгөрсөн жил миний хувьд энэ хойшлуулигүй баривчилгаа, шүүхийн шийдвэргүй баривчилгаа энэ асуудал дээр бас гишүүнийхээ зүгээс хуулийн төсөл санаачлаад, үүнийг зөвхөн гишүүнийхээ зүгээс өргөн барих уу, эсвэл. Засгийн газар нэгэнт энэ олон хуулийн өөрчлөлтүүд орж ирж байгаа учраас хамтраад хэлэлцэх боломж байсан учраас би энэ 7 удаагийн саналыг Засгийн

газарт хүргүүлсэн байгаа. Тэгээд миний энэ орсон саналууд бол энэ танилцуулга дээр харахад бүгд л орсон харагдаж байна. Ер нь энэ хойшлуулигүй баривчилгаа гэдэг энэ асуудлыг ингээд нарийвчлаад оруулж ирсэн нь одоо маш зөв.

Яагаад гэхлээр манай энэ Эрүүгийн хуулийг хараад байхад их л хуучинсаг засаг заалтууд оршоор л байгаа харагддаг. БНМАУ-ын үед хэрэглэж байсан л Эрүүгийн хуулийн заалтууд их олноороо байдаг. Тэгээд нөгөө коммунист аргаар айлган сүрдүүлдэг. Баривчилгаа гэдэг нь өөрөө хүний сэтгэл зүйд ийм нөлөөлдөг ийм зүйл нь бол ер нь энэ хүмүүсийг баривчилгааны асуудал дээр харагдаад байгаа. Тэгээд л хэн нэгнийг баривчлахад тэрийг нь сошиалаар бөөн шуугиад л нийгмээрээ сенсац болоод л тэр хүн нь бүүр гэмт хэрэгтэн, гэм буруу нь тодорхойгүй байхад гэмт хэрэгтэн мэт харагдаад ийм асуудлууд манайд маш их гарч байгаа. Тийм учраас энэ хойшлуулигүй баривчилгааны асуудлыг цэгцэлж оруулж ирж байгаа нь их зөв.

Ер нь хэлмэгдлийн үед тийм л сэтгэл зүй явж байсан шүү дээ. Хар машинтай, ногоон малгайтай хүмүүс ч шөнө оройн цагаар сүртэй ирээд л баривчилдаг тэр хавийнх нь бүх хүмүүс айдаг сүрддэг ийм зүйл манай баривчилгаа дээр ийм сэтгэл зүй харагддаг. Тэгэхээр бид бол энэ ардчилал хүний эрх дээдэлсэн, ардчилсан Үндсэн хуультай болчихоод энэ хуулийн заалтууд нь өөрөө тэр ийм коммунист үнэр ханхалсан хуулийн заалтуудаа өөрчлөхгүй байгаад байх юм бол энэ хүний эрх чинь зөрчигдсөөр л байх юм. Тэгэхээр энэ өөрчилсөн орж ирж байгаад би баяртай байна. Ер нь 12-16 онд энэ шүүхийн шийдвэргүйгээр баривчилдаг маш олон зүйлийг чинь хойшлуулигүй тохиолдлыг оруулсан байсныг 17 онд шууд л хойшлуулигүй тохиолдол гэдгийг бүгдийг нь шүүхийн шийдвэргүй баривчилгаа руу зүгээр механикаар оруулчихсан байхгүй



юу. Үүнээс болж маш их олон зүйл гарсан.

Тэгэхээр энэ Хүний эрхийн Үндэсний комиссын 22 дугаар илтгэлд нэг тоо хараад би энэ зүйлийг заавал бид нар засах нь зүйтэй юм байна гэж бодсон. Юу вэ гэхээр нийт баривчилсан хүмүүсийн 46 хувийг нь тэр 2 хоногийн дараа юм уу, 3 хоногийн дараа шүүх хуралдаад шаардлагагүй гээд гаргаж байгаа байхгүй юу. Тэгэхээр би бол энэ дээр шаардлагагүй хүмүүсийг бас баривчлаад байдаг юм байна. Ерөөсөө энийг цэгцэл. Ер нь Япон Солонгост байнгын оршин суух хаягтай, байнгын ажилтай хүмүүсийг заавал шөнийн цагаар ирээд л 5 дахь өдөр ирээд л баяр ёслолын үеэр сүржигнээд баривчлаад байх шаардлагагүй л гэж гэж үздэг. Би хоёр юм асуух гэсэн юм.

Энэ цагдан хорих дээр бас олон хоногоор л тэр 461-д л хөөрхий залуучууд олноороо олон сараар байж л байна. Тэгэхээр энэ асуудал цэгцлэгдэж чадсан уу Мөнх-Оргил гишүүнээ? Энэ дээр та хариулт өгөөч. Эсвэл энэ дээр тусдаа заалтууд орох ёстой юу, эсвэл энэ хуулиар бас цэгцэрч байна уу? Би бас энэ саналуудыг харахад цагдан хорихын асуудлууд орсон байна.

Хоёрт энэ гэр бүлийн хүчирхийллийн асуудалд өдөрт 70 дуудлага ирж байгаа шүү дээ. Энэ ерөөсөө буурахгүй байгаа. Тэгэхээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн дээр энэ хойшлуулигүй тохиолдол энэ тэр чинь яаж туссан юм болоо? Энэ 2 асуултыг асуух гэсэн юм.

Цэндийн Мөнх-Оргил ажлын хэсгийн ахлагч. Хууль зүйн байнгын хороо асуултад хариулья.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Одонтуяа гишүүний санаачилж байсан өргөн барьж байсан хуулийн төслийн гол гол санаанууд Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөл бүгд суучихсан

байгаа. Тэр бол суучихсан. Та сая хэллээ. Энэ хуулийн төслөөр Засгийн газар ч гэсэн тэр, манай Хууль зүйн байнгын хороо ч гэсэн тэр энэ баривчлах ажиллагаа дээр нэлээн хязгаарлалт тогтоож өгсөн. Одоо байгаа хуулиар ямар ч гэмт хэрэгт сэжиглэгдэж байсан гэсэн баривчилж байгаа шүү дээ. Энэ хуулиар зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүнийг л баривчилж болно гэж байгаа юм. Зөвхөн. Тэгээд хуучин бол хойшлуулигүй гэдэг тусгай үндэслэл байсныг нэг талаас хасаад, хойшлуулигүй гэдгийг яг юу гэж ойлгох юм бэ гээд гуравхан зүйлээр хязгаарлачихсан. Тэгэхлээр хуучин бол хойшлуулигүй гэдгийг мөрдөгч одоо хойшлуулигүй нөхцөл үүсчихлээ гээд өөрийнхөө үзэмжээр шийддэг байсан бол хуульд хойшлуулигүй гэдгийг яг юу гэж ойлгож байгаа юм бэ гэдгийг нь заагаад өгчихсөн учраас энэ нэлээн багасах байх.

Цагдан хорих дээр та асуулаа. Цагдан хорих дээр ч гэсэн бас нэлээн их хязгаарлалтууд орсон. Одоогийн хуулиар ямар ч гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүн цагдан хоригдож болж байгаа шүү дээ. Энэ хуулиар зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүмүүсийг тодорхой нөхцөл шаардлага хангагдах тохиолдолд цагдан хорино. Тэр нь хэргийн газар дээрээ эсвэл яг оргон зайлсан эсвэл гэрч нь яг хэлж өгсөн яг энэ хүн байсан, ингэсэн гэж шууд газар дээр нь гэрч нь зааж өгсөн, эсвэл хэргийн газар юм уу орон гэр, машин, хувцас дээр нь тухайн хэргийн ул мөр илэрсэн гээд маш ойлгомжтой гуравхан тохиолдлоор цагдан хорихоор болж байгаа.

Дээр нь энэ дээр хорих ял ноогдуулахаар заагаагүй ч гэсэн саяын миний хэлсэн үндэслэлүүд байж байдаг. Тэгээд Монгол Улсад оршин суудаггүй, хаяг нь тодорхойгүй, ахиад тэр хүнтэй холбоо барих нөхцөл бололцоо байхгүй бол тийм хүмүүст цагдан хорих арга

хэмжээ авахаар заасан байгаа. Тэгэхдээ тэр нь дахиад зөвхөн шүүхийн шийдвэрээр энэ дотор бас шинэ том өөрчлөлт орж байгаа. Одоо энэ хуулиараа хууль хэрэгжээд хүчин төгөлдөр явах юм бол 7 хоногийн 7 өдөр 6-22 цагийн хооронд тойргийн журмаар баривчилгааны шүүх цагдан хорихын шүүгч нар тусгайлан ажиллана. Одоо ажлын цагаар ажилладаг учраас прокурор хэндээ очоод хаанаа өгөхөө мэдэхгүй хагас бүтэн сайн өдөр хаалга нүүддэг юм байгаа бол үүнийг 6-22 цаг гэж цэгцэлж байгаа. Тэгэхлээр энэ бол нэлээн шуурхай явагдана. Бүгд бол шүүхийн шийдвэрээр дээр нь шүүхийн бүх хурал ажиллагаа, баривчлах ажиллагаа, анхны байцаалт, шүүх хуралд сэжигтэн, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчид заавал оролцох ямар нэгэн байдлаар оролцох боломжгүй бол томилсон өмгөөлөгч оролцохоор ингээж хуульчилж өгч байгаа. Хугацаа бас багасаж байгаа. Хугацаануудыг 30, 60, 90 гээд багасгачихсан байгаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдуулаад энэ ердийн адил бусад хуулиудтайгаа адилхан л үнэхээр гарцаагүй тэр хүнийг цагдан хорих шаардлага гарах юм бол яг л ердийн журмаар цагдан хорино. Тэрнээс биш энэ хүн яг гэр бүлийн хүчирхийлэл хийчихлээ гээд илүү цагдан хорих юм уу, илүү баривчлах тийм хуулийн зохицуулалт байхгүй. Тэгэхдээ энэ дотор бол.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Одонтуяа гишүүн. Салдангийн Одонтуяа гишүүн тодруулж асууна.

**С.Одонтуяа:** Нэг зүйл тодруулах гэсэн юм. Энэ хар тамхины асуудал дээр хар тамхийг тээвэрлээд оруулж ирж байгаа этгээд тэр хүнийг баривчлах санкц байхгүй учраас баривчлах тэр хэргийг нь хэлэлцээд голицуу Зөрчлийн хуулиар яваад байна уу, яана, ямар байна? Тэр хооронд тэр хүн нь гадаадад гарчхаад олдохгүй байгаа байхгүй юу.

Энэ бол хар тамхи оруулж ирж байгаа иргэд дээр маш их байна гээд би цагдаагийнхантай уулзахад хэлж байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр яаж шийдэх гэж байна? Бид нар гол нь тэр хэрэглэж байгаа хүмүүс гэхээсээ илүү тэр орж ирж худалдаалдаг, наймаалдаг, хилээр оруулж ирдэг хүмүүстэй л тэмцэх гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хүмүүс нь оруулж ирээд, баривчлахгүй учраас хил гараад явчхаж байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр энэ хуулийнхан хариулт өгөөч.

**Г.Занданшатар:** Батаагийн Батцэрэн Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, 80.

**Б.Батцэрэн:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр яг үнэхээр өөрийн эрхшээлд байгаа насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн хэрэг дээр бас зайлиггүй хорих, цагдан хорих үндэслэл байдаг. Түүнээс гадна таны нэр дурдсан тэр хар тамхины хэрэг буюу зохион байгуулалттай гэмт бүлгийн үйл ажиллагаанд хамтран оролцсон хүнийг хувьд мөн цагдан хорих нэг үндэслэл болж байгаа. Үүнийг тэр цагдан хорих үндэслэлд тусгайлан зааж өгсөн.

Тэгэхээр энд гэмт хэрэг үйлдсэн хүнээс гадна энэ гэмт хэргийн гэрч хохирогчийг хамгаалах асуудал давхар хөндөгдөж байгаа. Тэгэхлээр тэр ялангуяа тэр өөрийн эрхшээлд байгаа тэр гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн хүнийг, мөн тэр зохион байгуулалттай гэмт бүлгийн үйл ажиллагаанд нэгдэж үйлдсэн хүний хувьд цагдан хорих нэг үндэслэл болж байгаа. Ер нь зохион байгуулалттай гэмт бүлгийн.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй 15 санал байгаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 2.2 дугаар зүйлийн 10, 11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.Энэ хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тухай прокурорын саналыг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.

11.Энэ хуулийн 31.5 дугаар зүйлд заасны дагуу сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан тухай мөрдөгчийн шийдвэрийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх, хэрэв баривчлагдсан сэжигтнийг 24 цагийн дотор уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд хүргэх боломжгүй бол баривчлах ажиллагаа явагдсан газрын шүүх хянан шийдвэрлэнэ.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил, Норовын Алтанхуяг, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Бөхчулууны Пүрэвдорж, Шадарбалын Раднаасэд. Цаашид Ажлын хэсэг гэнэ. Санал хураалт дөнгөж л хүрэх юм байна.

52.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Баделхан гишүүн ээ Аубакир гишүүн таны үгэнд орж байна уу? Та дуудаач. Хуралдаа суухгүй юм. Таны үгэнд орох нь уу, үгүй юү үзье.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Шүүх энэ хуулийн” гэсний

дараа “14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5 дахь заалт,” гэж нэмж, 3.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 14.10 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “5 хоногийн өмнө” гэснийг “7-оос доошгүй хоногийн өмнө” гэж, 8 дахь хэсгийн “4 хоногийн өмнө” гэснийг “4-өөс доошгүй хоногийн өмнө” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Эрүүгийн нөхцөл байдал хүндэрсэн.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4-ийг уншихаас өмнө гүйцээн боловсруулах чиглэл өгчихье гэж өмнө нь ярьсан. Одонтуяа гишүүн ээ Ганбат гишүүнийг дуудаач. Дашидондогийн Ганбат гишүүнийг. Аан за з. Гол нь Ганбат гишүүн энэ дээр орох ёстой юм байгаа юм. Таны үгэнд орох байх гэсэн чинь.

Цэндийн Мөнх-Оргил гишүүн үг хэлнэ.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллын 4 дүгээр санал дээр эцсийн хэлэлцүүлгийн үед дахин боловсруулах чиглэл авмаар байна дарга. Техникийн ажиллагаа гарсан.

**Г.Занданшатар:** Гүйцээн боловсруулах чиглэл өгч байна 4 дүгээр саналыг.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 17.2 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Прокурор, мөрдөгч яллагдагчид энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан эрх, үүргээс гадна дараах эрхийг тусгайлан танилцуулна:

6.1.тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар мэдээлэл авах;

6.2.прокурорын санал болгосон эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах;

6.3.эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар өөрийн саналыг илэрхийлэх;

6.4.шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээс татгалзах.

7.Прокурор хохирогчид энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг мэдэгдэж, хохирол нөхөн төлөх талаар яллагдагчийн гаргасан санал болон энэ хуулийн Наймдугаар бүлэгт заасан эрх, үүргийг тусгайлан танилцуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ үг найруулга нь харин ёстой гүйцээн боловсруулах юм биш үү. Тусгайлан танилцуулна гэж байна шүү дээ эрх, үүргийг. Тэгээд 6.1 болохоор мэдээлэл авах гэж байгаа юм. Эсвэл татгалзах гээд явчхаж байгаа юм. Тусгайлан танилцуулах гэдэг нь сүүлдээ орж ирж байгаа юм 7 дээрээ. Ингэж заасан эрх, үүргээс гадна дараах эрхийг тусгайлан танилцуулна. Мэдээлэл авах татгалзах эрх, илэрхийлэх эрх, татгалзах эрх. Санал хураалт.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 17.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсгийн “хялбаршуулсан журмаар хянан

шийдвэрлэхгүй” гэснийг “ердийн журмаар хянан шийдвэрлэнэ” гэж тус тус өөрчилж, 17.2 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн “Эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн нь” гэсний дараа “мөрдөн шалгах ажиллагааны явцад” гэж нэмж, 17.2 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 17.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсгийн “хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй” гэснийг “ердийн журмаар хянан шийдвэрлэнэ” гэж тус тус өөрчилж, 17.2 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн “Эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн нь” гэсний дараа “мөрдөн шалгах ажиллагааны явцад” гэж нэмж, 17.2 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 17.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсгийн “хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй” гэснийг “ердийн журмаар хянан шийдвэрлэнэ” гэж тус тус өөрчилж, 17.2 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн “Эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн нь” гэсний дараа “мөрдөн шалгах ажиллагааны явцад” гэж нэмж, 17.2 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ сая хураасан. 7, 6 , 7 тийм тийм. 6 хураачихсан.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 17.3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтын “тохиролцоо хийгдсэн огноо” гэснийг “прокурорын санал танилцуулсан он, сар, өдөр” гэж өөрчилж, 17.3 дугаар зүйлийн 8 дахь

хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Прокурор яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийг харьяалах шүүхэд шилжүүлсэн тухай яллагдагч, хохирогч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинийх яачхав? Энхбаяр сайд хаагуур яваад байна? Эрүүгийн нөхцөл байдал гайгүй болсон уу? Орж ирэнгүүт чинь энэ санал унаж байна шүү дээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. Саранчимэг, Оюунчимэг хоёр.

**М.Оюунчимэг:** Их Хурлын дарга сая би уг нь кнопоо дарсан боловч ажилласангүй. Тийм учраас дахин санал хураалт явуулж өгнө үү гэж хүсэх байна.

**Г.Занданшатар:** Хүчингүй болгох.

**М.Оюунчимэг:** Хүчингүй болгоод дахиад санал хураалт явуулж өгнө үү гэж.

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Баделхан гишүүний Аубакир гишүүн яасан бэ?

9.төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт. Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас 8 дахь санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй гэж үзвэл” гэснийг хасаж, 14.9 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “оргон зайлсан” гэсний өмнө “эсхүл” гэж, 14.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “саналыг үндэслэн” гэсний дараа “шүүх” гэж тус тус нэмж, 14.9 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтын “сүрдүүлсэн” гэснийг “эсхүл сүрдүүлсэн, эсхүл нөлөөлсөн” гэж, 14.9 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтын “1.1, 1.3-т” гэснийг “1.1, 1.2, 1.3-т” гэж тус тус өөрчилж, 14.9 дүгээр зүйлийн 2.3, 2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2.3, 2.4, 2.5 дахь заалт болгох:

“2.3.зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт хамтран оролцсон;

2.4.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

2.5.Монгол Улсад байнга оршин суудаггүй.”. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт.

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 17.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “талууд” гэснийг “прокурор” гэж, “тохиолдолд” гэснийг “үндэслэлээр” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 31.5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“31.5 дугаар зүйл.Сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчлах**

1.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг дараах үндэслэлээр хойшлуулиггүйгээр баривчилж болно:

1.1.гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь, эсхүл гэмт хэрэг үйлдсэн газраас зугтах үед барьсан;

1.2.гэмт хэрэг үйлдсэн даруй гэрч, хохирогч шууд заасан;

1.3.хэргийн газарт болон тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд ул мөр илэрсэн.

2.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол хойшлуулиггүйгээр баривчилж болно:

2.1.хэн болох нь тогтоогдоогүй;

2.2.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

2.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй.

3.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн даруй энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэл бүхий сэжиг тогтоогдвол сэжигтнийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан аль нэг үндэслэлээр хойшлуулиггүйгээр баривчилж болно.

4.Мөрдөгч сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор баривчлах ажиллагаа хуульд нийцсэн эсэхийг хянаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

4.1.мөрдөгчийн шийдвэрийг баталж, шүүхэд даруй хүргүүлэх;

4.2.мөрдөгчийн шийдвэрийг үндэслэлгүй, эсхүл үргэлжлүүлэн баривчлах шаардлагагүй гэж үзвэл батлахаас татгалзаж, тэмдэглэл үйлдэх.

5.Үндэслэлгүйгээр баривчлагдсан сэжигтнийг прокурор даруй суллана.

6.Мөрдөгч энэ хуулийн 30.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлтэй бол хойшлуулиггүйгээр баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналаа сэжигтнийг баривчилснаас хойш прокурорт даруй хүргүүлнэ.

7.Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 6 цагийн дотор баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэнэ.

8.Прокурор сэжигтнийг баривчилсан шийдвэрийг хүчинтэйд тооцуулах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналаа баривчлах хугацаа дуусахаас 24 цагийн өмнө шүүхэд хүргүүлнэ.

9.Шүүх энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан прокурорын саналыг хүлээн авснаас хойш даруй, эсхүл 24 цагийн дотор шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, прокурорын саналыг үндэслэн баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох, яллагдагчид таслан сэргийлэх

арга хэмжээ авах эсэхийг хянан шийдвэрлэнэ.

10.Прокурор, эсхүл баривчлах байрны даргын шийдвэрээр суллагдсан сэжигтэн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд баривчлах ажиллагааны талаар сэжигтнийг суллагдсанаас хойш 10 хоногийн дотор гомдол гаргаж болно. Прокурор гомдол холбогдох материалыг харьяалах шүүхэд даруй хүргүүлнэ.

11.Шүүх энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг хянан шийдвэрлэнэ. Энэ шийдвэрт гомдол гаргахгүй.

12.Энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасны дагуу суллагдсан хүн гомдол гаргаагүй бол холбогдох шийдвэрийг 30 хоногийн дотор харьяалах шүүхэд хүргүүлнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Яах гэж байгаа юм, ямар үг? Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлж болно. Адьшаа гишүүн дэмжихгүй үг хэлнэ, Батжаргал гишүүн хоёр үг хэлнэ. Энхбаяр гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гурван гишүүн. Гурван гишүүнээр тасаллаа.

**Ш.Адьяа:** Энэ сэжигтнийг баривчлахтай холбоотой, прокурорын үйл ажиллагаатай холбоотой, мөрдөх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой энэ асуудал дээр үүнийг дэмжих боломжгүй байгаа юм.

Энэ гомдол гаргах эрхгүй гэсэн ийм зохицуулалт руу орж ирж байгаа. Өнөөдөр энэ аливаа хүний эрх зөрчигдсөн асуудал, тэр хүнийг баривчилсан асуудал, тэр хүний эрхэд халдсан асуудал, гэмт хэрэгтэй холбогдуулан шалгасан асуудал

дээр гомдол гаргахгүйгээр ингэж энэ хуулиар шийдэж байгаа нь цаанаа ямар зорилго агуулж байна? Хүний эрхийг энэ дордуулсан ийм заалтыг энэ хуулиар оруулж болохгүй. Ийм учраас энэ асуудлыг дэмжих тийм боломжгүй байна. Яагаад ийм асуудал л ингэж орж ирж байгаа юм гэдэг дээр их эргэлзэж байгаа учраас энэ заалтыг эсэргүүцэж би дэмжихгүй ийм саналыг өгч байгаа юм.

Яагаад гэхээр өнөөдөр хүний эрхийн асуудал, хүн давж заалдах эрхийн асуудал, ямар хэрэгт сэжиглэгдсэн энэ нь тогтоогдсон, тогтоогдоогүй гэдэг дээр заавал дээд шатын байгууллага, түүнчлэн шүүх эрх мэдлийн байгууллагад энэ хүн хүний эрхийн тухайд, энэ хүний Үндсэн хуулийн эрхийн тухайд зайлиггүй гомдол гаргаж үүнийг шийдэх нь өнөөдрийн энэ хууль, шүүхийн өмнө тэгш байх энэ зарчим ч алдагдаж байгаа учраас үүнийг дэмжихгүй байна.

**Г.Занданшатар:** Дэмжихгүй үг байна лээ. Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Тийм, сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчлах үйл ажиллагааг зохицуулж байгаа харилцаа л даа. Тэр 35.1 дээр болохоор хорих ялтай гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа улсыг ийм 3 үндэслэлээр гээд. 2 дээр нь болохоор зэрэг хорих ялгүй гэмт хэрэгт сэжиглэгдэж байвал 1.3 дээр дахиад нэмээд ийм 3 гэж ингэж хэлж байгаа байхгүй юу. Хорих ялтай улсууд дээр яахаараа сүүлийн 3 нь хамаардаггүй байх билээ? Тийм учраас энд тийм эргэлзээ байна гэж.

Хоёр дахь зүйл нь түрүүн Мөнх-Оргил гишүүнтэй ярилаа. Тэр хаяг тодорхойгүй гээд таслал тавьчхаад байгаа, ард нь эрхэлсэн ажилгүй гэхээр зэрэг өнөө Үндсэн хуулиар заагдсан ялгаварлан гадуурхах үйл ажиллагаа

явагдах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг засах ёстой гэж.

Гурав дахь нь сая тэр гомдолтой холбоотой асуудал байгаа юм. Ийм үндэслэлээр дэмжих боломжгүй л байгаад байна.

**Г.Занданшатар:** Хоёр дэмжихгүй үг хэлсэн. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Энэ ер нь Монгол Улсад шүүхийн хяналтаас гадуур дураараа баривчлаад л, суллаад байдаг гэдэг ийм нийтлэг асуудал яригдаад байдаг. Тэр дотор мөн хорих ял Эрүүгийн хуульд байхгүй, хөнгөн хэргүүд дээр бас хүнийг цагдан хорьж шалгаад байдаг гэдэг ийм 2 асуудлыг цэгцлэх гэж, хүний эрхийн хувьд улам сайжруулж хууль хяналтын байгууллагууд дур зоргоор хүний эрхэд халдаж аливаа төрлийн баривчилгаа хийдэг асуудлыг хязгаарлахын тулд тэр баривчилдаг үндэслэлийг нь тодорхой болгож байгаа юм. Одоо дийлэнхдээ энэ чинь 70, 80 хувь нь хойшлуулиггүй гэдэг үндэслэлээр л бариад байгаа байхгүй юу.

Тэгэхээр хойшлуулиггүй гэдэг бол тухайн хууль сахиулагчийн дур зоргоор тайлбарлагдах ийм үндэслэл байна гэдгээр үүнийг улам тодорхой болгож байгаа юм. Тодорхой болгохдоо хөнгөн хэрэг дээр хүнийг ер нь цагдан хорихгүй.

Өөрөөр хэлбэл, хорих ял Эрүүгийн хуульд бичигдээгүй хэрэг дээр хүнийг ерөөсөө цагдан хорихгүй. Хойшлуулиггүйгээр баривчилж байгаа тохиолдолд бол 3 үндэслэл л байя. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн даруй шууд хохирогч шууд заагаад байгаа юм. Энэ хүн дээрэмдсэн, энэ хүн хулгайлсан, миний машиныг яг хулгайлаад аваад явсан. Ингээд шууд зааж байгаа, гэмт хэргийн үйлдлийн газраас шууд зугтаж байхад нь барьчихсан, эсвэл гэмт хэргийн газарт шууд ул мөр нь үлдчихсэн. Энэ 3 үндэслэлээр шууд хойшлуулиггүйгээр баривчилна шүү. Тэрнээс сураг ажгаар,

үзэмжээр, таамгаар ингээж хүнийг баривчлахгүй шүү гэдгийг тодорхой болгож өгч байгаа юм.

Адьяаа гишүүний хэлсэн тэр асуудал бол Адьяаа гишүүн маань тэр яг эсрэгээр нь сая хэлчихлээ. Та зөвхөн нөгөө хууль чинь ингээж ярьж, зүйл, заалтаар нь уншаад байгаа шүү дээ. Та хамгийн сүүлийнхийг нь уншихаж. Таны уншсан 12 дугаар зүйлийг эшилж байгаа 10 дахь заалтыг нь би уншаад өгчихье. Прокурор эсвэл баривчлах байрны даргын шийдвэрээр суллагдсан сэжигтэн түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд баривчлах ажиллагааны талаар сэжигтнийг суллагдсанаас хойш 10 хоногийн дотор гомдол гаргаж болно. Прокурор гомдолд холбогдох материалыг харьяалах шүүхэд даруй хүргүүлнэ. Өөрөөр хэлбэл тэр гомдол гаргах эрхийг энэ 10 дугаар зүйлд нь биччихсэн байгаад байгаа байхгүй юу.

Тийм учраас та гомдол гаргах эрхгүй байгаад байна гэдэг энэ үндэслэл буруу. Шүүхэд хянагдах нь байна. 12 дугаар зүйл буюу таны саяын уншсан зүйл чинь тэр суллагдсан хүн саяын энэ гомдлоо гаргаагүй бол холбогдох шийдвэрийг 30 хоногийн дотор харьяалах шүүхэд хүргүүлнэ гэж байгаа нь энэ чинь би, намайг 10 жилийн өмнө 1 хоног саатуулж байсан юм гээд гэнэт ухаараад 10 жилийн дараа хүн гомдол гаргаад яваад байж болохгүй шүү дээ. Энэ чинь бас хугацаатай байх ёстой биз дээ? Тэр хугацаа хашилтыг нь хүрээ хязгаарыг нь л хэлж өгсөн заалт байхгүй юу. Тэрнээс биш гомдол гаргах эрхийг нь хязгаарласан тийм зүйл заалт байхгүй. Тийм учраас Адьяаа гишүүн маань суудалдаа эргээж суугаад, одоо саналаа дэмжсэн дээр нь өгөх байх гэж ингээж найдаж байна. Та эсрэг өгөх юм бол эсрэгээрээ гомдол гаргах эрхтэй гэдэг заалтыг нь та дэмжихгүй болчихож байгаа байхгүй юу. Тийм учраас Адьяаа гишүүн маань бас ухаарч, их ухаантай хүн шүү дээ. Бас тийм ухаарч, ойлгож



энэ үйлдлээ залруулах байх гэж бодож байна.

**Г.Занданшатар:** Цэндийн Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энхбаяр сайд ерөнхийд нь тайлбарлачихлаа даа. Адьшаа гишүүн ээ, Батжаргал гишүүн ээ, Энэ заалтыг дэмжихгүй бол бид нарын нөгөө хүний эрхийг хангах гээд байгаа, хойшлуулишгүй баривчлагддаг ажиллагааг хумих гээд байгаа юмнууд чинь хумигдахгүй үлдчих аюултай байгаа юм. Тэр зөвхөн хорих ялтай гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүнийг хойшлуулишгүйгээр баривчилна шүү дээ. Баривчилна. Тэн дотроо хорих ялгүй гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа мөртөө хэн болох нь тогтоогдоогүй, хэн нь мэдэгдэхгүй байгаа байхгүй юу. Бичиг баримт байдаггүй, таньдаг хүн байдаггүй.

Нөгөөдөх нь Монгол Улсад ерөөсөө оршин суудаггүй, тодорхой хаяггүй, эсвэл ажил төрлөөр нь хөөгөөд оччихъё гэхлээр ажил байдаггүй, хаяг байдаггүй, аль аль нь зэрэг хаяг ч байдаггүй, ажил ч байдаггүй. Тэгэхлээр тэр хүнийг яах вэ гээд. Тэгэхлээр тэрэнд баривчлах ажиллагаа хийхээс өөр аргагүй болж байгаа юм. Монгол Улсад байнга оршин суудаггүй энэ тохиолдолд хойшлуулишгүйгээр баривчлаад, шүүхэд материалыг нь танилцуулаад, эсвэл шүүх тэрийг нь дэмжээд явна, эсвэл буруу байна, үндэслэл дутуу байна гэж хэлээд суллана.

Тэр шүүхэд, энэ шийдвэрт гомдол гаргах уу гэдэг нь ийм учиртай юм гишүүд энэ чинь хүн хойшлуулишгүйгээр баривчлагдаад 24 цагийн дотор прокурорын шийдвэрээр суллагдчихсан хүн байгаа байхгүй юу. Суллагдчихсан. Нөгөө хүн чинь шүүхэд гомдол гаргаж байгаа байхгүй юу. Намайг хууль зөрчиж баривчилчихлаа гээд шүүхэд гомдол гаргана. Тэгэхлээр нь прокурор нь материалыг нь шүүхэд өгнө. Шүүх нь

бүрэн хэмжээнд хэлэлцүүлэг явуулаад үндэслэлтэй байж уу, үндэслэлгүй байж уу гэдгийг л хэлэлцэнэ. Энэ дээр дахиад гомдол гаргаад явчихлаар нэг талаас хэрэг сунжраад явчхаж байгаа юм.

Хоёрдугаарт яг шүүхийн гаргаж байгаа шийдвэр чинь өөрийнхөө шийдвэр дээр биш байгаа байхгүй юу. Прокурорын хяначихсан шийдвэр дээр шийдвэр гаргаж байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ дээр дахиж гомдол гаргах шаардлагагүй юм гэж үзэж байгаа юм. Харин 12 дээрээ гомдол гаргаагүй байх юм бол бүх материалуудыг нь, тэр сарынхаа материалуудыг прокурор нь бүгдийг нь хянуулах гээд шүүхэд өгч байгаа. Шүүх нь хянаж байгаа. Ингээд бүхэлдээ Монгол Улсад баривчлах ажиллагаа бүх шатдаа шүүхийн хяналтад орж байгаа. Урьдчилсан хяналтад ч орно, дараа нь баривчилгаа явагдсаны дараа прокурорын шийдвэр гарсны дараа ч гэсэн шүүхийн шийдвэр гарсны дараа ч гэсэн хяналтад орж байгаа ийм шинэ тогтолцоо бий болж байгаа юм.

Тийм учраас гишүүд ээ дэмжиж өгөөрэй. Энэ заалтуудыг бид нар нэгмөр ойлгож шийдвэрлэх гэж ажлын хэсэг 2 сар ажилласан, манай шүүх, прокурор, хүний эрхийнхэн, тагнуул, цагдаа, АТГ-ынхан дэд ажлын хэсэгтээ бид нар 11 удаа хуралдсан. Ажлын хэсэг 3 удаа, 4 удаа хуралдсан, Байнгын хороон дээрээ 2 удаа хэлэлцсэн.

Тэгэхлээр энэ дээр манай хууль хяналтын байгууллагуудын санал энэ хэмжээндээ болох юм байна, хууль хэрэгжих юм байна, хүний эрх талаас хангагдах юм байна. Нөгөө талаас гэмт хэрэгтэй тэмцэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын садаа болохгүй энэ хоёр шаардлага сонирхол тэнцээд явж байна гэдэг дээр санал нийлсэн байгаа шүү.

**Г.Занданшатар:** Үгүй ээ, зөрөөгүй, зөрөөгүй. Тэр чинь тэр юутай чинь. Ер нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар баривчлах ажиллагааг хоёр замаар хийж байгаа. Нэг нь шүүхийн зөвшөөрөлтэйгөөр, нэг нь шүүхийн зөвшөөрөлгүйгээр, хойшлуулиггүй ажиллагааны журмаар гээд. 99 хувь нь шүүхийн зөвшөөрөлгүй гэж байна. Тэрний 60 хувь нь хойшлуулиггүй ажиллагааны журмаар хийгдэж байна гэж үндэслэл тавиад хойшлуулиггүй ажиллагаа гэсэн ганцхан тогтоол дээр үндэслэл бичээд явж байгааг илүү тодорхой болгож зүйл, заалтаар нарийвчлан тусгаж хойшлуулиггүй үндэслэл гэдгийг ямар тохиолдолд ямар зүйлд хамруулах вэ гэдгийг л тусгайлан зааж байгаа заалт шүү дээ тийм ээ? Төсөл дээрээ ч гэсэн ийм үзэл баримтлал нь ингэж орж ирсэн. Үүнийг илүү л тодорхой болгож байгаа заалт гэж ойлголцох юм.

Санал хураалт явуулъя. Гишүүд суудалдаа сууя. Та үг хэлчихсэн. Тайлбарлахгүй, хууль тайлбарлахгүй. Дэмжсэн, дэмжээгүй саналаа л хэлнэ. Ажлын хэсэг гаргасан саналаа тайлбарлаж болно гэж Дэгийн тухай хуульд заасан байгаа. Дэмжих байдлаар үг хэлчхэж байгаа юм. Саналаа дэмжих, дэмжихгүй л үг хэлсэн. Ингээд санал хураалт явуулна. Ухаарч ойлгосон байх гэж найдаж байна. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 4 дүгээр зүйлийн “15.8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч” гэснийг “давж заалдах шатны шүүх” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ ажиллахаа больсон шүү.

53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 4 дүгээр зүйлийн “31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасаж, 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт болгох:

**“5/31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Мөрдөгч сэжигтнийг баривчлах үед түүнийг ямар хэрэгт холбогдуулан баривчилж байгаа талаар мэдэгдэж, энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг сануулна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 4 дүгээр зүйлийн “31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн” гэснийг хасаж, 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт болгох:

**“6/31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэрийг танилцуулсан, эсхүл хойшлуулиггүйгээр баривчилсан тохиолдолд энэ хуулийн 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг танилцуулсан үеэс баривчилсан хугацааг тоолох бөгөөд сэжигтнийг мөрдөн шалгах байгууллагад хүргэх, зайлиггүй эмнэлгийн туслалцаа үзүүлэх, эрүүлжүүлэх, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзахад зарцуулсан хугацааг энэ хуулийн 31.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан хугацаанд оруулан тооцохгүй. Өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах хугацаа 1 цагаас илүүгүй байна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14 дүгээр зүйлийн бас дараа, сая санал хураагдсан. 14 чинь 53.5, хувийн саналаар санал дэмжигдсэн. 15 дээр үү?

15.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарын шилэлийг нийцүүлж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг.

Цэндийн Мөнх-Оргил гишүүн ажлын хэсгийн ахлагч.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн дагуу төслийн 2 дугаар зүйлээр хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад оруулж байгаа нэмэлтийг дахин харах хэрэгтэй болсон юм дарга. Техникийн шаардлага гарсан. Энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл авмаар байна.

Хоёрдугаар зүйл дээр яг ажлын хэсгээс санал оруулаагүй байгаа юм. Тэгэхдээ дахин эцсийн хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулах чиглэл аваад 2 дугаар зүйл дээр энэ 1.1 дээр өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа юм. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг дахин ярих шаардлагатай болсон байгаа юм. Энэ 3 дугаар зүйл дээр нь Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд орох ёстой “зардал мөнгө гарга” гэсэн заалт орчихоод байгаа юм. Үүнийг эцсийн хэлэлцүүлгийн үед хасаад Дагаж мөрдөх журмын тухай хуульдаа оруулах шаардлага гарч байна. Ийм техникийн 2 шаардлага байгаа учраас дахин боловсруулах чиглэл авмаар байна дарга.

**Г.Занданшатар:** Энд хөндөгдөөгүй, уншигдаагүй саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөхгүй. Эцсийн хэлэлцүүлэг дээр Хууль зүйн

байнгын хороон дээрээ хууль тогтоомжийн нийцлийг хангах зорилгоор төслийн бүтэц, нэр томъёо, найруулгыг дэс дараалал, бүлэг, зүйл, хэсэг заалтын дугаар, шилэлүүдийг нийцүүлж өөрчлөх зорилгоор боловсруулалт хийх чиглэлийг өгч байна. Энэ хүрээндээ Байнгын хороон дээрээ авч үзээд. бүүр болохгүй гуравны хоёрроор л Байнгын хороон дээрээ шийднэ дээ. Ингээд гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Тэгэхдээ энэ 15-аар бол хураагдаж байж эцсийн хэлэлцүүлэг явна. Тэгэхээр 15 дахь санал хураалтыг явуулна. Эцсийн хэлэлцүүлэг энд нийцлээ хангах ёстой.

15 дахь санал хураалтыг явуулъя. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаар, шилэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Цогтбаатар дарга суудалдаа суу. Санал хураалт.

62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Энэ Дагаж мөрдөх журмын тухай хууль гарна шүү дээ. Энэ дээрээ саяынхаа юмнуудыг хийгээд хэрэгжих хугацааг нь бас хуулийн бэлтгэл хангахаар бодож хийх хэрэгтэй. Нөгөө иргэний хэрэг чинь 8 сарын 1-наас бил үү, 10 сарын 1-нээс билүү? Дараагийн асуудал.

16.14 цаг

**Арвангурав.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил танилцуулна. Мөнх-Оргил гишүүнийг индэрт урьж байна.

**Ц.Мөнх-Оргил:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн байна.

Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 14 дүгээр тогтоолоор хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Пүрэвдорж, Раднаасэд нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажилласан.

Байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Ажлын хэсэг тусгайлсан журмаар шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах нэхэмжлэлийн төрөл, тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргах, тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд хүсэлт гарган ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжих нөхцөлийг тодорхой болгох, хуулийг дагаж мөрдөх хугацаа зэрэг асуудлуудыг боловсронгуй болгон тусгаж, 1 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асуугаагүй болно.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд олонхын санал авсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Батсүрэнгийн Ундрах Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Ганзоригийн Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Нармандахын

Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Чойжамцын Оюунцэцэг Шүүхийн шийдвэр ерөнхий газрын тэргүүн дэд дарга, Мөнхдэлгэрийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн шинжээч.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Санал хураалт явуулна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. 1 санал байгаа. Хураачихъя.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллын талаар санал хураалт явуулъя.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1, 2 дугаар зүйл болгох:

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай 7 дугаар бүлэг нэмэх. **“ДОЛДУГААР<sup>1</sup> БҮЛЭГ** нэмэх юм байна.

### **“ДОЛДУГААР<sup>1</sup> БҮЛЭГ**

**Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа**

**75<sup>1</sup> дүгээр зүйл. Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг**

75<sup>1</sup>.1. Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин

нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75<sup>1</sup>.1.1. бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах;

75<sup>1</sup>.1.2. дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах;

75<sup>1</sup>.1.3. хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах;

75<sup>1</sup>.1.4. бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах.

75<sup>1</sup>.2. Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75<sup>1</sup>.2.1. шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;

75<sup>1</sup>.2.2. энэ хуулийн 75<sup>1</sup>.1.1-д заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;

75<sup>1</sup>.2.3. ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл.

75<sup>1</sup>.3. Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглоно.

75<sup>1</sup>.4. Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон журмын дагуу шийдвэрлэнэ.

75<sup>1</sup>.5. Гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

**75<sup>2</sup> дугаар зүйл.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх зарчим, хугацаа**

75<sup>2</sup>.1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.

75<sup>2</sup>.2.Зохигч шүүх хуралдаанаас өмнө, энэ бүлэгт заасан хугацааны дотор өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

75<sup>2</sup>.3.Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

75<sup>2</sup>.4.Энэ хуулийн 75<sup>2</sup>.3-т заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

**75<sup>3</sup> дугаар зүйл.Хэрэг үүсгэх, нэхэмжлэл гардуулах**

75<sup>3</sup>.1.Шүүгч энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлага хангагдсан бөгөөд энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

75<sup>3</sup>.2.Энэ хуулийн 75<sup>4</sup> дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, эрх, үүргийн тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77

дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 75<sup>4</sup>.4-т заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсанд тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

75<sup>3</sup>.3.Нэхэмжлэл, хариу тайлбар, хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална.

**75<sup>4</sup> дүгээр зүйл.Мэдэгдэх хуудсыг хүргүүлэх**

75<sup>4</sup>.1.Шүүх энэ хуулийн 77.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол хариуцагч иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар, эсхүл регистрийн дугаарыг мэдээлсэн нэхэмжлэлийн тухайд албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

75<sup>4</sup>.2.Энэ хуулийн 75<sup>4</sup>.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч уг хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний болон хуулийн этгээдийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ.

75<sup>4</sup>.3.Энэ хуулийн 75<sup>4</sup>.2-т заасан цахим шуудангийн хаягаас гадна хариуцагчийн албаны болон хувийн цахим шуудангийн хаягийн мэдээллийг нэхэмжлэлд тусгасан бол эдгээр хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг давхар илгээнэ.

75<sup>4</sup>.4.Энэ хуулийн 75<sup>4</sup>.2, 75<sup>4</sup>.3-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.

**75<sup>5</sup> дугаар зүйл.Хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, гуравдагч этгээд оролцох**

75<sup>5</sup>.1.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэгтгэх, тусгаарлах, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд, хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагч татан оролцуулах ажиллагаа хийгдэхгүй.

75<sup>5</sup>.2.Хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш 7 хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргаж болно.

75<sup>5</sup>.3.Сөрөг нэхэмжлэл энэ хуулийн 73, 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

75<sup>5</sup>.4.Зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.

75<sup>5</sup>.5.Нэхэмжлэгч иргэний хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлага, үндсэн нэхэмжлэлд заасан үндэслэлийн хүрээнд нэхэмжлэлийн шаардлагаа нэг удаа нэмэгдүүлж болно. Нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлснийг хэргийн оролцогчид мэдэгдэнэ.

75<sup>5</sup>.6.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь бие даасан шаардлага

гаргаагүй гуравдагч этгээдээр оролцож болно.

**75<sup>6</sup> дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг**

75<sup>6</sup>.1.Гэрч энэ хуулийн 43.3-т заасан эрх, үүргийг ойлгосны үндсэн дээр үнэн зөв мэдүүлснээ илэрхийлэн, нотариатаар гэрчлүүлсэн мэдүүлгийг шүүхэд ирүүлсэн нь хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75<sup>6</sup>.2.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтай гэрч, шүүгч, зохигч нэгэн зэрэг холбогдон авсан гэрчийн мэдүүлгийг хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75<sup>6</sup>.3.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлсэн нь гэрчийн мэдүүлгийг энэ хуулийн 75<sup>6</sup>.2-т заасны дагуу үнэлэхэд саад болохгүй.

**75<sup>7</sup> дугаар зүйл.Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх**

75<sup>7</sup>.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш дараах нөхцөл байдал тогтоогдвол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ:

75<sup>7</sup>.1.1.нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасныг зөрчсөн;

75<sup>7</sup>.1.2.тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн.

75<sup>7</sup>.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.

**75<sup>7</sup>.3.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс тогтоосон тов ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хүчинтэй хэвээр байна.**

**75<sup>7</sup>.4.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр үргэлжлүүлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолох үндэслэл болохгүй.**

**75<sup>8</sup> дугаар зүйл.Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх**

**75<sup>8</sup>.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш энэ хуулийн 74.1-д заасан үндэслэл бүрдвэл хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэнэ.**

**75<sup>9</sup> дүгээр зүйл.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр**

**75<sup>9</sup>.1.Энэ хуулийн 75<sup>7</sup>.1-д зааснаас бусад тохиолдолд шүүх энэ хуулийн 75<sup>1</sup>.1, 75<sup>1</sup>.2-т заасан шүүх хуралдаанаас шийдвэр гаргана.**

**75<sup>9</sup>.2.Энэ хуулийн 75<sup>9</sup>.1-д заасан шийдвэр нь удиртгал, үндэслэх, тогтоох хэсэгтэй байх бөгөөд үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, шийдвэрийн үндэслэлийн товч агуулгыг дурдана.**

**75<sup>9</sup>.3.Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ хуулийн 75<sup>3</sup>.2-т заасны дагуу зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулна.**

**75<sup>9</sup>.4.Энэ хуулийн 75<sup>9</sup>.2 дахь хэсэг давж заалдах шатны шүүхийн магадлалд нэгэн адил үйлчилнэ. Шийдвэр, магадлалын бүтэц, боловсруулах аргачлалыг Улсын дээд шүүх батална.**

**75<sup>10</sup> дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр нэмэлт хугацаа тогтоох, хуваарь гарган хэсэгчлэн төлөх**

**75<sup>10</sup>.1.Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн, эсхүл хэсэгчлэн хангасан бол хариуцагчийн санхүүгийн байдал, харгалзвал зохих бусад зайлиггүй шалтгаанаар, хариуцагчийн хүсэлтэд үндэслэн шийдвэрийг биелүүлэх нэмэлт хугацаа тогтоох, эсхүл хуваарийн дагуу хэсэгчлэн төлөхөөр шүүхийн шийдвэрт зааж болно. Нэмэлт хугацаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш зургаан сараас илүүгүй байна.**

**75<sup>11</sup> дүгээр зүйл.Давж заалдах гомдол гаргах**

**75<sup>11</sup>.1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75<sup>9</sup>.3-т заасны дагуу гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.**

**75<sup>11</sup>.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.”**

**2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил, Норовын Алтанхуяг, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Бөхчулууны Пүрэвдорж, Шагдарбалын Раднаасэд цаашид ажлын хэсэг.**

Энэ 1 зүйлтэй заалтыг ингэж их дэлгэрүүлж үндсэндээ бараг шинэ хууль бичих хэмжээний бичсэн байгаа бөгөөд энэ маань процессыг хэдийгээр тодотгож байгаа боловч доторх зүйлүүдийг уншиж үзэхэд нь хууль зүйн үр дагавар нь бас эрсдэлтэй байж болох тийм нөхцөлүүд бас үүсгэж байна. И-мэйлээр жишээлбэл, хаяг нь олдохгүй гээд мэйл хүргээд, түүнийгээ хүргэсэнд тооцно, цахим шуудангаар хүргэсэнд тооцно, 6 хоноод л хүргэсэнд тооцно гэх



мэтчилэн энэ журмууд нь бас нарийвчлан үзэх шаардлагатай гэж үзэж байна.

Яагаад гэвэл 1 л зүйлтэй зохицуулалтыг нь бүхэл бүтэн процесс болгочхож байгаа учраас дотор нь алдаа гарвал энэ дээр бас эрсдэлтэй байна. Ер нь бас энэ шүүхийн практикт шүүхийн шийдвэр биелдэггүй нэг асуудлууд бол энэ Иргэний хэрэг маргаан шийдвэрлэх тухай д хөрөнгийг урьдчилж битүүмжилдэггүй. Ингээд давж заалдаж явсаар явсаар байгаад нөгөө үнэ, бүх хөрөнгөө зувчуулдаг юм уу, зуугуулдаг юм уу, алга болоод шүүхийн шийдвэр дээр баахан хэрэгждэггүй шүүхийн шийдвэр байгаад байдаг гэх мэтчилэн асуудлууд байдаг гэх мэтийн асуудлууд байдаг. Нэгэнтээ ингээд дэлгэрүүлж байгаа бол үүнийг хууль зүйн техникийн хувьд байна шүү дээ Мягмар даргаа та хэд нарийвчлан сайн үзээд, эцэслэн батлахад үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өгчихнө. Энийг 3 хуудас юмыг нэг дор уншаад санал хураалт явуулахад бас, санал хураачхаад гүйцээн боловсруулах чиглэл өгнө гэж байхгүй л дээ. Энэ чинь 1 зүйл болоод байна л даа. Хууль зүйн газар энийг нарийвчилж үзсэн үү?

Цэндийн Мөнх-Оргил гишүүн үг хэлнэ.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Их Хурлын дарга гишүүдээсээ уучлалт хүсэж байна. Энэ зүйл маань 4 хуудас дүүрэн 1 санал хураалт болчихоод байгаа юм. Энэ бол бид нар олж задлаад, зүйл зүйлээр нь санал хураалгаад явчихъя гээд олон талаас нь нэлээн үзсэн юм. Тэгээд болохгүй байгаа юм. Энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд тусгай шинэ процесс орж байгаа. Хялбаршуулсан журмаар гээд. Тэр процесст ердийн журмаар явдаг шат дамжлагуудыг ямар нэгэн байдлаар заавал тусгах хэрэгтэй болчихоод байгаа юм. Жишээ нь хэзээ давж заалдах юм, хэдэн хоногийн дотор давж заалдах юм, юун дээр нь давж заалдаж болох юм гэх мэтээр

процессжуулах, нарийвчлах гарцаагүй шаардлага бий болчихоод байгаа юм.

Яагаад гэвэл энэ дандаа хөрөнгө, мөнгөтэй холбоотой нарийн асуудлууд учраас. Энэ томъёоллыг бичих гэж бид нар бас сар гаруй болсон. Энэ дээр Дээд шүүх, Дээд шүүхийн иргэний танхимын тэргүүн шүүгч Алтанчимэг, Баярмаа шүүгч, Нийслэлээс Нийслэлийн тэргүүн шүүгч, Ерөнхий шүүгч Даваадорж, дүүргийн шүүгч нар, манай иргэний хэргийн иргэний эрх зүйн урдаа барьдаг мэргэжилтнүүд, Хууль зүй, дотоод хэргийнхэн гээд бүгдээрээ сууж байгаад ийм томъёолол дээр хүрч байгаа юм дарга. Энэ томъёолсноор хэдий дэгийн хувьд хүндрэлтэй ч гэсэн энэ томъёолсноороо бид нар батлаад явчих юм бол шүүхийн ачаалал огцом буурна. 12 сая төгрөгөөс доош хүнтэй хэргүүд, дээр нь шүүхийн шийдвэртэй хэргүүд маш хурдавчилсан журмаар асуудлууд нь шийдэгдээд, иргэд ч гэсэн шүүхийн сунжирсан удаан процессоор явахгүй шүүх ч гэсэн ажлын ачааллаа багасгах их ач холбогдолтой хуулийг Засгийн газар өргөн мэдүүлсэн байгаа юм.

Тийм учраас бид нар Засгийн газар өргөн мэдүүлснийг зарчмын хувьд ерөөсөө өөрчлөөгүй. Зүгээр процессжуулсан заалтууд л нэмсэн байгаа юм. Тийм учраас Их Хурлын гишүүдээс үүнийг нэгэнт бид нар уншихсан юм чинь дэмжээд өгчхөөч ээ. Энд нэлээн бөөсийг нь түүсэн, дээд шүүхийнхэнтэй нэлээн их ажилласан заалтууд байгаа шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

**Г.Занданшатар:** Ер нь процессжуулах шаардлагатай гээд ойлгож байна. Энэ процесс хийх гэж байна гэж харагдаж байна. Гэхдээ энд чинь агуулгын заалтууд ороод байна. 75.2 энэ тэр дээр шүүхийн шийдвэрийн нэхэмжлэлийн. Дээр нь ер нь манай энэ хуулиуд процесс дутуу учраас хүндрэлтэй байдгийг ойлгож ингэж процессжуулах нь зөв байх. Тэгэхдээ 1 амьсгаагаар энийг

санал хураалт явуулахад хоорондоо, 1 саналыг 4 хуудас болгоод санал хураахад 1 цохилтоор шийдэж болохгүй. Ядаж хяналтын шат давуулна.

Тийм учраас Хууль зүй, дотоод хэргийн сайд ч гэсэн энэ дээр бас яам талаасаа энэ хяналтаа хийж үзэх хэрэгтэй. Хууль зүйн газар энэ дээр бас хяналт хийж үзэх хэрэгтэй. Яагаад гэвэл энэ процессоос гадна агуулга дотор нь орчихоод байна л даа. Дан процесс байсан бол одоо дүүрч гэхэд. Ийм учраас гүйцээн боловсруулах чиглэл өгч, дахин хяналт хийгээд Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд, Тамгын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам хянаад оруулж ирье.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг. Энэ чинь харин унагаахгүй, бүүр гүйцээн боловсруулах чиглэл өгч байгаа нь сайн хэрэг шүү дээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна. Нэг хэлэлцүүлэг хийчихлээ гэсэн үг шүү дээ. Түүнээс биш анхны хэлэлцүүлэгт буцааж болох байсан юм шүү. Дараагийн асуудалд орно.

16.35 цаг

**“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын

хороо 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасан журмын дагуу “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно. Байнгын хорооны хуралдаанаар “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Цогтбаатар даргаа энэ чинь нөгөөдөх чинь үү? Төсвийн байнгын хорооных. Яг ингээж явуулна шүү дээ. Та ойлгож байна

уу? Нөгөө засвараа яг ингээд явуулчих байсан шүү дээ. Ойлгов уу?

“Байнгын хорооны саналаар тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Тогтоолын төсөл батлагдлаа. 58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хүүш энэ чинь 15 асуудал явчихсан байна шүү дээ өнөөдөр. Дараагийн асуудалд оръё

16.38 цаг

**Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох, чөлөөлөх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Намжилдоржийн Энхбаяр, Жамсрандоржийн Дэлгэрсайхан, Нинжбатын Ууганбаатар, Амаржаргалын Энхбат, Равсалын Ринчинбазар, Лхагважавын Гангэрэл, Ланганы Отгонтуяа нар нь Төсвийн байнгын хорооны 2023 оны 16 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа

бүрдүүлж Байнгын хороонд ирүүлсэн болно.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нартай хийсэн нэр дэвшигчийн сонсголыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16<sup>1</sup> дүгээр зүйлийн 16<sup>1</sup>.4.5.Төсвийн байнгын хороо нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29, 30, 31 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-127 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулах гэж заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулах үе шатыг баримтлан дараах ажиллагааг явуулав.

2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” Байнгын хорооны тогтоолыг баталж, 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар миний бие томилогдон ажилласан болно.

2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 10 цагт Нийтийн сонсголын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт Улсын Их Хурлаас зохион байгуулах нэр дэвшигчийн сонсголд тухайн асуудал эрхэлсэн Байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь оролцох гэж заасны дагуу Төсвийн байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь буюу Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин, Баделхан, Батжаргал, Батсуурь, Даваасүрэн, Одонтуяа, Пүрэвдорж, Раднаасэд, Сандаг-Очир, Чойжилсүрэн нар Байнгын хорооны сонсголд хүрэлцэн

ирж, ирц бүрэлдэж нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд сонсголд оролцсон гишүүд сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана. Тайланд сонсголын дүнг үндэслэн тухайн нэр дэвшигч нь албан тушаалд тавигдсан шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусган тухайн тайланг ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигч, түүний санал болгосон этгээдэд хүргүүлж, Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна гэж заасны дагуу 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр сонсголын тайланг дэмжсэнийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Намжилдоржийн Энхбаяр, Жамсрандоржийн Дэлгэрсайхан, Нинжбатын Ууганбаатар, Амаржаргалын Энхбат, Равсалын Ринчинбазар, Лхагважавын Гангэрэл, Ланганы Отгонтуяа нарыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Нэр дэвшигчийн танилцуулга, Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно. Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолын нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн

гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтаар Улсын Их Хурлаас томилдог болсонтой холбогдуулан бүрэн эрхийн хугацаа нь дууссан Далрайн Даваасамбуу, Эрдэнийн Бямбажав, Баярсайханы Баярдаваа, Атарбаатарын Энхжин, Ланганы Отгонтуяа, Дамирангийн Сувдаа, Гүнсэнгийн Алтанзаяа нарыг Төсвийн байнгын хорооны 2018 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн орон тооны бус гишүүнээс бас чөлөөлөгдөж байгаа болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтолцоо байдлын зөвлөлийн гишүүнээр томилох асуудлаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлт болон эрх бүхий албан тушаалтнаас, саналаас нь асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? 3 гишүүнээр тасаллаа. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүнээр тасаллаа, нэмэхгүй. Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Тэгэхээр бас Улсын Их Хурал дээр аятайхан эерэг мэдээнүүд, эерэг өөрчлөлтүүд гарч эхэлж байна. Энэ ялангуяа төсвийн асуудал дээр энэ дээр их баяртай байна. Энэ нэр дэвшиж байгаа хүмүүсийн хувьд надад ярих юм алга. Би сэтгэл өндөр байна. Яагаад гэхлээр бүгд л манай улсын тэргүүлэх эдийн засагчид байна. Гадаад, дотоодын нарийн мэргэжлийн сургуульд сурсан, төсөв санхүүг мэдэхийн дээдээр л мэддэг ийм хүмүүс байгаа. Би нэг зүйлийг л асууя. Бүгдээс нь асуух боломжгүй учраас гол мэддэг Энхбаяр нэр дэвшигчээс асуучихъя даа.

Энэ төсөв батлах явцад Их Хурлын гишүүн ч тэр эргэж тэр маш сэтгэл хангалуун бус байсан юм. Яагаад гэхээр Засгийн газар нэг юм оруулж ирдэг тэрийг нь Улсын Их Хурал баахан өөрчилдөг, сүүлдээ арай дээрдээд Засгийн газар оруулж ирснийг нь тоог нь нэмэхгүйгээр дотор нь баахан бантагнуулдаг, тойрог болгон руугаа төсөв чирдэг. Тэгээд энэ нь ямар ч тийм хүн амын тоонд нь харьцуулсан, үр ашигт харьцуулсан индексжүүлсэн юм байхгүй. Жишээлэхэд ямар гомдол гардаг вэ гэхээр Хэнтийд энэ улсын хамаг төсөв тавигдчихлаа, тэр аймагт хамгийн бага тавигдчихлаа гээд л жишээлэхэд ярьдаг. Зарим газар бол огт сургуульгүй хороо байхад, зарим газар олон сургууль байна ч гэдэг юм уу ингээд ийм яг Монгол улсын хөгжлийн, урт хугацааны ийм зүйлүүд бол шийдэгдэж чаддаггүй байсан. Үүнийг бол бүгд л мэдэж байгаа.

Тэгэхээр одоо та бүгд энэ төсвийг өргөн барихаас нь өмнө үзэж шинжлэх юм байна, саналаа өгөх юм байна, түүний дараагаар төсөв өргөн баригдах юм байна гэж би ойлголоо. Тэгэхээр энэ мэргэжилтнүүд ажилласан төсөв өргөн баригдана гэдэг бол нэг том алхам байх. Тэгэхээр та бүхэн яг хараат бус ажиллаж чадах уу гэдэг дээр л бид нар их санаа зовж байгаа юм. Энэ замбараагүй байдлыг өөрчилж чадах уу? Энэ яг хүн амынх нь тэр төвлөрөлд тааруулсан, хүн амын хөгжилд нь тааруулсан Монгол Улсын тэргүүлэх эдийн засгийн гол гол дэд бүтэц ямар байдаг юм, энэ чиглэлүүдэд энэ хөрөнгө оруулалтыг нь чиглүүлэх энэ бүх зүйлүүдийг бас хийж чадах уу? Төсвийн тогтвортой байдлын хууль гэж байна. Төсвийн хүрээний мэдэгдэл байна гэж байна. Өө дуртай цагтаа л, дуртай өдрөө л өөрчилдөг шүү дээ. Нэг нам олонх болчихсон бүүр санаа амар. Тэгэхээр энэ бүх зүйл дээр ямар ахиц, дэвшил гарах вэ гэдгийг иргэдэд болон энэ гишүүдэд сайхан тайлбарлаад өгөөч гэж хүсэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл хуучин энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд бас хэрэндээ сайн ажиллаж байсан л даа. Даваасамбуу гуай байна, Бямбажав гуай байна. Үгүй ээ энэ чинь болохгүй ээ энэ ийм байх ёстой гээд. Үгүй ээ тэрийг нь сонсож байгаа ч хүн алга, тэрийг нь төсөвтөө тусгаж байгаа ч газар байхгүй тэгээд л тэрнийхээ эсрэг л батлагддаг шүү дээ. Манай Ардчилсан намынхан л сөрөг хүч болохоор өө яг энэ зөв байна, та нар зөв юмыг нь олж харсан байна гээд л тэрнээс цааш хэтэрдэггүй.

Тэгэхээр энэ бүх зүйл замбараагүй, энэ төсвийн замбараагүй шийдлийг яаж өөрчилж чадах юм бэ гэдгийг хүмүүсийн итгэл төгс төртөл сайхан тайлбарлаад өгөөч л гэж хүсэж байна. Би зүгээр жишээ авсан юм.

**Г.Занданшатар:** Энхбаяр, 82.

**Н.Энхбаяр:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа гишүүний тавьсан асуултад хариулъя.

Жил болгон Улсын Их Хурлын чуулганаар Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, төсвийн тодотгол, төсвийн гүйцэтгэл гээд үндсэндээ төсвийн тухай холбогдолтой асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар 4 удаа хэлэлцэж байна. Төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйл та бүхэн сайн мэдэж байгаа Монгол Улсын төсвийн тухай хууль тогтоомж нь өөрөө ганцхан хууль биш, энэ бол Төсвийн тухай хууль тогтоомж маань Үндсэн хууль болон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль гээд багц асуудлууд байгаа.

Тэгэхээр энэ төсвийг цаашдаа тогтвортой байлгах асуудал маань ганцхан байгууллагын үүрэг биш, угаасаа хуулийн институцийнхээ чиг үүргээр хамгийн гол нь энэ төсвийг батлах чиг үүрэгтэй мэдэж Улсын Их Хурал бол

үүн дээр хамгийн гол чухал үүрэгтэй. Энэ дотроо Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ Улсын Их Хурлыг төсвийг чанартай, үндэслэлтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй батлан боловсруулж хэлэлцүүлэхэд туслах чиг үүрэгтэй ийм бүтэц байгаа юм. 2010 онд анх баталсан Төсвийн тогтвортой байдлын хуульдаа бид анх энэ функцийг оруулсан. Өнгөрсөн арван гурав, дөрвөн жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засгийн бүтцэд хамгийн гол нь маш том өөрчлөлт орсон 2008, 2009 он хүртэл уул уурхайн салбарын эзлэхүүн манай дотоодын нийт бүтээгдэхүүний дөнгөж 10 орчим хүрэхгүй хувьтай байсан бол өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүний 20 гаруй хувь, экспортын 90 гаруй хувийг эзэлж байгаа, 94 орчим хувь. Тэгэхээр үүнээс хамаарсан төсвийн ийм савлагаатай байдлууд байж байгаа. Энэ бол бодит нөхцөл нь.

Тэгэхээр бид нар төсвийг тогтвортой байлгана гэдэг маань зөвхөн төсвийг боловсруулсан тоон үзүүлэлт дээр ажиллахаас гадна тэр савлагааг үүсгэж байгаа үндсэн шалтгаан байгаа. Гадаад худалдааны савлагаа. Монгол улсын экспортын 2023 оны гүйцэтгэлээр 57 хувь нь зөвхөн нүүрсний экспортоос бүрдэж байна. Өнгөрсөн арван гурав, дөрвөн жилд эдийн засгийг савлуулж байгаа гол шалтгаан өөрөө энэ нүүрсний экспортын тоо хэмжээ болон үнийн өөрчлөлтөөс ихээхэн хамаарч байгаа. Жил болгон нүүрс зөвхөн нүүрсний үнийн энэ савлагаанаас хамаараад экспортын орлого 1 тэрбум доллароор дээшээ, доошоо савлаж байсан.

Тэгэхээр энэ 23 онд бид 65 сая тонн нүүрс экспортод гаргаад 7.8 тэрбум доллар орлого олчихоод байна. Энэ амжилтыг хэрвээ бататгаж чадахгүй бол дахиад л энэ савлагаа маань цаашидаа улам их савлана гэсэн үг. Энэ Төсвийн тогтвортой байдлын хуульд орсон өнгөрсөн онд баталсан энэ оноос мөрдөж байгаа нэмэлт, өөрчлөлтийн дагуу Төсвийн тогтвортой байдлын

зөвлөл шинээр гүйцэтгэх ёстой нэг үүрэг бол төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад болон жил болгоны төсвийн төслийг боловсруулахын өмнө макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг хараат бусаар боловсруулах чиг үүрэг байгаа. Тэгэхээр энэ чиг үүрэг дээр энэ өнөөдөр томилогдохоор нэр дэвшээд байгаа хүмүүс маань хамтран баг болж ажиллана. Мөн Төсвийн байнгын хорооны дэргэд төсвийн шинжилгээний институт байгаа. Энэ баг маань ажиллана. Үүнээс гадна Монгол Улсад энэ яг төсөв мөнгөний бодлогын холбоотой яг макро эдийн засгийн тооцоолол хийж байгаа 2 чухал институт байна. Монголбанк, Засгийн газар, Сангийн яам.

Тэгэхээр эдгээр институтууд тус бүрдээ макро эдийн засгийн тооцоолол хийж байгаа. Тэгэхээр энэ Засгийн газар, Монголбанк Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо гэсэн энэ 3 байгууллага энэ макро эдийн засгийн тооцоолол дээрээ тооцоо, судалгаагаа үндэслэлтэй хийх, харилцан ойлголцох, ялангуяа ашиглаж байгаа загвар маань яг ирэх жилүүдийн энэ тулгамдаж байгаа асуудлуудыг зөв гаргалгааг нь гаргаж чадах загвар мөн үү гэдэг дээр бид нар улам сайжруулах шаардлага байгаа. Одоогийн энэ загвар маань яг бүрэн төгс нийцчихсэн загвар гэж хэлэхэд бас учир дутагдалтай. Үндсэн загвар маань дотоодын нийт бүтээгдэхүүний загвар. Үүний зэрэгцээ инфляц, гадаад худалдаа гээд, төлбөрийн тэнцэл гээд бус бусад олон үзүүлэлтийг тооцож байгаа загварууд байгаа.

Тэгэхээр энэ болгон дээрээ бид нар хамгийн сүүлийн түүхий эдээр тулгуурласан улс орнуудад эдийн засгийн төсөөллийг оновчтой боловсруулахад чиглэж байгаа энэ загварыг бид нар цаашидаа авчирч ихэсгэх шаардлагатай. Үүн дээр мэдээж нөгөө бусад Чили болон Сингапур бусад улсын жишгээр бүхий л засаглалын энэ нөгөө сайн засаглалын

институц маань л маш чухал гэж хариулахыг хүсэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Маш чухал ажлын нэг үр дүн гарч байна гэж би бодож байна. Яагаад гэвэл Улсын Их Хурал 2023 оны 7 дугаар сард 33 гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Тэмүүлэн даргаар ахлаад ажлын хэсэг гараад, хуулийн төслийг санаачлаад өргөн барьж байсан. Өнөөдөр яг үүний үр дүн гарч Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн мэргэжлийн гишүүд орж ирж байна. Бид нарын гол тавьж байгаа зорилго бол засаг дээр юм уу, Засгийн газар дээр төсвийг багцлаад оруулаад ирдэг. Оруулаад ирсний дараа сая гишүүдийн яриад байгаа шиг яг хаана улс орны хөгжлийн бодлого, хүн амын хөгжил, тэр нягтаршил хаана юу хэрэгтэй байна гэх мэт төсвийн мэдрэмжтэй, ухаалаг хуваарилалтыг хийж чаддаггүйгээс болоод өнөөдөр жишээлбэл түгжрэл, энэ утаа униар гээд нийгмийн эрүүл мэнд чиглэл дээр, боловсрол дээр ч гэдэг юм уу асар том гажуудлууд гарчхаад байна шүү дээ.

Тийм учраас бидний энэ төсвийн шинэчлэлийн хүрээнд өнөөдөр бий болж байгаа та нарын маань гол зорилго одоо яг төсөв, төсвийн өмнө энэ макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдээр судалгаа хийгээд та нарын гаргасан эдийн засгийн хөгжил энэ дээр бид 2025 оны төсөв илүү их анхаарах ёстой юм байна. Энэ дээр бид нэлээд хэмнэлт хийх бололцоотой юм байна гэх мэтээр маш чухал үзүүлэлтэд судалгаа гаргаад, тэр судалгаан дээр чинь Эдийн засгийн хөгжлийн яам эд нар дээр нь нөгөө Сангийн яам маань яриад Засгийн газар бодитой, ухаалаг, зөв төсвийн төслийг оруулж ирээд Их Хурал нь тэрийгээ хэлэлцээд гаргаж байвал бид өнөөдөр ёстой нөгөө төсвийн тогтвортой байдал, энэ төсөв алдагдалгүй батлах, энэ өр гээд бүх асуудлыг шийдэх бололцоо уг нь бүрдэх

учиртай. Ийм том найдлага хүлээлгэж өнөөдөр бид нар мэргэжлийн хүмүүсийг энэ томилж байгаа шүү. Бүгдийг нь дэмжиж байгаа. Энэ дотор Дэлгэрсайхан багш, манай Энхбаяр эдийн засагч маань, Ринчинбазар гуай гээд мундаг хүмүүс маань орж ирсэн байна.

Би нэг зүйлийг бүүр илүү их хүсдэг байхгүй юу. Юу гэхээр сүүлийн энэ 30 жилд бид нар төсвийн мэдрэмжтэй хуваарилалт хийж чадаагүйгээс болоод асар их алдагдал, өнөөдрийн энэ бүх гажууд л үүнээс үүдэлтэй байгаа. Өнөөдөр та бүхэн харж байгаа байх нэг өдөр түгжрэл үүслээ гээд л нэг, хоёр хүн бухимдангуут хотын дарга маань асуудлаа хийж байх хооронд Боловсролын сайд нь салбартайгаа ярихгүйгээр шууд боловсролоо хүртэл хаагаад явчхаж байгаа байхгүй юу. Өнөөдөр хүүхдүүд нь хичээлээ ч цахимаар хөдөө, орон нутгийн хүүхдүүд, гэр хорооллын хүүхдүүд цахимаар хичээллэж чадахгүй, хичээл, сургууль дээрээ очоод хоол ундаа идээд бас аль аль талаасаа үр ашигтай нийгмийн талаасаа ч, эдийн засгийн талаасаа ч байсан ингээд хүндрэлд ороод байна.

Хүүхэд хамгааллын хууль дээр ингэж болохгүй гэдэг заалт оруулаад өгөөч гээд өнөөдөр эцэг эхчүүд бидэнд хандаад бас ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ юу вэ гэхээр бид нарт ямар ч юм төлөвлөлт юмыг өмнө нь хийж, судалгаан дээр хийж бас хэлэлцэж байж энэ асуудал нь ярьж шийдэгддэг байхгүй ингээд нэг л хэсэг бүлгээр ярьж байгаад юм уу, эсвэл сэтгэлийн хөдөлгөөнөөр, эсвэл ямар байдаг юм нэг юмыг шийдэхийн тулд нөгөө салбараа бусдыг хохироож байдаг ч гэдэг юм уу ийм гажуудал үнэхээр олон жил явж ирсэн. Энэ өнөөдөр манай улсыг өөдлөхгүй болоход хүргээд байна шүү дээ.

Тийм учраас өнөөдөр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань энэ төсвийн шинэчлэлийн хуулийн хүрээнд орж ирээд ажилдаа орох гэж байна. Та

бүхэн сая бас би л Төсвийн байнгын хорооны даргатай ярьж байхад Цэцийн гишүүний түвшний эрх мэдэлтэй Улсын Их Хурлаас томилогдож байгаа гээд маш бас нэлээд өндөр статустай, бас эрх мэдэлтэй, орон тоотой, төсөвтэй, хөрөнгө, цалин хөлстэй гээд бас ингээд бололцоогоор ажиллах нөхцөлөөр та бүхнийгээ хангахыг Улсын Их Хурлаас ингэж зорьсон.

Тэгэхээр та бүхэн маань хичээж маш сайн ажиллаарай гэж хэлмээр байна. Би Дэлгэрсайхан багшаас ганцхан зүйл асуучихъя. Одоо бид нар төсөв мөнгөний бодлогыг уялдуулж байж л бидний өмнөө тавьсан энэ зорилгууд биелнэ гээд бараг 20, 30 жил ярьж байна. Одоо хүртэл сая ипотекийн зээл энэ орон сууц хөтөлбөр дээр төсөв мөнгөний бодлогыг уяад энэ дээр бид тусгасан гэсэн хэр нь мөнгөний бодлого дээр заалт нь байдаг, төсөв батлах болохоор нөгөө заалт нь байхгүй. Энэ хэрэгжих ч юм уу, үгүй ч юм уу ийм зүйлүүд байгаад байгаа юм. Тэгэхээр та бүхэн маань үүн дээр жишээлбэл яаж цаашидаа ажиллах ёстой вэ Дэлгэрсайхан багш аа, зөвлөлийн гишүүн ээ та энэ дээр бас хариулт өгөөч гэж хэлмээр байна.

**Г.Занданшатар:** 84,  
Дэлгэрсайхан.

**Г.Дэлгэрсайхан:** Баярлалаа. Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллаж байгаад талархаж байна. Гол нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс төсөв, мөнгөний бодлогын уялдаа гэдэг бидний анхаарах гол асуудлын нэг бай болох байх болно гэдгийг би хувь хүнийхээ зүгээс хэлмээр байна.

Учир нь өнөөдөр Монгол Улсад төсөв, мөнгөний бодлогын хоорондын тэнцвэр алдагдсан. Зарим талаар төсөв

нь өөрөө хэтэрхий түрүүлж мөнгөний бодлого нь түүнд хөтлөгдөж явдгаас болоод макро эдийн засгийн гол зорилгыг, тэр зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг гэдэгтэй би хувьдаа санал нэг байдаг.

Гэхдээ төсөв, мөнгөний бодлогын уялдаа гэдэг үгээс илүү би хувьдаа төсөв, мөнгөний бодлогын зөв хослолыг бид хэрэгжүүлж байх ёстой юм байна гэж ойлгодог. Тийм учраас би хэрвээ энд сонгогдоод ажиллавал миний зүгээс хийх энэ Төсвийн тогтвортой байдлын Зөвлөлийн багийн гишүүдтэйгээ хийх гол ажлуудын нэг нь Монгол Улсын төсвийн бодлого өөрөө Монгол Улсын хөгжлийн бодлого, Үндсэн хуулийн үзэл баримтлал, язгуур эрх ашиг гэсэн тэр урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцтэй байхын тулд ямар байх ёстой вэ гэдэг тэр үндсэн загварыг гаргаж тэр загварын хүрээнд л Монгол Улсын төсвийн төлөвлөлтийг явуулахыг хичээх нь бидний гол ажлын нэг байх. Хэрвээ төсөв нь өөрөө тэр яг үндсэн суурь макро эдийн засгийн зорилго руугаа чиглэхсэн байж чадвал мөнгөний бодлого өөрөө эдийн засгийг дэмжих тэр орон зайгаа олж аваад мөнгөний бодлого тэнд чөлөөтэй өөрөө өөрийн бодлогын хувилбаруудыг хэрэгжүүлэх ийм боломж үүсэх байх. Тэрнээс төсөв, мөнгөний бодлого бие даасан тусдаа бодлогууд болохынхоо хувьд нэг нэгнээсээ хараат бус, хоёулаа Монгол улсын хөгжлийн бодлого, макро эдийн засгийн зорилт руу чиглэсэн ийм байдлаар хэрэгжээсэй гэж би хувьдаа хүсдэг.

Тийм учраас бидний зүгээс хийх гол ажлууд төсөв, мөнгөний бодлогын зөв хослолтой байж байж төсөв хэт тэлсэн, төрийн оролцоо хэт өндөртэй энэ төсвөөр яваад, хэт өндөр алдагдалтай төсвөөр яваад бид өнөөдөр гарсан үр дүнгээ нэгэнт харж байгаа тул энэхүү төсвийн бодлогыг зөв чиглэлд чиглүүлснээрээ мөнгөний бодлогод чөлөөтэй орон зайг бий болгож макро эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг



хэрэгжүүлэх тэр нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ажиллах нь бидний гол зорилт байх гэж үзэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Оюунчимэг гишүүн тодруулж асууя. 1 минут.

**М.Оюунчимэг:** Энэ төсвийн шинэчлэлийн хуулийн төслийг санаачилсан 33 гишүүний нэг нь би байгаа юм. Төсвийн байнгын хорооны дарга энэ гишүүд маань бүх салбарынхандаа маш удаан нарийн хэлэлцүүлгүүд энэ дээр хийсэн. Ер нь ийм олон улсын жишиг ийм зөвлөл байх нь чухал юм байна гэж үзэж өнөөдөр үр дүн нь гараад явж байна. Та бүхнийг бас дэмжигдээд, сонгогдоод явбал сайн ажиллаарай гэж хүсэхээр байна.

Ингээд өмнө бас тэр Даваасамбуу гуай өмнө нь зөвлөлийн гишүүд зарим тохиолдолд нөгөө сайд нар сонсохгүй ч юм уу, яг салбарын хүмүүс нь сонсохгүй болохоор бид нарт та нар маань үүнийг маш сайн уншаад бас аваарай, энэ ийм учиртай байгаа юм шүү, энэ асуудлын судалгаа нь ингэж гарсан, олон улсад ийм байгаа юм гээд анализ, дүгнэлт хийчихсэн судалгаануудыг бид нарт бас их өгдөг. Тэрэнд бас уншиж судлаад бусад зүйлүүдтэйгээ харьцуулаад, асуудалд нухацтай хандахад их хэрэг болдог юм. Тийм учраас би бас энэ тал дээрээ хэрвээ та бүхэн маань дэмжигдээд явбал анхаарч ажиллаарай гэж хүсэх байна. Баярлалаа, амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Үг хэлье. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Д.Өнөрболор:** Эдийн засагт энэ төсвийн бодлого бол маш чухал үүрэг гүйцэтгэнэ. Тэгэхээр энэ үр ашиггүй зардлын тэлэлт, төсвийн тогтворгүй байдал энэ эдийн засагт олон талын сөрөг үр дагаврыг бол авчирч ирсэн. Тэгэхлээр өнгөрсөн хугацаанд энэ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл

жил бүр байнга өөрчлөгддөг. Үүнийгээ дагаад бол бас энэ дагуулж татварын болон суурь энэ хуулиуд өөрчлөгддөг. Энэ нь эдийн засагт оролцогч талуудыг бол маш ойлгомжгүй, тодорхойгүй байдлыг үүсгэдэг. Ийм явж ирсэн. Энэ Төсвийн хуульд бол энэ шинэчлэлийн шинжтэй бол маш их чухал ийм нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан. Үүний нэг гол өөрчлөлт нь бол энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл.

Тэгэхлээр энэ яг би яг бүгдээс нь уул нь асуумаар л байна. Ер нь энэ яг энэ төсвийн энэ шинэчлэл, нэн ялангуяа энэ манай Монгол Улсын энэ татварын шинэчлэл, энэ цогц шинэчлэлтэй холбоотойгоор ер нь энэ асуудал дээр өнөөгийн яг энэ цаг үед авах арга хэмжээнүүд яг юу гэж авч үзэж байна? Би нэр дэвшигчдээс бас энэ байр суурийг нь энэ тал дээр сонсмоор байна.

Нөгөөтээгүүр энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд орж ажилласнаар энэ төсвийг тогтвортой ер нь байлгах эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийг бий болгох тал дээр, ядуурлын бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тал дээр нэн тэргүүнд яг ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх ийм байр суурьтай байна вэ гэдгийг бас асууя. Гишүүд бүгдээрээ л илэрхийлж хэлж байна. Миний хувьд ч гэсэн энэ ажлын хэсэгт орж ажиллахдаа бол хамгийн гол нь энэ улс төрийн энэ шийдвэрээс ангид, бие даасан энэ хараат байдлаа энэ зөвлөл маань хангах асуудал бол хамгийн чухал асуудал гэж бол байр сууриа илэрхийлээд байгаа юм.

Яагаад гэхлээр энэ олон нийтийн өмнө ер нь та бүгд бараг шүгэл үлээгч болох ёстой. Тэгэхлээр энэ эрх хэмжээ томорч байгаагийн хэрээр бас хариуцлага нэмэгдэж байгаа. Энэ агуулгаараа та бүгд маань яг энэ бие даасан, хараат бус яг энэ тал дээр дээрээ яг энэ байр сууриа яг яаж

хамгаалж, хангах вэ гэдэг тал дээр та бүгдээс бас асууя.

**Г.Занданишатар:** Бүх хүнээс асууж байгаа юм уу? 80-аас эхлээд 81, 82, 83, 84, 85, 86, 87 гээд дараалаад товч, товч 1 минут өгчих.

**А.Энхбат:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Энхбат гэдэг Монгол улсын их сургуулийн багш.

Би өмнө нь Одонтуяа гишүүн, Оюунчимэг гишүүдийн асуулт сая бас Өнөрболор гишүүний асуултыг базаад ерөнхийдөө бодлого чиглэлийнх нь төсвийн хүрээнд хийх бод шинэчлэлийн хүрээнд хийх бодлого чиглэлийнх нь хувьд хураангуйлаад миний барьж байгаа байр суурийг товчхон танилцуулъя.

Ерөнхийдөө манай улс өнгөрсөн энэ төсвийн шинэчлэлийн асуудал бол их урт хугацаанд явагдаж байгаа зүйл. Цаашидаа ч энэ шинэчлэл бодлогын хүрээнд төсвийн шинэчлэлийн асуудал хийгдэж үргэлжилж явна гэж харж байгаа. Түүний нэг илрэл нь өнөөдөр энэ хараат бус Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг бий болгож байгаа байдал бол нэг илрэл гэж харж байгаа. Цаашидаа, ерөнхийдөө энэ түрүүн тэр орон нутгийн түвшинд хөрөнгө оруулалтыг бий болгох, мөн хүн амын нягтаршил.../минут дуусав./

**Г.Занданишатар:** 81.

**Р.Ринчинбазар:** Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Товчхон ярих учраас би тэр хараат бус гэдэг дээр ганцхан зүйлийг л хэлье дээ. Тэгэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн санал, дүгнэлт, зөвлөмж судалгааг бол онолын хувьд Улсын Их Хурал хүлээж авахгүй байх боломжтой, боломжтой. Гэхдээ хэрвээ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл мэргэжлийн үүднээс ажиллаад шинэчлэх ухааны үндэслэлтэй судалгаа, тооцоотой тийм дүгнэлтүүдийг гаргах юм бол бид

тэрийгээ Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Их Хуралд тавих ёстой. Тэр бидний хийсэн ажлын үр дүнгээс бас хамаарна. Чанар сайтай, сайн үр дүн гаргах юм бол Их Хурал тэрийг бас ойлгож дэмжих бас талтай. Би бол ингэж л бодож байна.

**Г.Занданишатар:** 83.

**Н.Энхбаяр:** Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Мэдээж цаг бага байгаа учраас би хоёрхон зүйл дээр хариулъя гэж бодож байна. Монгол Улсын эдийн засгийг савлуулж байгаа хамгийн том хүчин зүйл түүхий эдийн худалдаа байна. Нийт экспортын 94-97 хувийг эзэлж байгаа. Тэгэхээр түүхий эдийн худалдаан дээр бид нар гадаад худалдааны бодлогоо зөв тодорхойлж явах юм бол энэ дээр савлагааг багасгах маш сайн боломжтой. Энэ дээр бид нар олон улсын жишигт хэрэглэж байгаа оновчлол гэдэг аргыг бид нар ялангуяа манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бид нар бас хийх бололцоотой гэж үзэж байгаа. Ямар хэмжээний түүхий эдийг ямар үнээр гаргах вэ гэдэг хувилбарыг бид нар тооцоолон гаргах боломжтой. Монгол улс маань ганц зах зээлд цөөхөн нэр төрлийн бүтээгдэхүүн гаргаж байгаа ийм онцлогтой.

Хоёрдугаарт хараат бус байхын тухайд нэгэнт одоогийн чиг үүргээрээ Монголбанк, Сангийн яам макро эдийн засгийн төсөөллөө хийж байгаа. Тэгэхээр эдгээр байгууллагатай ч гэсэн адилхан энэ макро эдийн засгийн загвар дээр бид нар өөрсдийн гэсэн боловсруулсан загвар дээрээ харилцан санал солилцох, зөрүүтэй зүйл дээрээ учир шалтгаанаа тайлбарлах, аль болохоор илүү үндэслэл сайтай загвар дээрээ санал нэгдэж ажиллах.

**Л.Гангэрэл:** Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Бусад гишүүд маань нэмээд санал хэлэлгүй яах вэ. Миний хувьд нэг юуг хэлье. Энэ Төсвийн

тогтвортой байдлын зөвлөл ингээд шинээр өөрчлөн байгуулагдсанаар олон нийтэд төсвийг зохиохоос өгсүүлээд төсвийг батлах хүртэлх хугацаанд олон нийтэд хөндлөнгийн хараат бус байдлаар олон нийтэд мэдээллийг өгөх асуудал асар их чухал байгаа. Энэ тал дээр бас манай энэ тогтвортой байдлын зөвлөлд хуульдаа ч бас нэлээн эрх өгчихсөн байж байгаа. Энэ чиглэлдээ бас илүү түлхүү ажиллана л гэж бодож байна.

**Ж.Дэлгэрсайхан:** Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Багцлаад хариулчихъя. Би энэ зөвлөлийг Улсын Их Хурлаас томилогдож байгаа хараат бус мэргэжлийн зөвлөл гэж ойлгож байгаа учраас хараат бус байдлаар бид судалгаа, шинжилгээний ажилд суурилсан Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, хууль, эрх зүйн орчинд нийцсэн, тийм маш хүчтэй, баталгаатай тийм судалгаанд үндэслэсэн зөвлөмж, чиглэлүүдийг Улсын Их Хурал болон Засгийн газарт хүргүүлэх замаар энэ төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, төсвийн хууль, эрх зүйн орчны нөхцөл байдалд тохирсон хуулийг дээдэлсэн тийм төсвийн хэрэгжилтийн төлөө ажиллах болно гэж хэлмээр байна. Баярлалаа.

**Л.Отгонтуяа:** Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Ер нь дэлхий нийтэд хийгдэж байгаа сүүлийн 100 гаруй жилийн туршид хийгдэж байгаа төсвийн шинэчлэл бол төсвийн нэгдсэн сахилга батыг хангах, байгаа боломжит нөөцдөө багтааж бид төсвийн хязгаарлалтынхаа хүрээнд багтааж төсвөө зарцуулах ёстой. Хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлдээ нийцүүлж төсвөө үндэслэлтэй зөв хуваарилан төлөвлөх ёстой. Түүнчлэн төсвийн байгууллагууд төсвийн зарлагаа үр ашигтай, үр дүнтэй зарцуулж үйлчилгээгээ үзүүлдэг байхад чиглэж ажиллах ёстой.

Тэгэхлээр эндээс үр дүнд чиглэсэн дунд хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлд

суурилсан төсөвлөлтийг бид нэвтрүүлэхэд илүү ба чиглэж үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллана.

Хараат бус байхын тухайд бид судалгаа, нотолгоонд суурилсан төсвийг төсвийн төсөлдөө судалгаа, нотолгоонд тулгуурласан дүгнэлт гаргаж, зөвлөмж өгөөд иргэд олон нийтдээ үүнийг танилцуулж ажиллах болно гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

**Н.Ууганбаатар:** Гишүүний асуултад товчхон хариулъя. Судалгаа, шинжлэх ухаан ер нь бол зөвийн талд, үнэний талд зогсох ёстой. Зөв болон үнэн гэсэн тийм эзэнтэй. Үүнийхээ талд зогсох байх. Шүгэл үлээх шаардлага гарахгүй болов уу гэж найдаж байна. Ямар нөхцөл яаж гарах юм, цаашаа юу болохыг бол урдаас хэлэхэд бол хэцүү. Татварын бодлогыг яаж нийгэм эдийн засагтаа илүү үр ашигтай болгох вэ энэ дээр ямар реформ санал болгох вэ гэсэн иймэрхүү асуулт асууж байх шиг байна. Үүн дээр нарийн судалгаанууд хийгдэх ёстой. Тодорхой хэмжээний урьдчилсан судалгаа хийгдсэн байгаа. Манай татварын систем дээр үр ашгийг нэмэгдүүлэх шаардлага бол нэлээн харагдаж байсан. Төсвийн тухайд бол орлого тал нь нэлээн либерал бүтэцтэй, зарлага тал нь нэлээн халамжийн бүтэцтэй ийм хайчин дунд байгаа ийм төсөв. Үүн дээр л бүгдээрээ л ажиллах байх даа.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалтад бэлтгэе. Нууц санал хураалтад бэлтгэнэ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108.2-т заасны дагуу нэгдсэн хуралдаан эрх бүхий албан тушаалтны санал холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсоод, нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх саналыг

дэмжсэн энэ тухай тогтоол батлагдсанд тооцно гэж заасан. Энэ дагуу нууцаар санал хураалт явуулна. Нууц санал хураалтын бэлтгэлийг хангая. Болчихсон уу? Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Санал хураалт. Санал хураалтад бэлэн үү?

Байнгын хорооны саналаар Намжилдоржийн Энхбаярыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна.

24 гишүүн дэмжиж, 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Жамсрандоржийн Дэлгэрсайханыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нинжбатын Ууганбаатарыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураана. Санал хураалт.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нинжбатын Ууганбаатарыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт. Нинжбатын Ууганбаатарыг хураачихсан.

Амаржаргалын Энхбатыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцсон.

Амаржаргалын Энхбатыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Равсалын Ринчинбазарыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ланганы Отгонтуяаг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Бага ярьцаая, бага шуугьцаая. Пүүжээ суудалдаа суу, санал хураалт. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Миний дэмжээд байгаа Ринчинбазар гуайд би дөнгөж сая монгол бичгээр биччихсэн гар бичмэлээ дурасгаж явж байгаад санал хураалтад орж чадсангүй. Та үүнийг хүчингүй болгож өгөөч гэсэн.

**Г.Занданшатар:** Дарчхаад бас тэгсэн бол энэ чинь хэн эсрэг санал өгснийг нь би яаж мэдэх юм. Одоо ахиж санал хураалт явуулахгүй шүү. Яагаад гэвэл энэ нууц санал хураалт учраас хэн эсрэг өгснийг мэдэх бололцоогүй. Сүүлийн удаа санууллаа.

Ингээд Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар энэ саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Тийм, горимоо солихгүйгээр явуулчих даа. Санал хураалт. Горимоо сольчихсон.

Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналыг 58.5 хувиар дэмжиж, өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас Ланганы Отгонтуяаг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор дахиж санал хураалтыг нууцаар явуулъя.

58.5 хувийн саналаар.

Санал хураалт, Лхагважавын Гангэрэлийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураана. Санал хураалт.

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Томилох саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцдог. Тогтоолыг унишиж танилцуулъя.

“Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилох” тухай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16<sup>1</sup> дүгээр зүйлийн 16<sup>1</sup> 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр Лхагважавын Гангэрэл, Жамсрандоржийн Дэлгэрсайхан, Ланганы Отгонтуяа, Равсалын Ринцинбазар, Нинжбатын

Ууганбаатар, Амаржаргалын Энхбат, Намжилдоржийн Энхбаяр нарыг томилсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Оюунчимэг гишүүн суудалдаа суу.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр сонгогдсон та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж бас ажлын амжилт хүсье.

Улсын Их Хурлаас бүхий л салбарт олон шинэчлэлийг хэрэгжүүлж байгаа. Үүний хоёр тод илрэл нь өнөөдөр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийг нууц санал хураалтаар томилж байгаа явдал. Өмнө нь Улсын Их Хурлаас томилдог, сонгодог албан тушаалтнуудыг Улсын Их Хурлын дарга Байнгын хороо, чуулганд танилцуулаад томилчихдог байсан. Одоо бол дандаа нээлттэй сонсголоор, нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгон шалгаруулаад нээлттэй сонсгол хийгээд Улсын Их Хурлын чуулганаар нууц санал хураалтаар томилдог болсон. Энэ бол гишүүдийн та бүхний яриад байгаа тэр бие даасан хараат бус байдлыг хангаж байгаа. Эхнээсээ институцийн тогтвортой байдлыг хангаж байгаа ийм шинэчлэлийг бүхий л салбарт хэрэгжүүлсэн.

Улсын Их Хурлаас томилдог бүхий л албан тушаалтнууд дандаа нээлттэй сонсголоор томилогддог болсон. Үүний зэрэгцээ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлагдаж, энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд өндөр ач холбогдол өгч байгаа. Тийм учраас та бүхэнд онцгой анхаарах чиглэл өгч байгаа. Манай энэ Ууганбаатар доктор бас энэ татварын реформын математик загварчлал дээр ажиллаж байгаа.

Татварын ашиг тус, үр ашгийн талаар математик загварчлалаар судалгаа, шинжилгээ ч хийж байгаа. Татварын цогц реформыг хэрэгжүүлнэ. Сангийн сайд сайн тусалж дэмжих хэрэгтэй. Та бүхэн зөвхөн төсөв орж ирэхээр л ажиллах улсууд биш. Байнгын өндөр цалин хангамжийг бид бас баталсан.

Тэгэхээр байнгын энэ ажил нэгдүгээрт энэ төсвийн реформ, нэгдүгээрт төсвийн зарлагын реформ, төсвийн зарлагын реформ дотроо энэ нийтийн санхүүгийн реформ, энэ сангуудын реформ. Энэ сангууд дээр ямар их хулгай зэлгий, хяналт шалгалт алдагдаж төсвийн мөнгө үр ашиггүй зарцуулагдаж байгаа, төсвийн сахилга бат хангалтгүй байгааг зөвхөн тоон судалгааны хувьд төдийгүй бусад чанарын болон тоон судалгаан дээр үндэслэж судалгаа, нотолгоо дээр суурилсан шийдвэр гаргаж Улсын Их Хурлыг шийдвэр гаргах боломжоор хангаж энэ шинэчлэл реформын суурь нь та бүхэн болно.

Хоёрдугаарт нь энэ төсвийн зарлагын реформоос гадна төсвийн зарлага одоо Ганбат доктор хэлж байна. Халамжийн шинж чанартай болсны зэрэгцээ үрэлгэн, үр ашиг багатай хавтгайрсан энэ нийтийн санхүүгийн реформ хийх зайлигүй шаардлага байгаа. Нөгөө талаас татварын реформ хийх хэрэгтэй. Татварын реформ шударга өрсөлдөөний зарчмыг хангаж чадахгүй байгаа. Шулуухан хэлэхэд. Хүн амын орлогын албан татвараар 700 мянган төгрөгийн цалин авч байгаа, сая төгрөгийн цалин авч байгаа үйлчлэгч, төрийн албан хаагч хэн ч бай төр, хувийн хэвшилд ажиллаж байгаа хүн 10 хувийн татвар төлж байгаа. Тэгэхэд 1.5 тэрбум төгрөгийн орлоготой хүн 1 хувийн татвар төлж байгаа жишээтэй.

Ингээд цаашилаад НӨАТ, импортын татвар, манай энэ татварын тогтолцоо бүхэлдээ гажуудалд орсон. Ийм учраас татварын реформ хийж

байж үндэсний үйлдвэрлэлийг сэргээх, энэ эдийн засгийн сэргэлтийг хийх энэ улс төрийн тогтолцооны реформ хийсэн, энэ нийгмийн тогтолцооны реформууд хийгдэж байгаа, энэ сахилга хариуцлагыг сайжруулж байгаа энэ бүх реформын эцсийн үр дүн баялгийн сангийн реформ энэний нөхцөл болох ёстой. Бас АМНАТ-ын тооллогыг бид нар хийх ажлын хэсэг байгуулж байгаа. Ажиллуулж эхэлсэн. АМНАТ, татвар энэ бүх маань тэгш шударга байх энэ бололцоог бүрдүүлэх шаардлага байгаа юм.

Ийм учраас Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хамгийн гол нь Засгийн газраас хараат бус байж, төсвийн үр ашгийг хангахад чиглэгдэж байгаа ийм институт. Ийм учраас энэ чиглэлээр та бүхэн судалгаа, тооцоогоо чиглүүлж, Төсвийн байнгын хорооны хэрэгжүүлж байгаа энэ төсвийн реформ, татварын реформ, нийтийн санхүү, төрийн санхүү, нийтийн санхүүгийн реформын ажилд судалгаа, нотолгоо, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангаж дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэгтэй шүү гэдгийг онцлон тэмдэглэж хэлж байна.

Та бүхний ажилд өндөр амжилт хүсье. Монгол Улсын, манай уур уурхайн бүтээгдэхүүний үнэ ханиш гайгүй байгаа, тогтвортой байгаа энэ үед манай төсвийн орлого 548 тэрбум төгрөгөөр давж биелж, тогтворжуулалтын сан 1.6 их наяд хүрсэн ч гэсэн дан дандаа ийм байхгүй. Үнэ ханишаас хамааралтай энэ эдийн засгийг төрөлжүүлэх, солонгоруулах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, үүнтэй татварын бодлого, санхүүгийн бодлого, мөнгө зээлийн бодлого бүгд уялдах шаардлагатай ийм торгон үе шүү гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт хүсье. Төсвийн байнгын хороотойгоо хамтарч Төсвийн байнгын хороон дээр татварын реформ, нийтийн санхүүгийн

реформын ажлын хэсэг байгуулагдсан ажиллаж байгаа Эдийн засгийн байнгын хороо. Энэ дээр хамтарч ажиллах хэрэгтэй. Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дарга бас идэвхтэй ажиллах хэрэгтэй.

Ингээд тогтоол батлагдсан. Амжилт хүсье. Та бүхэнд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

17.15 цаг

Дараагийн асуудалд орно. Асуудлаа хэлчихье. Эрхэм гишүүд ээ явж болохгүй шүү.

**“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Хаалттай хуралдааны горимд.

17.20 цаг.

Нээлттэй горимд шилжив.

17.42 цаг.

**Г.Занданишатар:** Маргааш хууль эцэслэн батлахад гишүүд сайд нар ирц сайн байна шүү. Өглөө 10 цагаас 150 хууль эцэслэн батална 39-өөр. Гишүүд байж байгаад нээлттэй горимд шилжихээр гарах ёстой. 2 минутын дараа нээлттэй горимд шилжихээр.

Эрхэм гишүүд ээ, энэ чинь нээлттэй горимд шилжсэн үү?

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашгийн менежментийг сайжруулах болон аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай Улсын Их Хурлын тогтоолуудын нэгтгэсэн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Гүйцээн

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

17.43 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР